



МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/607

Улаанбаатар хот

Технологийн үйл ажиллагааны
үлгэрчилсэн загвар мөрдүүлэх тухай

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалтыг үндэслэн галт тэргэнд техникийн үйлчилгээ хийх технологийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. “Галт тэрэг, вагонд техникийн үзлэг, үйлчилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан зааврыг хэрэгжүүлэн, одоо мөрдөгдөж байгаа технологийн үйл ажиллагааг шинэчлэн сайжруулж, батлан мөрдүүлэх ажлыг 2024 онд багтаан хэрэгжүүлэхийг Вагоны аж ахуйн албаны дарга (Л.Болд)-д даалгасугай.

3. “Галт тэрэг, вагонд техникийн үзлэг, үйлчилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ыг Замын нэгдсэн технологийн үйл ажиллагааны бичиг баримтуудад тусгахыг Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар)-д даалгасугай.

4. Улаанбаатар төмөр замын даргын 2012 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А-137 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

5. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Замын ерөнхий инженерийн орлогч (Ч.Мөнхцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601243584

“УБТЗ” ХНН-ийн даргын 2024 оны 07 дугаар сарын
08-ны өдрийн А/607 дугаар тушаалын хавсралт



Галт тэрэг,вагонд техникийн үзлэг, үйлчилгээ хийх үлгэрчилсэн технологийн загвар

ЗӨВШӨӨРСӨН: РБ

НТП

НБТ

Д

В

Л

ВОХР

ХЯНАСАН: РБв

ВГ

ВИст

БОЛОВСРУУЛСАН: ВР

ВУР-1

ВУР-2

ВЧДГ-3

ВЧДИт-3

М.ЦОГТ

С.МӨНХ-АЛДАР

А.ЭНХ-АМГАЛАН

Ц.АРИУНБОЛД

Л.БОЛД

Д.ПҮРЭВСҮРЭН

Ц.АРИУНБАТ

Ц.ТҮМЭНДЭЛГЭР

Б.ДОРЖБАТ

Ш.ГАНЗОРИГ

А.ПҮРЭВБААТАР

С.АЛДАРМАНДАХ

Б.ЖАМСРАН

С.БЭХБААТАР

Г.БАЛДАНДОРЖ

2024 ОН

Гарчиг

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
Товчилсон нэр томъёоны тодорхойлолт.....	4
НЭГ:ВАГОНЫ ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАРЫН ТӨРӨЛ АНГИЛАЛ	7
1.1. Хөдөлгөөн дундах үзлэг хийх нөхцөл:	7
1.2. Галт тэргэнд техникийн бүрэн үзлэг хийх нөхцөл:	7
1.3. Галт тэргэнд техникийн хяналтын үзлэг хийх нөхцөл.....	8
1.4. Техникийн ачилтын үзлэг хийх нөхцөл:	8
1.5. Гүүшингийн халуун үзлэг хийх нөхцөл:.....	8
1.6. Урсгал засвар хийх нөхцөл:	8
1.7. Төлөвлөгөөт бус урсгал засвар хийх нөхцөл:	8
1.8. Галт тэрэгний аюулгүй байдлыг хангах баталгаат хэсэглэл	8
ХОЁР: АЧААНЫ ГАЛТ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	9
2.1. Ачааны галт тэргийг техникийн үзлэгт авах дараалал, ажилбар	9
2.1.1. Техникийн үзлэгт авах:	9
2.1.2. Өртөөнд ирсэн галт тэрэг.....	10
2.1.3. Өртөөнөөс явах галт тэрэг	10
2.1.4. Дахин ажиллагаатай галт тэрэг	11
2.1.5. Шууд болон дамжин өнгөрөх галт тэрэг	11
2.1.6. Замын ашигтай уртад багтаагүй галт тэрэг.....	12
2.2. Техникийн үзлэг засвар хийгдэх галт тэргийг хамгаалалтад авах хамгаалалт буулгах.....	13
2.3. Ачааны галт тэргэнд техникийн үзлэг, үйлчилгээ хийх аргачлал.....	13
2.3.1. Хөдөлгөөн дундах үзлэг /ХДҮ/.....	13
2.3.2. Ачааны галт тэрэг, бүрэлдэхүүнд үзлэг хийх замнал	14
2.3.3. Ачааны вагонд техникийн үзлэг хийх байрлал	16
2.3.4. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэг.....	17
2.3.5. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний вагонд Техникийн үзлэг үйлчилгээ, техникийн ачилтын үзлэгийг хамтатган хийж гүйцэтгэх технологийн горим	19
2.3.6. Өртөөнөөс явах ачааны галт тэрэг	21
2.3.7. Техникийн ачилтын үзлэг /Цаашид “ТАҮ” гэх/ хийх технологийн горим...	22
Техникийн ачилтын хоёрлосон үзлэг	23
Вагон үзэгчгүй өртөөнд ачилтад вагон бэлтгэх	23
2.3.8. Завсрын өртөөнд дуудлагаар ажиллах	24

2.3.9. Хилийн төмөр замууд дээрх галт тэрэг солилцооны технологи.....	24
2.3.12.Замын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын аж ахуйн галт тэргэнд ажиллах	24
2.3.13.Техникийн үзлэг хийснээс хойш хүлээгдэж байгаа галт тэрэг	25
2.3.14.Өндөр, нам тавцантай замд техникийн үзлэг хийгдэх галт тэрэг	25
2.3.15.Ачааны галт тэргэнд үзлэг хийх үед хийгдэх засварын ажлын технологийн хугацаа.....	26
2.3.16. Галт тэрэгний сүүлийн вагоны дохио, бэхэлгээг авах, тавих, хяналт тавих ажиллагаа	26
2.3.17.Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн болон товчилсон туршилтын технологи горим	26
2.3.17.5.Тоормосын бүрэн туршилт.....	27
2.3.11.4.Тоормосын товчилсон туршилт	35
2.3.11.5.Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг нэг вагон үзэгч гүйцэтгэх	39
2.3.11.6.Хийн суурин төхөөрөмжөөр бүрэлдэхүүнд тоормосын туршилт хийх ..	42
ГУРАВ: ЗОРЧИГЧИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ	45
3.4.Зорчигчийн галт тэргэнд ХДҮ хийх	45
3.5.Зорчигчийн галт тэргэнд техникийн үзлэг хийх замнал.....	45
3.6.Зорчигчийн вагонд техникийн үзлэг хийх байрлал	47
3.6.2.Техникийн бүрэн үзлэг /цаашид “ТБҮ” гэх/ хийх технологийн горим	48
3.6.3.Техникийн хяналтын үзлэг /Цаашид “ТХҮ” гэх/ хийх технологийн горим...	49
3.7.Зорчигчийн галт тэргэний вагонд тавигдах техникийн нэмэлт шаардлага ..	52
3.8. Зорчигчийн галт тэрэгний тоормосын бүрэн болон товчилсон туршилтын технологи горим	52
3.8.5.Тоормосын товчилсон туршилт	55
ДӨРӨВ.САЛГАЛТТАЙ УРСГАЛ ЗАСВАР	58
ТАВ.ГТХАБ-ТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ	58
ЗУРГАА.АЧААНЫ ВАГОН ПАРКИЙГ ӨВӨЛ, ЗУНЫ ТЭЭВЭРТ БЭЛТГЭХ ҮЗЛЭГ ЗАСВАР	58
ДОЛОО.СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН БУУРШГҮЙ НӨӨЦИЙГ ТОГТООХ, СЭЛБЭГИЙН ХАЙРЦАГ БАЙРЛУУЛАХ.....	61
НАЙМ.ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ	61

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү технологийн үлгэрчилсэн загвараар УБТЗ ХНН-ийн Вагоны аж ахуйн албаны ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг депо, түүний харъяа вагон засварын газар, техник үйлчилгээний газар, техник үйлчилгээний хэсэг бүхий өртөө, хэсгийн өртөө, зөрлөгүүдэд ачаа, зорчигч, ачаа зорчигчийн галт тэрэгний вагонд хийх техникийн болон вагоныг ачилтад бэлтгэх үзлэг үйлчилгээ, вагоны бүрэн бүтэн байдлыг хангах ажиллагаа, засварын ажлын хэмжээ, дараалал, зохион байгуулалт болон галт тэргийг бэлтгэх нормт хугацааг тогтооно.

Энэхүү технологийн үлгэрчилсэн загвар нь УБТЗ-ын Нэгдсэн технологийн горимын салшгүй хэсэг бөгөөд Вагоны аж ахуйн албаны ашиглалт, вагон засварын чиглэлийн ажлыг зохицуулахад оршино.

Галт тэрэг, вагонд техникийн үзлэг үйлчилгээ /ТБҮ, ТҮХ/ хийх технологи хугацааг ТҮГ, ТҮХ-т хийгдсэн судалгааны ажлын үр дүнгээс гарсан бодит хугацаагаар тооцож гаргасан болно.

Товчилсон нэр томъёоны тодорхойлолт

УБТЗ-Улаанбаатар төмөр зам

МТЗ-Монголын төмөр зам

ОТЗ-Оросын төмөр зам

ХТЗ-Хятадын төмөр зам

БГТЗ-Баянгол төмөр зам

ХХВЭ-Хувийн хэвшлийн болон түрээсийн вагон эзэмшигч

ВЧД-3-Вагон ашиглалтын депо (телеграфын товчилсон нэр ВЧД-3)

ВЧД-1-Зүүнхараа дах ачааны вагон засварын депо (телеграфын товчилсон нэр ВЧД-1)

ТҮГ-Техник үйлчилгээний газар (телеграфын товчилсон нэр ПТО)

“Техник үйлчилгээний газар” гэж вагонд үүсч болох гэмтлээс урьдчилан сэргийлэх техникийн үзлэг, үйлчилгээг хийхэд зориулагдан ачилт, буулгалтын болон галт тэрэг найруулан бэлтгэх зориулалттай төмөр замын томоохон хэсэглэх газруудад техникийн үзлэг, засвар хийх үйлчилгээний нэгж.

ТҮХ-Техник үйлчилгээний хэсэг

ВЗГ-Вагон засварын газар (телеграфын товчилсон нэр ППВ)

Техникийн үзлэг, үйлчилгээ /цаашид “ТҮ” гэх/

Эд анги, зангилаа хэсэг нь батлагдсан хэсэглэлийн хэмжээнд буюу тогтоосон хугацаанд ажиллах чадвартай эсэхийг баталгаажуулсан цогц үзлэг үйлчилгээ.

Техникийн үзлэг, үйлчилгээ-1 /цаашид “ТҮ-1” гэх/

Техникийн өртөөнд хийгдэх вагоны эд анги, зангилаа хэсгийн элэгдэл, гэмтэл гарах явдлаас урьдчилан сэргийлэх ба гэмтэлтэй тохиолдолд засварын хэмжээг тогтоох үзлэг, зарим эд ангийн тохиргоог, тосолгоо хийх цогц үзлэг, үйлчилгээ. /ТБУ+ТАУ+ТХҮ+ХДҮ+УЗ+УЗ-1-ээс бүрдэнэ/

Техникийн үзлэг үйлчилгээ-2 /цаашид “ТҮ-2” гэх/

Ачаа, зорчигчийн вагоныг зуны болон өвлийн тээвэрлэлтэд бэлтгэн засварын бааз бүхий газарт техникийн актаар баримтжуулан, гүйцэтгэх цогц үзлэг, үйлчилгээ.

Техникийн бүрэн үзлэг /цаашид “ТБҮ” гэх/

Вагоны эд анги, зангилаа хэсгийн нүдэнд харагдах хүрээнд хийх үзлэг, нүдэнд шууд харагдахгүй хэсэгт өвдөглөж суусан байдлаар хийх үзлэгийн нийлбэрийг хэлнэ.

Техникийн хяналтын үзлэг /цаашид “ТХҮ” гэх/

Вагоны эд анги, зангилаа хэсгийн нүдэнд харагдах хүрээнд хийх үзлэг.

Хөдөлгөөн дундах үзлэг /цаашид “ХДҮ” гэх/

Галт тэргийг хүлээн авах, үдэн гаргах, шууд өнгөрөх үед явуут дунд нь вагоны техникийн байдалд хяналт тавих үзлэг.

Тоормосын бүрэн туршилт /цаашид “ТБТ” гэх/

Ачаа болон зорчигчийн галт тэргэнд явахын өмнө тоормосын зангилаа эд ангийн бүрэн бүтэн байдлыг хангах, элэгдэл нь хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахуйц тогтоосон хэмжээнд тохирч байгаа эсэхийг шалгах үзлэг.

Тоормосын товчилсон туршилт /цаашид “ТТТ” гэх/

Ачаа болон зорчигчийн галт тэрэг дахин ажилласан болон өртөөнөөс явахын өмнө суурин хийн төхөөрөмжөөр шалгасан галт тэрэгний сүүлийн хоёр вагон, нэмсэн вагонуудын тоормосын зангилаа эд ангийн бүрэн бүтэн байдлыг хангах, элэгдэл нь хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахуйц тогтоосон хэмжээнд тохирч байгаа эсэхийг шалгах үзлэг.

Урсгал засвар /цаашид “УЗ” гэх/

Гэмтэлтэй нь “ТҮ”-гээр тогтоогдсон вагоныг галт тэрэгнээс салгахгүйгээр хийх салгалтгүй засвар.

Төлөвлөгөөт бус урсгал засвар /цаашид “УЗ-1” гэх/

Вагоны гэмтэл нь салгалтгүй засвар “УЗ”-аар засварлах боломжгүй нь “ТҮ-1” үзлэгээр тогтоогдсон, засварын ажлыг тусгай тоноглолтой зориулалтын зам дээр гүйцэтгэх салгалттай урсгал засвар.

Гүүшингийн халуун үзлэг/цаашид “ГХҮ” гэх/

Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор өртөөнд ирсэн галт тэрэгний вагонуудын хайрцган болон өнхрөх холхивчит гүүшинг халсан эсэхийг тодорхойлох үзлэг. /Гүүшингийн халалтыг шалгах хээрийн байгууламжтай бол ГХҮ-ийг хийх шаардлагагүй/

Техникийн ачилтын үзлэг / цаашид “ТАҮ” гэх/

Тээвэрлэх ачааны төрлөөс хамааран түүний бүрэн бүтэн байдлыг хангах, вагоны зангилаа эд ангийн байдал, элэгдэл нь хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахуйц тогтоосон хэмжээнд тохирч байгаа эсэхийг үзэх бүрэн үзлэг.

ГТХАБ- Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал

ХАБЭА- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй

ДНЦ- Диспетчер

ДСП- Өртөөний жижүүр

ТЧ- Татах хэсэг

ПЧ- Замын анги

ДС- Өртөө

ДСЦ- Сэлгээний хөдөлгөөн зохицуулагч

ВД- Вагоны диспетчер

ВЗЗ- Вагон засварын тусгай тоноглогдсон зам

АТҮЦС- Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем программ

ВУ-14- Вагоныг техникийн үзлэгт оруулах цахим дэвтэр (Өртөөний жижүүр, туслах жижүүрт хөтөлнө)

ВУ-22- Гэмтлийн мэдэгдэл

ВУ-23- Ачааны вагоныг засварт өгсөн мэдэгдэх цахим хуудас /Галт тэрэгнээс салгах/

ВУ-23А- Ачааны вагоныг салбар замд засварлах мэдэгдэх цахим хуудас

ВУ-23Б- Хувийн хэвшлийн вагоныг засварт өгсөн мэдэгдэх цахим хуудас /Галт тэрэгнээс салгах/

ВУ-25- Вагоны гэмтлийн тухай акт

ВУ-25Б- Вагоны засварын захиалгын маягт

ВУ-26- Вагон илгээх дагалдах цахим хуудас

ВУ-26Б- Хувийн хэвшлийн вагон илгээх дагалдах цахим хуудас

ВУ-31-Ачааны паркийн гэмтэлтэй вагоны засварын ба бэлэн байдлын бүртгэлийн дэвтэр

ВУ-36- Вагон засвараас хүлээн авсан мэдэгдэх хуудас

ВУ-45- Галт тэрэгний вагонуудын тоормосын ажиллагааг шалгасан тухай маягт

ВУ-53- Хос дугуйн засвар ба эргэлтийн бүртгэлийн дэвтэр

ГУ-98А- Техникийн ачилтын үзлэгийн цахим дэвтэр

ТЧМ- Зүтгүүрийн машинч

Галт тэрэг хүлээн авах цэг- Хязгаарын шонгоос дотогш аюулгүй зайд галт тэрэгний бүрэлдэхүүнийг бүрэн хүлээн авах вагон үзэгчийн байрлах цэг.

Галт тэрэгний бүрэлдэхүүнийг бүрэн хүлээн авах ажиллагаа- Вагон үзэгчийн байрлалаас үл хамаарч галт тэрэгний бүрэлдэхүүний сүүлийн вагон хүлээн авч байгаа вагон үзэгчийн өмнүүр бүрэн өнгөрч зогссон бүх тохиолдлыг хэлнэ.

Галт тэргийг үдэн гаргах ажиллагаа- Вагон үзэгч нь гаргах дохионоос дотогш аюулгүй зайд, түүчээ зүтгүүрийн машинчийн харалдаа зогсож, галт тэргийг бүрэн бүрэлдэхүүнээр нь гаргаж өгөх.

Технологийн холбоо- Чанга яригч, радио станц, шууд утас зэрэг технологийн зорилгоор ашигладаг, тодорхой хугацаанд хяналт шалгалтаар баталгааждаг холбооны хэрэгсэл.

Хоёр талын холбоо- Технологийн холбоог ашиглан хоёр ажилтны харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагаа.


Өртөөгөөр зогсолттой галт тэргийг өнгөрүүлэх- Өртөөнд орж ирээд ямар нэг шалтгаанаар /дахин ажиллагаа хийгдэхгүй ачаа хүргэгч болон зүтгүүрийн бригад буулгаж суулгах, зөрлөг хүлээх гэх мэт/ тодорхой хугацаанд зогсоод явах галт тэргийг хэлнэ.

Өртөөгөөр зогсолтгүй галт тэргийг өнгөрүүлэх- Өртөөгөөр шууд өнгөрүүлэхээр нээсэн зөвшөөрсөн заалттай дохио, замналын дагуу зогсолтгүй өнгөрөх галт тэргийг хэлнэ.

НЭГ:ВАГОНЫ ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАРЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

Вагон нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, вагоны бүрэн бүтэн байдал, түүний найдвартай ажиллагааг хангах зорилгоор дараах төрлийн техникийн засвар, үзлэг үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.

Зураг 1. Вагоны техникийн үйлчилгээ, засварын төрөл ангилал



Тайлбар:

1. Энэхүү технологийн загварын 1.5-р заалтад заасны дагуу ГХҮ-ийг хийж гүйцэтгэнэ.

1. Ачаа, зорчигчийн, ачаа зорчигчийн галт тэрэгнүүдэд ТҮГ, ТҮХ-ийн байршил орон нутгийн онцлогт тохируулан дараах үзлэг засварыг хийнэ.

1.1. Хөдөлгөөн дундах үзлэг хийх нөхцөл:

- 1.1.1. Галт тэргийг хүлээн авах үед
- 1.1.2. Галт тэргийг үдэн гаргах үед
- 1.1.3. Өртөөгөөр зогсолттой галт тэргийг өнгөрүүлэх үед
- 1.1.4. Өртөөгөөр зогсолтгүй галт тэргийг өнгөрүүлэх үед

1.2. Галт тэргэнд техникийн бүрэн үзлэг хийх нөхцөл:

- 1.2.1. Өртөөнд ирсэн галт тэрэгний вагоныг цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт үзлэгт өгсөн үед.
- 1.2.2. Дахин ажиллагаатай галт тэргэнд нэмэх вагоныг цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт үзлэгт өгсөн үед.
- 1.2.3. Дахин ажиллагаатай галт тэрэгнээс салсан вагоныг цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт үзлэгт өгсөн үед.
- 1.2.4. Салбар замаас ачилт хийгдэн өртөөний зам дээр татаж гарч ирсэн, буултаас суларсан вагонуудыг өртөөний зам дээр татаж гарч ирсэн тохиолдолуудад буюу цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт үзлэгт өгсөн үед.
- 1.2.5. Ирсэн галт тэрэгний вагонд техникийн ачилтын үзлэгийг хамтатган гүйцэтгүүлхээр цахим /цаасан/ ВУ-14, ГУ-98А дэвтэрт үзлэгт өгсөн үед. (Энэ үед ТАҮ-ийн хугацааг баримтлана.)

- 1.2.6. Галт тэрэг солилцооны үед.
- 1.2.7. Тушаал шийдвэрээр вагон солилцох үед
- 1.3. Галт тэргэнд техникийн хяналтын үзлэг хийх нөхцөл**
 - 1.3.1. Өртөөнөөс явах галт тэргийг цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт үзлэгт өгсөн үед.
- 1.4. Техникийн ачилтын үзлэг хийх нөхцөл:**
 - 1.4.1. ГУ-98А цахим болон цаасан дэвтэрт тэмдэглэгдсэн үед.
- 1.5. Гүүшингийн халуун үзлэг хийх нөхцөл:**
 - 1.5.1. Өртөөнд ирсэн галт тэргэнд гүүшингийн халуун үзлэгийг хийж гүйцэтгэнэ.
- 1.6. Урсгал засвар хийх нөхцөл:**
 - 1.6.1. Галт тэрэгний вагонд техникийн үзлэгээр үл тохирол /гэмтэл/ илэрсэн үед.
 - 1.6.2. ТАҮ-ээр үл тохирол /гэмтэл/ илэрсэн үед.
- 1.7. Төлөвлөгөөт бус урсгал засвар хийх нөхцөл:**
 - 1.7.1. Урсгал засвараар засварлах боломжгүй гэмтэлтэй вагонд.
 - 1.7.2. ВБББ алдагдсан тохиолдолд
 - 1.7.3. Вагоны засварын хугацаа сунгах үед.
- 1.8. Галт тэрэгний аюулгүй байдлыг хангах баталгаат хэсэглэл**
 - 1.8.1. Замын даргын тогтоосон хөдөлгөөний аюулгүй байдлын баталгаат хэсэглэл дууссан буюу эхэлж байгаа өртөөдөд галт тэрэгний бүрэлдэхүүнд техникийн бүрэн үзлэгийг хийж гүйцэтгэнэ.
 - 1.8.2. Өртөөнөөс найруулсан галт тэрэгний ГТХАБ-ын хангах баталгаат хэсгийн хязгаар нь тухайн галт тэрэгний хүрэх өртөө (Уг галт тэргийг дахин найруулах) болох бөгөөд энэ нь хилээр болон зэргэлдээ төмөр замаас хүлээн авч байгаа галт тэргэнд хамаарахгүй.

ХОЁР: АЧААНЫ ГАЛТ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. Ачааны галт тэргийг техникийн үзлэгт авах дараалал, ажилбар

2.1.1. Техникийн үзлэгт авах:

2.1.1.1. Дараах тохиолдлуудад өртөөний ажилтан /ДСП, ДСПо, ДСПп/ цахим /цаасан/ ВУ-14 маягтад тэмдэглэн галт тэрэг, бүрэлдэхүүнийг үзлэгт өгч гарын үсэг /цахим, тоон/ зурна. Үүнд :

а. Өртөөнд галт тэргийг орж ирсний дараа зүтгүүр салах бол бүрэлдэхүүнийг ивүүрээр бэхэлж, тухайн замаас гарсны дараа.

б. Дахин ажиллагаатай галт тэрэгнээс вагон салж үлдсэн, вагон нэмэх тохиолдолд.

в. Тоормосын бүрэн болон товчилсон туршилтын үед.

г. Салбар замаас вагоныг гарч ирэх тохиолдолд /Ачилт хийгдсэн, буулгалтаас суларсан, удаан хугацаагаар зогссон/

2.1.1.2. Өртөөний жижүүр нь /оператор/ Замын даргын тогтоосон тушаал, шийдвэрээс бусад өртөөний замын ашигтай уртад багтахгүй бүрэлдэхүүнийг хувааж тавьсан зам тус бүрээр цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт тэмдэглэн үзлэгт өгч гарын үсэг /цахим, тоон/ зурна.

2.1.1.3. Өртөөний жижүүр /оператор/-ын цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт үзлэгт өгсөн бичиглэлийг үндэслэн ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ тухайн замыг 2.2-р заалтад заасны дагуу хамгаалалтад авч баталгаажуулан үзлэг эхэлсэн цагийг тэмдэглэж гарын үсэг /цахим, тоон/ зурна. Энэ нь галт тэрэгний вагонуудыг техникийн үзлэгт хүлээн авсан буюу техникийн үзлэг эхэлсэн цаг болно.

2.1.1.4. Өртөөний жижүүрийн мэдэгдлээр дахин ажиллагаатай галт тэргийг ахлах үзэгчийн томилсон групп /вагон үзэгч нар/ ХДҮ хийж угтан авсан талаар ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт “Хяналт тавив” гэсэн бичиглэл хийж гарын үсэг /цахим, тоон/ зурна.

2.1.1.5. Өртөөнд найруулагдаж бэлэн болсон бүрэлдэхүүн, дахин ажиллагаатай галт тэргэнд нэмэх вагонд 1.2-1.6-р заалтанд заагдсан техникийн үзлэг, үйлчилгээг хийсний дараа ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ хамгаалалт буулган цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт “Үзлэг хийв” гэсэн бичиглэл хийж гарын үсэг /цахим, тоон/ зурна.

2.1.1.6. Өртөөнд ирсэн, өртөөнөөс явах, дахин ажиллагаатай галт тэрэгнээс салсан вагонд 1.2-р заалтанд заагдсаны дагуу техникийн үзлэг, үйлчилгээ хийгдсэн, тоормосын туршилт гүйцэтгэн бэлэн болсон галт тэргийг ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ хамгаалалт буулган цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт “**Техникийн гэмтэлгүй**” гэсэн бичиглэл хийж гарын үсэг /цахим, тоон/ зурна.

2.1.1.7. ТҮГ /ТҮХ/-ийн хүчин чадал, галт тэрэгний давхцалаас шалтгаалж тухайн технологит ажилбар гүйцэтгэж буй замын зэргэлдээх замаас бусад замаар /зам алгасан/ орж ирсэн галт тэргэнд ХДҮ-ийг хийгээгүй бол 1.2-1.6-р заалтад заагдсан техникийн үзлэг үйлчилгээ хийсний дараа ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ хамгаалалт буулган цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт “Техникийн гэмтэлгүй” гэсэн бичиглэл хийж гарын үсэг /цахим, тоон/ зурна.

2.1.2. Өртөөнд ирсэн галт тэрэг

2.1.2.1. Өртөөний жижүүр зэргэлдээ өртөөнөөс ирэх галт тэрэгний хүлээн авах цаг, зам, вагон тоо, ямар ажилбар хийгдэх зэргийг хоёр талын холбоогоор ТҮГ /ТҮХ/-ийн вагон үзэгч нарт тодорхой мэдэгдэнэ. Тухайн өртөөний ТҮГ-ын байршил зэргэлдээ өртөөний алслалт зэргээс шалтгаалан өмнөх өртөөнөөс гарах галт тэрэгний мэдээллийг урьдчилан өгч болно.

2.1.2.2. Өртөөний жижүүрийн мэдэгдлийн дагуу ахлах үзэгчийн томилсон групп /вагон үзэгч нар/ галт тэрэг хүлээн авах цэгт байрлан ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ. ТҮГ /ТҮХ/-ийн хүчин чадал, галт тэрэгний давхцалаас шалтгаалж тухайн технологит ажилбар гүйцэтгэж буй замын зэргэлдээх замаас бусад замаар /зам алгасан/ орж ирж буй галт тэргэнд ХДҮ хийхгүй байж болно.

2.1.2.3. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт 2.1.1.3-р заалтад заасны дагуу бичиглэл хийж 2.2-р заалтад заасны дагуу хамгаалалтад авах, ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.1.2.4. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт тэмдэглэгдэн хамгаалалтад авагдсан галт тэрэгний вагонуудад 1.2-1.6-р заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Бүх вагоны авто угсрааны найдвартай холболтыг шурганы лоомоор /шурганы алх/ шалгана.

2.1.2.5. Техникийн үзлэгээр илэрсэн УЗ-аар засварлах боломжгүй гэмтэлтэй вагонд ВУ-23, ВУ-23Б маягтыг үйлдэн 1.7.1-р заалтыг үндэслэн УЗ-1-ийг хийж гүйцэтгэнэ.

2.1.2.6. Техникийн үзлэг үйлчилгээ дууссаны дараа ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ 2.1.1.6-р заалтыг хэрэгжүүлнэ. Энэ нь техникийн үзлэг үйлчилгээ дууссан цаг болно.

2.1.3. Өртөөнөөс явах галт тэрэг

2.1.3.1. Өртөөний жижүүр найруулагдан бэлэн болсон галт тэрэгний мэдээллийг хоёр талын холбоогоор ТҮГ /ТҮХ/-ийн ахлах үзэгч /оператор, вагон үзэгч/ нарт тодорхой мэдэгдэж цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт 2.1.1.3-р заалтад заасны дагуу бичиглэл хийж ахлах үзэгч /оператор, вагон үзэгч/ нар хариу мэдэгдэж 2.2-р заалтад заасны дагуу хамгаалалтад авах ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.1.3.2. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт тэмдэглэгдэн хамгаалалтад авагдсан галт тэрэг вагонд 1.2-1.6-р заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт 2.1.1.5-р заалтыг хэрэгжүүлнэ.

2.1.3.3. Техникийн үзлэгээр илэрсэн УЗ-аар засварлах боломжгүй гэмтэлтэй вагонд ВУ-23, ВУ-23Б маягтыг үйлдэн 1.7-р заалтын дагуу УЗ-1-ийг хийж гүйцэтгэнэ.

2.1.3.4. 1.2-1.6-р заалтанд заагдсаны дагуу техникийн үзлэг, үйлчилгээ хийж дууссаны дараа ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ 2.1.1.5-р заалтыг хэрэгжүүлнэ.

2.1.3.5. Бүрэлдэхүүнд зүтгүүр холбогдсоны дараа 2.1.1.1, 2.1.1.3-р заалтад заагдсан ажилбаруудыг гүйцэтгэж тоормосын туршилтыг хийж гүйцэтгэнэ.

2.1.3.6. Тоормосын туршилтыг хийж гүйцэтгэж ВУ-45 маягтыг ТЧМ-д гардуулж ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ 2.1.1.6-р заалтыг хэрэгжүүлнэ. Энэ нь галт тэрэг бэлэн болсон цаг болно.

2.1.3.7. Тоормосын бүрэн туршалт хийж бэлэн болсон галт тэрэг удаан зогссон шалтгаанаар тоормосын товчилсон туршилт хийх шаардлага гарсан тохиолдолд 2.1.1.1, 2.1.1.3, 2.1.3.5-р заалтад заагдсан ажилбаруудыг гүйцэтгэнэ.

2.1.3.8. Техникийн үзлэг, үйлчилгээ, тоормосын туршилт хийж бэлэн болсон галт тэрэг шууд явахгүй удаан зогсох нь тодорхой болсон бол ахлах үзэгчийн шийдвэрээр группийг /вагон үзэгч нар/ дараагийн галт тэрэгний ажилбарт шилжүүлж болно. Тухайн галт тэргийг 30 минут тутам ТТТ хийхгүйгээр өртөөнөөс явахын өмнө хийж гүйцэтгэж болно.

2.1.4. Дахин ажиллагаатай галт тэрэг

2.1.4.1. Өртөөний жижүүр зэргэлдээ өртөөнөөс ирэх галт тэрэгний хүлээн авах цаг, зам, вагон тоо, ямар ажилбар, хэрхэн хийгдэх зэргийг хоёр талын холбоогоор ТҮГ /ТҮХ/-ийн вагон үзэгч нарт тодорхой мэдэгдэнэ.

2.1.4.2. Өртөөний жижүүрийн мэдэгдлийн дагуу ахлах үзэгчийн томилсон групп /вагон үзэгч нар/ галт тэрэг хүлээн авах цэгт байрлан ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ.

2.1.4.3. Бүрэлдэхүүнээс бүлэг /нэг/ вагоныг салгах, нэмэх сэлгээний ажил хийгдэнэ. Хоёр ба түүнээс дээш байранд сэлгээний ажил хийгдсэн тохиолдолд 1.2-1.6-р заалтуудыг баримтлан техникийн үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

2.1.4.4. Сэлгээний ажил дуусаж бүрэлдэхүүн бэлэн болсны дараа замын даргын тогтоосон тушаалын дагуу тохирох тоормосын туршилтыг хийж гүйцэтгэнэ.

2.1.4.5. Дахин ажиллагаатай галт тэргэнд нэмэх вагоныг 1.2.3-р заалтад заагдсаны дагуу техникийн үзлэг үйлчилгээг урьдчилан хийсэн байна. Холбогдсон хэсгийн авто угсрааны найдвартай холболтыг шурганы лоомоор /шурганы алх/ шалгана.

2.1.4.6. Дахин ажиллагаатай галт тэрэгнээс салсан вагоныг 1.2.3, 1.3.3-р заалтад заагдсаны дагуу техникийн үзлэг үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. Энэ үед 2.1.1.1, 2.1.1.3-р заалтуудыг мөрдөж ажиллана. Техникийн үзлэг, үйлчилгээ хийж дууссаны дараа ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ 2.1.1.5-р заалтыг хэрэгжүүлнэ.

2.1.4.7. Дахин ажиллагаатай галт тэргийг өртөөнөөс явах үед тоормосын туршилт хийсэн групп /вагон үзэгч нар/ ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ. Галт тэрэгний мэдээллийг технологийн холбоогоор /радио станц/ ДСП-д өгнө.

2.1.5. Шууд болон дамжин өнгөрөх галт тэрэг

2.1.5.1. Өртөөний жижүүр зэргэлдээ өртөөнөөс ирэх галт тэрэгний хүлээн авах цаг, зам, вагон тоо, ямар ажилбар, хэрхэн хийгдэх зэргийг хоёр талын холбоогоор ТҮГ /ТҮХ/-ийн вагон үзэгч нарт тодорхой мэдэгдэнэ.

2.1.5.2. Өртөөний жижүүрийн мэдэгдлийн дагуу зогсолтгүй шууд өнгөрөх галт тэргэнд ахлах үзэгчийн томилсон групп /вагон үзэгч нар/ галт тэрэгний давхцалгүй бол ажлын байрны харалдаа, галт тэрэгний давхцалтай, зэргэлдээ замаар өнгөрч буй тохиолдолд ажилбарыг зогсоож ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ.

2.1.5.3. ТҮГ /ТҮХ/-ийн хүчин чадал, галт тэрэгний давхцалаас шалтгаалж вагон үзэгчийн технологит ажилбар гүйцэтгэж буй замын зэргэлдээх замаас бусад замаар /зам алгасан/ зогсолтгүй шууд болон дамжин өнгөрч байгаа галт тэргэнд ХДҮ хийхгүй байж болно.

2.1.5.4. Өртөөний жижүүрийн мэдэгдлийн дагуу зүтгүүрийн бригад солигдохоор зогсолттойгоор дамжин өнгөрөх галт тэргийг ахлах үзэгчийн томилсон групп /вагон үзэгч нар/ галт тэрэг хүлээн авах цэгт байрлан ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ. Энэ үед ахлах үзэгч /вагон үзэгч, оператор/ 2.1.1.4-р заалтыг хэрэгжүүлнэ.

2.1.5.5. Зүтгүүрийн бригад солигдох бол 2.1.1.1, 2.1.1.3-р заалтуудыг хэрэгжүүлж тоормосын туршилтыг хийж гүйцэтгэнэ. Энэ үед ахлах үзэгч нь /вагон үзэгч, оператор/ 2.1.1.6-р заалтыг хэрэгжүүлнэ.

2.1.5.6. Зүтгүүрийн бригад солигдоод явах галт тэргэнд тоормосын туршилт хийсэн групп /вагон үзэгч нар/ ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ. Галт тэрэгний мэдээллийг технологийн холбоогоор /радио станц/ ДСП-д өгнө.

2.1.5.7. Өртөөний жижүүрийн мэдэгдлийн дагуу зурмагийн бус зогсолттойгоор дамжин өнгөрөх галт тэргийг ахлах үзэгчийн томилсон групп /вагон үзэгч нар/ ажлын байрны харалдаа, галт тэрэгний давхцалтай бол ажилбар гүйцэтгэж буй байрлалаас ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ.

2.1.5.8. Өртөөн дээр зогсолттой зөрлөг хийн шууд явах галт тэрэгнүүдэд ахлах үзэгчийн томилсон вагон үзэгч нар хязгаарын шонгоос дотогш аюулгүй зайд байрлан ХДҮ-ийг хийж гүйцэтгэнэ. Галт тэрэгнүүдийн мэдээллийн талаар ахлах үзэгч /вагон үзэгч/ өртөөний жижүүр /ДСП/ нар албан ярилцлага хийнэ.

2.1.6. Замын ашигтай уртад багтаагүй галт тэрэг

2.1.6.1. Өртөөнд ирсэн болон явах галт тэрэгний бүрэлдэхүүн замын ашигтай уртад багтаагүй тохиолдолд 2-оос дээш замд хувааж үзлэгт өгөхийг хатуу хориглоно.

2.1.6.2. Өртөөний аль нэг замын ашигтай уртад багтахаар бүрэлдэхүүнийг нэгээс дээш зам дээр хувааж үзлэгт өгөхийг хатуу хориглоно.

2.1.6.3. Замын даргын тушаалаар тогтоосон өртөөдөд замын ашигтай уртад багтахгүй буухиа чингэлэгийн галт тэргийг тухайн зам дээр нь 1.1-1.6-р заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

2.1.6.4. Өртөөнөөс явах замын ашигтай уртад багтахгүй галт тэргийг 2 зам дээр хувааж техникийн үзлэг үйлчилгээ гүйцэтгэсэн бол бүрэлдэхүүнийг нийлүүлж холбосны дараа тоормосын туршилтыг хийж гүйцэтгэнэ.

2.1.6.5. Өртөөнд хүлээн авсан галт тэрэг замын ашигтай уртад багтаагүй тохиолдолд салсан бүлэг вагоныг зэргэлдээ ТҮГ /ТҮХ/- тэй өртөөнд техникийн үзлэгт оруулахыг хориглоно.

2.2. Техникийн үзлэг засвар хийгдэх галт тэргийг хамгаалалтад авах хамгаалалт буулгах

2.2.1. Галт тэрэг, вагонуудад техникийн үзлэг, үйлчилгээ хийхийн тулд хамгаалалтад авч тухайн замруу өөр хөдлөх бүрэлдэхүүн орох боломжгүй болгох ёстой. Дараах хамгаалалтын төрлийг ашиглана. Үүнд:

2.2.1.1. **Төвлөрсөн хамгаалалт** - Ахлах үзэгч ээлжийн ажлаас чөлөөлөгдсөн, оператортой ТҮГ /ТҮХ/-дэд вагон үзэгч технологит ажил үүрэг гүйцэтгэж буй бүх тохиолдолд.

2.2.1.2. **Зөөврийн улаан самбар** - Төвлөрсөн хамгаалалтаар хамгаалалтад авах боломжгүй замд болон хагас автомат хориглол ажиллагаагүй болсон тохиолдолд.

2.2.1.3. **Улаан таг** - ТҮГ /ТҮХ/-н ажлын байранд төвлөрсөн хамгаалалтын пульт байхгүй, ТҮГ /ТҮХ/-ийн хүчин чадлаас шалтгаалан /ахлах үзэгч группын зохион байгуулалтад ажиллаж байгаа, операторгүй/ ТҮГ /ТҮХ/-т байрлах төвлөрсөн хамгаалалтын пультаг ашиглах боломжгүй тохиолдолд.

2.2.2. Галт тэргийг хамгаалалтад авахдаа ахлах үзэгч /оператор, вагон үзэгч/ ТҮГ /ТҮХ/-т байрлах төвлөрсөн хамгаалалтын пультэн дээрх зохих замын товрууг дарна. Энэ үед өртөөний жижүүр өөрийн пультэн дээрх тухайн замын хамгаалалтын товрууг дарж, пульт дээрх улаан гэрэл жигд ассанаар тухайн зам бүрэн хамгаалагдана.

2.2.3. Өртөөний жижүүрийн пультаг товруун дээр улаан тагаар хамгаалалтад авч буулгах ажлыг өртөөний жижүүр /ДСП/ хариуцана. Энэ үед хоёр талын технологийн холбоогоор /радио станц/ ахлах үзэгч /вагон үзэгч/ өртөөний жижүүр /ДСП/, зүтгүүрийн машинч /ТЧМ/ нар албан ярилцлага хийнэ.

2.2.4. Онцгой тохиолдолд төвлөрсөн хамгаалалт ажиллагаагүй болсон үед зөөврийн улаан самбарыг “Төмөр замын дохиолол холбооны журам”-ын 4.2.1-ийн дагуу байрлуулж үзлэг засвар хийж байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг хамгаална.

2.2.5. Галт тэрэгний техникийн үзлэг үйлчилгээ, тоормосын туршилт дууссаны дараа ахлах үзэгчийн /вагон үзэгч/ мэдэгдлээр төвлөрсөн пульт дээрх товрууг татах, ахлах үзэгчийн томилсон вагон үзэгч зөөврийн улаан самбарыг авах, жижүүрийн пульт дээрх улаан тагийг авснаар хамгаалалт буулгасанд тооцно.

2.2.6. Галт тэргийг хамгаалалтад авах, буулгах ажиллагааны үед хоёр талын технологийн холбоогоор /радио станц/ хамгаалалтад авсан, техникийн үзлэг үйлчилгээ дуусаж хамгаалалт буулгасан талаар албан ярилцлага заавал хийнэ.

2.3. Ачааны галт тэргэнд техникийн үзлэг, үйлчилгээ хийх аргачлал

2.3.1. Хөдөлгөөн дундах үзлэг /ХДҮ/

2.3.1.1. Галт тэргийг хүлээн авах, үдэн гаргах, шууд өнгөрөх үед явуут дунд нь вагоны техникийн байдалд дараах үл тохиролууд байгаа эсэхэд хяналт тавина. Үүнд:

- а. Хос дугуй чирэгдэж яваа эсэх
- б. Аяллын үед хос дугуй эргэж байсан ч тоормосын шахавч хос дугуйн хооронд их хэмжээний оч гарч чийхарч дуугаран тоормос бариатай тоормосын цилиндрийн шилбэ дутуу суусан явж байгаа эсэх.
- в. Хос дугуй зам төмөрт хүчтэй цохиж яваа эсэх.
- г. Тэргэнцэр хүчтэй донсолсон, хос дугуй жигд эргэж чадахгүй байх, гүүшинд чийхарсан дуу гарч байгаа эсэх.
- д. Гүүшингийн үзлэгийн таг байхгүй, вагоны хаалга нээлхий онгорхой вагон бүрэлдэхүүнд байгаа эсэх.
- е. Тоормосын хөшүүрэг, татуурга унаж чирэгдсэн эсэх.
- ё. Зөөлөн хоолой вагонуудын хооронд унжсан эсэх.
- ж. Бүрэлдэхүүний дундуур төгсгөлийн кран хаалттай яваа эсэх.
- з. Вагоны кузовын хазайлт хэмжээнээс хэтэрсэн эсэх.
- и. Авто угсрааны салгах хөшүүрэг байрнаасаа хөдөлсөн, өргөгчийн гол унжсан эсэх.
- й. Вагонд ямар нэг зүйл чирэгдэж яваа эсэх.
- к. Хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачааны бэхэлгээ алдагдсан, вагоны аль нэг хэсгээр ачаа гоожиж яваа эсэх.


2.3.1.2. Үдэн гаргах, шууд болон дамжин өнгөрөх галт тэргэнд ХДҮ-ийг хийх үед вагонд үл тохирол илэрсэн тохиолдолд вагон үзэгч нь технологийн холбоогоор /радио станц/ ДСП-д мэдэгдэж галт тэргийг зогсоох арга хэмжээг авна. Галт тэрэг зогссоны дараа вагон үзэгч нар үл тохирол бүхий вагонд үзлэг хийж шаардлагатай шуурхай арга хэмжээг авч ажиллана. Өртөөнд ирсэн галт тэргэнд угтан авах үеийн ХДҮ-ээр илэрсэн үл тохирол бүхий вагоныг 1.2-1.6-р заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээгээр нарийвчилсан үзлэг хийж шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

2.3.1.3. ХДҮ-ээр илрэх боломжгүй үл тохирлийг техникийн үзлэг, үйлчилгээ хийж явуулсан ТҮГ /ТҮХ/ хариуцна.

2.3.2. Ачааны галт тэрэг, бүрэлдэхүүнд үзлэг хийх замнал

2.3.2.1. Галт тэрэгний вагондуудад нэг группийн зохион байгуулалтаар техникийн үзлэгийг дараах байдлаар гүйцэтгэнэ.

Зураг 2. Галт тэрэгний вагонд нэг группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх замнал




2.3.2.2. Галт тэрэгний вагондуудад хоёр группийн зохион байгуулалтаар техникийн үзлэгийг дараах байдлаар гүйцэтгэнэ.

2.3.2.3. Галт тэрэг, бүрэлдэхүүнд техникийн үзлэгийг хоёр группийн зохион байгуулалтаар хийх явцад аль нэг групп өөр галт тэргэнд шилжин ажиллах тохиолдолд, зураг 3-ын “В”-ийн дагуу үзлэг хийх бол бүрэлдэхүүний дундаас үзлэг эхлүүлсэн групп наалдсыг /болзолт тэмдэг/ авто угсрааны дээр нүдэнд харагдахуйц байрлуулна.

2.3.2.4. Дунд уулзсан авто угсрааны найдвартай холболтыг 1-р групп, наалдас /болзолт тэмдэг/ байрлуулсан авто угсрааны найдвартай холболтыг наалдас /болзолт тэмдэг/ авсан групп хариуцна.

2.3.2.5. Галт тэрэгний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар техникийн үзлэг үйлчилгээ хийх замнал нь ТҮГ /ТҮХ/-ийн ажлын байрны байршил, орон нутгийн онцлогоос шалтгаалж бүрэлдэхүүний толгой болон сүүлээс нэгэн зэрэг үзлэгийг эхлүүлж дундаа уулзах /зураг А/, бүрэлдэхүүний дундаас хоёр тийш нэгэн зэрэг үзлэгийг эхлүүлэх /зураг Б/, аль нэг групп нь толгой эсхүл сүүл хэсгээс нөгөө групп нь бүрэлдэхүүний дундаас /мөрдөх зарчимаар/ нэгэн зэрэг үзлэгийг эхлүүлэх /зураг В/ аргачлалтай байна.


Зураг 3. Галт тэрэгний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх замнал



2.3.3. Ачааны вагонд техникийн үзлэг хийх байрлал

2.3.3.1. Ачааны вагоны үйлдвэрлэл, хийцийн онцлог, төрөл, зориулалтаас хамаарч зангилаа, эд анги хэсгүүдийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаанд энэ технологийн загварын 1.2-1.6-р заалтад заасан техникийн үзлэгийг дараах байрлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

Зураг 4. Ачааны вагонд техникийн бүрэн үзлэг хийх байрлал



2.3.4. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэг

2.3.4.1. Өртөөнд ирсэн ачааны галт тэргэнд ТБҮ-ийг хийж гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 2.3.3-р заалтад заасны дагуу вагоны зангилаа, эд анги хэсгүүдэд нүдэнд харагдах болон өвдөглөж суусан байдлаас хийж гүйцэтгэнэ.

2.3.4.2. Вагон үзэгч нар өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний вагонд техникийн үзлэг, үйлчилгээг нэг группын зохион байгуулалтаар хийж гүйцэтгэх тохиолдолд энэхүү технологийн загварын 2.3.1.1-р заалтад заалтыг мөрдөж ажиллана.

2.3.4.3. Вагон үзэгч нар өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний техникийн үзлэг нь өөр ямар нэгэн галт тэрэгний техникийн үзлэг, үйлчилгээтэй давхцаагүй тохиолдолд хоёр группын зохион байгуулалтаар хийж гүйцэтгэх ба энэхүү технологийн загварын 2.3.1.2-2.3.2.5-р заалтуудыг мөрдөж ажиллана.

2.3.4.4. Өртөөнд ирсэн галт тэргэнд техникийн үзлэг хийх үед гүүшингийн халуун үзлэгийг хамт хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 1. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний вагонуудад нэг группын зохион байгуулалттай техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)										
							15 хүртэл	10	20	30	40	50	60	70	80		
1	Галт тэрэг орж ирэх тухай мэдээллэнэ.	ДСП	-	Радио станц	-												
2	Галт тэргийг угтан авахад бэлтгэж, явуул дунд хяналт тавина.	В.үзэгч нар	IV, V, VI	Гар чийдэн / шөнө/	Өртөөний зам паркар зориндоо хальтрч унах, бударч тэглэх аюулас сэрэмжилж, ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө.												
3	Бүрэлдэхүүн байрлаж буй замыг хамгаалалтанд авах, цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зориндоо ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд ороходоо хальтрч унах, бударч тэглэх аюулас сэрэмжилж, шатны барилуулс барих явна.												
4	Техникийн үзлэг хийх	В.үзэгч нар	IV, V, VI	В.у-ийн алх, шурганы лоом, хуруур, дулаан мэдрэгч	ТЗ-ын зурвас газар зорчих, г.т, вагонд үзлэг засвар хийх үеийн ААЗ-ыг мөрдөнө. Замыг хамгаалалтанд бүрэн авна. Өртөөний замын голд байрлах мөүр, сэлбэгийн хайрцаг, дооноогоо хоолооны хэрэгсэлд бударч тэглэх аюулас сэрэмжилнэ	30 40 55 70											
5	Урсгал засвар хийх	В.үзэгч нар	IV, V, VI	Алх, газар, бордож, домкрат, хасуур, баа, түлхүүр / төр.бур/	Г.т, вагонд үзлэг, засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Текгоримд засны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Газраа эвчнэ, толгойг цоох, мөл гар дээрээ эд анги унагаж, сэлбэг материал аважаар явах үед бударч унах, г.т, сэлбэгийн хадгалууны үйлдэлд өртөөс сэрэмжилнэ. Алх, бордож, түлхүүр багаж нь АА-ны шаардлага хангасан байна.		ТУ хийсэн хугацааг техникийн үзлэгийн хугацаан дээр нэмж тооцно.										
6	УЗ хийх боломжгүй гэмтэлтэй вагонд ВУ-23 маягтыг ДСП-д өгнө.	А.үзэгч	V, VI	-	Зам паркар зориндоо ТЗ-ын зурвас газар зорчих ААЗыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд ороходоо хальтрч унах, бударч тэглэх аюулас сэрэмжилж ба шатны барилуулс барих явна.	5											
7	Хамгаалалт буулгаж цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	-	5											
	НИЙТ ХУГАЦАА					35 45 60 75											

Тайлбар: — 30 хүртэл томьёолсон урттай
— 31-60 хүртэл томьёолсон урттай
— 61-80 хүртэл томьёолсон урттай
— 81-100 хүртэл томьёолсон урттай

Тайлбар:

1. Бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийх хугацаанд УЗ хийх технологит хугацааг тооцоогүй.
2. Вагон үзэгч нарын нэг галт тэрэгний техникийн үзлэгээс нөгөө галт тэрэг угтан авах, техникийн үзлэгээс тоормосын туршилт гүйцэтгэх байрлалд шилжих хугацаа 15 хүртэл минут байна.

Хүснэгт 2. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний вагонуудад хоёр группын зохион байгуулалттай техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)						
							15 хүртэл	10	20	30	40	50
1	Галт тэрэг орж ирэх тухай мэдээллэнэ.	ДСП	-	Радио станц	-							
2	Галт тэргийг угтан авахад бэлтгэж, явуул дунд хяналт тавина.	В.үзэгч нар	IV, V, VI	Гар чийдэн / шөнө/	Өртөөний зам паркар зорчихдоо хальтирч унах, бүдрч тээглэх аюулаас сэрэмжлэх, ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө.							
3	Бүрэлдэхүүн байрлаж буй замыг хамгаалалтанд авах, цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдрч тээглэх аюулаас сэрэмжлэх, шатны баруулаас барьж явна.							
4	Техникийн үзлэг хийх	В.үзэгч нар	IV, V, VI	В.ү-ийн алх, шурганы лоом, хусуур, дулаан мэдрэгч	ТЗ-ын зурвас газар зорчих, г.т, вагонд үзлэг засвар хийх үеийн ААЗ-ыг мөрдөнө. Замыг хамгаалалтанд бүрэн авна. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, докиопол холбооны хэрэгсэлд бүдрч тээглэх аюулаас сэрэмжилнэ	15 20 28 37						
5	Урсгал засвар хийх	В.үзэгч нар	IV, V, VI	Алх, газар, бордок, домкрат, хасуур, бахь, түлхүүр / төр.бүр/	Г.т, вагонд үзлэг, засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Төх.горимд заасны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Гараа хавчих, толгойг цохих, хөл гар дээрээ эд анги унахад аюултай материал авахаар явах үед бүдрч унах, г.т, салбгийн хөдөлгөөний үйлчлэлд өртөхөөс сэрэмжилнэ. Алх, бордок, түлхүүр багаж нь АА-ны шаардлага хангасан байна.		ТУ хийсэн хугацааг техникийн үзлэгийн хугацаанд нэмж тооцно.					
6	УЗ хийх боломжгүй гэмтэлтэй вагонд ВУ-23 маягтыг ДСП-д өгнө.	А.үзэгч	V, VI	-	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдрч тээглэх аюулаас сэрэмжлэх ба шатны баруулаас барьж явна.	5						
7	Хамгаалалт буулгаж цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт		5						
	НИЙТ ХУГАЦАА					20 25 33 42						

Тайлбар: — 30 хүртэл томьёолсон урттай
— 31-60 хүртэл томьёолсон урттай
— 61-80 хүртэл томьёолсон урттай
— 81-100 хүртэл томьёолсон урттай

Тайлар:

- 1.Бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийх хугацаанд УЗ хийх технологит хугацааг тооцоогүй.
- 2.Вагон үзэгч нарын нэг галт тэрэгний техникийн үзлэгээс нөгөө галт тэрэг угтан авах, техникийн үзлэгээс тоормосын туршилт гүйцэтгэх байрлалд шилжих хугацаа 15 хүртэл минут байна.

2.3.5. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний вагонд Техникийн үзлэг үйлчилгээ, техникийн ачилтын үзлэгийг хамтатган хийж гүйцэтгэх технологийн горим

2.3.5.1. Өртөөнд ирсэн ачааны галт тэргэнд техникийн үзлэг үйлчилгээ, ТАҮ-ийг хамтатган хийж гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 2.3.3-р заалтад заасаны дагуу вагоны зангилаа, эд анги хэсгүүдэд нүдэнд харагдах болон өвдөглөж суусан байдлаас хийж гүйцэтгэнэ.

2.3.5.2. Галт тэрэгний бүрэлдэхүүний 30 хувь ба түүнээс дээш вагон ТАҮ-т орох тохиолдолд доорх технологи хугацааг мөрдөж ажиллана.

2.3.5.3. Техникийн үзлэг, үйлчилгээ, ТАҮ-ийг хамтатган 1 группын зохион байгуулалтаар гүйцэтгэх технологийн горим.

Хүснэгт 3. Өртөөнд ирсэн ачааны галт тэрэгний вагонд нэг группийн зохион байгуулалтаар техникийн үзлэг, үйлчилгээ, ТАҮ хамтатган хийх технологи горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хугацаа (мин)	Хугацаа (мин)											
1	Галт тэрэг орж ирэх болон бүрэлдэхүүн бэлэн болсныг мэдэгдэнэ.	ДСП	-	Радио станц	-	15 Хүртэл	15	30	40	55	70	80	90	100	120			
2	Галт тэргийг утган авахад бэлтгэж ХДҮ хийж утган авах. Нэг г.т-ээс нөгөө г.т-ний үзлэгт шилжих	В.Үзэгч нар	IV, V, VI	Гэрэлтүүлэх хэрэгсэл /шөнө/	Өртөөний зам паркар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.													
3	Галт тэрэг, бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтад авах. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт гарын үсэг /цахим, тоон/ зурна.	ДСП А.үзэгч	V, VI	Пульт	Өртөөний зам паркар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.													
4	Бүрэлдэхүүнд ТАҮ хийнэ.	В.Үзэгч нар	IV, V, VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	Өртөөний зам паркар зорчих үеийн, ГТ вагонд үзлэг засвар хийх үеийн, Ачааны вагонд УЗ хийх үеийн ААЗ зааврыг мөрдөж ажиллана.	35 70 85 100 115												
5	Урсгал засвар хийх	В.Үзэгч нар	IV, V, VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	Ачааны вагонд салгалтгүй УЗ хийх ААЗ-ыг, А-24 технологи картыг мөрдөнө.	УЗ буюу салгалтгүй урсгал засвар хийсэн хугацааг ТБУ-ийн хугацаан дээр нэмж тооцно.												
6	УЗ-1 буюу салгалттай урсгал засвар хийх гэмтэлтэй вагонд цахим /цаасан/ ВУ-23 маягт үйлдэнэ.	А.үзэгч	V, VI	-	Өртөөний зам паркар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.	5												
7	ГТ, бүрэлдэхүүн байрлах замын хамгаалалт буулгаж. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт гарын үсэг /цахим, тоон/ зурна.	ДСП А.үзэгч	V, VI	Пульт	-	5												
8	Нийт хугацаа					40 75 90 105 120												

Тайлбар: — 30 хүртэл томьёолсон урттай — 60 хүртэл томьёолсон урттай — 80 хүртэл томьёолсон урттай — 100 хүртэл томьёолсон урттай — 120 хүртэл томьёолсон урттай

2.3.5.4. Техникийн үзлэг, үйлчилгээ, ТАҮ-ийг хамтатган 2 группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх технологийн горим.

Хүснэгт 4. Өртөөнд ирсэн ачааны галт тэрээний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар техникийн үзлэг, үйлчилгээ, ТАҮ хамтатган хийх технологи горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хугацаа (мин)	Хугацаа (мин)						
1	Галт тэрэг орж ирэх болон бүрэлдэхүүн бэлэн болсныг мэдэгдэнэ.	ДСП	-	Радио станц	-	15 Хүртэл	20	30	40	50	60	70	
2	Галт тэргийг утган авахад бэлтгэж ХДҮ хийж утган авах. Нэг г.т-ээс нөгөө г.т-ний үзлэгт шилжих	В.Үзэгч нар	IV,V,VI	Гэрэлтүү -лэх хэрэгсэл /шөнө/	Өртөөний зам паркаар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.								
3	Галт тэрэг, бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтад авах. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт гарын үсэг /цахим, тоон/ зурна.	ДСП А.үзэгч	V,VI	Пульт	Өртөөний зам паркаар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.								
4	Бүрэлдэхүүнд ТАҮ хийнэ.	В.Үзэгч нар	IV,V,VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	Өртөөний зам паркаар зорчих үеийн, ГТ вагонд үзлэг засвар хийх үеийн, Ачааны вагонд УЗ хийх үеийн ААЗ мөрдөж ажиллана.	20 35 40 50 60							
5	Урсгал засвар хийх	В.Үзэгч нар	IV,V,VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	Ачааны вагонд салгалтгүй урсгал засвар хийх аюулгүй ажиллагааны заавар, А-24 технологи картыг мөрдөнө.	УЗ буюу салгалтгүй урсгал засвар хийсэн хугацааг ТБҮ-ийн хугацаан дээр нэмж тооцно.							
6	УЗ-1 буюу салгалттай урсгал засвар хийх гэмтэлтэй вагонд цахим /цаасан/ ВУ-23 маягт үйлдэнэ.	А.үзэгч	V,VI	-	Өртөөний зам паркаар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.	5							
7	Галт тэрэг, бүрэлдэхүүн байрлах замын хамгаалалт буулгаж. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт гарын үсэг /цахим, тоон/ зурна.	ДСП А.үзэгч	V,VI	Пульт	-	5							
8	Нийт хугацаа					25 40 45 55 65							

Тайлбар: — 30 хүртэл томьёолсон урттай — 60 хүртэл томьёолсон урттай — 80 хүртэл томьёолсон урттай — 100 хүртэл томьёолсон урттай — 120 хүртэл томьёолсон урттай

2.3.6. Өртөөнөөс явах ачааны галт тэрэг

2.3.6.1. Өртөөнөөс явах ачааны галт тэргэнд ТХҮ-ийг хийж гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 2.3.3-р заалтад заасны дагуу вагоны зангилаа, эд анги хэсгүүдэд нүдэнд харагдах байдлаас хийж гүйцэтгэнэ. Авто угсрааны найдвартай холболтыг тоормос бүрэн болон товчилсон туршилт хийж гүйцэтгэж буй вагон үзэгч нар дохионы сэртэн, салгах хөшүүрэгний байдлаар шалгана.

2.3.6.2. Вагон үзэгч нар өртөөнөөс явах ачааны галт тэрэгний вагонд нэг группын зохион байгуулалтаар ТХҮ, ТБТ хийж гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 2.3.1.1-р заалтыг мөрдөж ажиллана.

2.3.6.3. Вагон үзэгч нар өртөөнөөс явах ачааны галт тэрэгний техникийн үзлэг нь өөр ямар нэгэн галт тэрэгний техникийн үзлэгтэй давхцаагүй тохиолдолд хоёр группын зохион байгуулалтаар гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 2.3.1.2-2.3.2.5-р заалтуудыг мөрдөж ажиллана.

Хүснэгт 5. Өртөөнөөс явах ачааны галт тэрэгний вагонд нэг групп ТХҮ, ТБТ хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хугацаа (мин)	Хугацаа (мин)						
1	Галт тэрэг бэлэн болсныг мэдэгдэнэ.	ДСП	-	Радио станц	-	15 Хүртэл	15	30	40	50	60	70	
2	Нэг г.т-ээс нөгөө г.т-ний үзлэгт шилжих	В.Үзэгч нар	IV,V,VI	Гэрэлтүүлэх хэрэгсэл /шөнө/	Өртөөний зам паркаар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.								
3	Галт тэрэг, бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтад авах. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт гарын үсэг /цахим, тоон/ зурна.	ДСП А.үзэгч	V,VI	Пульт	Өртөөний зам паркаар зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааварын мөрдөж ажиллана.								
4	Бүрэлдэхүүнд ТҮХ хийх, авто угсрааны холболтыг шалгана.	В.Үзэгч нар	IV,V,VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	Өртөөний зам паркаар зорчих үеийн, ГТ вагонд үзлэг засвар хийх үеийн, Ачааны вагонд УЗ хийх үеийн ААЗ зааврыг мөрдөж ажиллана.	35 40 45 60							
5	Бүрэлдэхүүн байрлах замын хамгаалалт буулгаж. Зүтгүүр оруулах	ДСП А.үзэгч	V,VI	Пульт	Вагон үзэгч нарт аюулгүй зайд байрлах талаар урьдчилан мэдэгдэнэ.Зүтгүүр орох үед вагон доор байрлах, захын зам төмрөөс 1,2м-ээс дотогш зогсохыг хориглоно.								
6	Зүтгүүр орсны дараа тухайн замыг дахин хамгаалалтад авна.	ДСП А.үзэгч	V,VI	Пульт	Ахлах үзэгчээс хамгаалалтад авсан гэсэн зөвшөөрлийн дагуу тоормосын туршилт хийхэд бэлтгэнэ.								
7	Галт тэргэнд тоормосын бүрэн туршилтыг хийж гүйцэтгэнэ.	В.Үзэгч ТЧМ нар	IV,V,VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	ТБТ хийхдээ, даралтад хийн үйлчлэлд өртөх, хавчулахаас сэргэмжилнэ. Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн ААЗ-ыг мөрдөж ажиллана.	35 40 45 60							
8	Галт тэрэг байрлах замын хамгаалалт буулгаж. Цахим /цаасан/ ВУ-14 дэвтэрт гарын үсэг /цахим, тоон/ зурна.	ДСП А.үзэгч	V,VI	Пульт	-	5							
9	Галт тэргийг явуул дунд хяналт тавьж гаргаж өгнө.	В.Үзэгч нар	IV,V,VI	Вагон үзэгчийн ажлын багаж хэрэгсэл	Галт тэргийг гаргаж өгөх үед аюулгүй байрлал эзэлж зогсоно. Галт тэргэний өмнүүр гаргах үед зэргэлдээ замын үйлчлэлд өртөхөөс сэргэмжилнэ.								
	Нийт хугацаа					40 45 50 65							

Тайлбар: — 30 хүртэл томьёолсон урттай
— 40 хүртэл томьёолсон урттай
— 45 хүртэл томьёолсон урттай
— 50 хүртэл томьёолсон урттай
— 60 хүртэл томьёолсон урттай

Тайлбар:

1. Өртөөнд найруулж бэлэн болсон галт тэрэгний толгой ба сүүлийн вагоны захын залгаадаагүй авто угсрааг №873 загвараар хэмжих, мөн автоугсрааны өндрийг хэмжих ёстой.
2. Бүрэлдэхүүнд зүтгүүр оруулахын тулд хамгаалалт буулгаснаас дахин хамгаалалтанд авсан хугацааг нийт техникийн үзлэгийн хугацаанд тооцохгүй.
3. Өртөөнөөс явах галт тэрэгний бүрэлдэхүүнд зүтгүүр орсны дараа тоормосын бүрэн туршилтыг хоёр вагон үзэгч гүйцэтгэнэ.
4. Галт тэргийг үдэн гаргах үед вагонд ГТХАА-нд сөргөөр нөлөөлөх гэмтэл илэрсэн тохиолдолд галт тэргийг нэн даруй зогсоох арга хэмжээг авах ёстой.
5. Нэг галт тэрэгний техникийн үзлэг, тоормос турших ажиллагаанаас нөгөө галт тэрэгний техникийн үзлэгт шилжих хугацаа 15 хүртэл минут байна.
6. Галт тэрэгний тоормосыг туршсан 2-р вагон үзэгч тоормосын туршилт гүйцэтгэсний дараа сүүлийн вагоныг дохио, бэхэлгээгээр бэхэлж, галт тэргийг явтал сүүлд хүлээж байгаад гаргаж өгнө.

2.3.7. Техникийн ачилтын үзлэг /Цаашид “ТАҮ” гэх/ хийх технологийн горим

2.3.7.1. Өртөөний жижүүр (довын болон ачааны диспетчер) ачилтын захиалгын дагуу вагон тавьж өгөхийн өмнө уг вагоныг техникийн болон ачаа тээврийн үзлэгт оруулж тухайн ачаанд тэнцэх эсэхийг тодорхойлуулна.

2.3.7.2. Ачилтад бэлтгэж байгаа бүрэлдэхүүнийг галт тэрэгний нэгэн адил хамгаалалтад авна.

2.3.7.3. Тээвэрлэх ачааны төрлөөс хамааран түүний бүрэн бүтэн байдлыг хангах, вагоны зангилаа эд ангийн байдал, элэгдэл нь хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахуйц тогтоосон хэмжээнд тохирч байгаа эсэхийг 1.3.3-р заалтад заасан байрлалын дагуу үзнэ.

2.3.7.4. ТАҮ-ийн үед илэрсэн үл тохиролтой вагоныг УЗ-аар засварлана. Засвар хийсэн технологит хугацааг ТАҮ-ийн хугацаан дээр нэмж тооцно.

2.3.7.5. Салгалтгүй урсгал засвараар засварлагдах боломжгүй, ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж чадахгүй гэмтэлтэй вагонд цахим /цаасан/ ВУ-23 маягт үүсгэн засварт салгах ёстой. Хэрэв уг вагоны тухайн гэмтлийг ТҮГ (ТҮХ)-т засварлах боломжгүй бол зохих засварын газарт явуулахаар цахим /цаасан/ ВУ-26 маягтыг үүсгэнэ.

2.3.7.6. Тухайн вагоныг үзсэн ачаа тээврийн ажилтан, вагон үзэгч нар цахим /цаасан/ ГУ-98А дэвтэрт бичлэг хийж, үзлэг дууссан цагийг тэмдэглэн, өртөөний жижүүртэй харилцан, тоон гарын үсгээр баталгаажуулснаар уг вагоны техникийн болон ачаа тээврийн байдал нь тухайн ачилтад тэнцэнэ /тэнцэхгүй гэсэн баталгаа болно. Вагон үзэгч нь цахим /цаасан/ ГУ- 98А дэвтэрт тухайн вагоны техникийн байдлыг тодорхойлсон тэмдэглэлийг хийхдээ “Тэнцэнэ”, “Тэнцэхгүй” гэж бичиж хаана.

2.3.7.7. Вагоны техникийн байдал нь заагдсан ачааг ачих боломжгүй боловч зарим өөр төрлийн ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж чадахуйц бол тухайн ачаанд тэнцүүлж болно. Гэхдээ вагон үзэгч нь цахим /цаасан/ ГУ-98А дэвтэрт тухайн төрлийн ачааны нэрийг зааж, бичлэг хийнэ. Жишээ нь: “Модон

материалд тэнцэнэ” гэх мэт.

2.3.7.8. Техникийн үзлэгт ороогүй эсвэл техникийн үзлэгт орсон боловч тэнцэхгүй вагоныг ачилтад тавьж өгөхийг хориглоно.

2.3.7.9. Ачааны нэр зааж ачилтад тэнцүүлсэн вагонд өөр төрлийн ачаа ачихыг хориглоно. Хэрэв дээрх вагонд өөр төрлийн ачаа ачих зайлшгүй шаардлага гарвал дахин цахим /цаасан/ ГУ-98А дэвтэрт тэмдэглэл хийж, техникийн үзлэгт оруулна.

2.3.7.10. Тухайн вагонд ачилтад бэлтгэх үзлэг засвар хийгдэн цахим /цаасан/ ГУ-98А дэвтэрт ачилтад тэнцсэн талаар вагон үзэгч тэмдэглэл хийж гарын үсэг /цахим, тоон/ зурснаар уг вагон нь техникийн байдлаар ачаа хүрэх өртөөнд очоод буух хүртэл галт тэрэгнээс техникийн гэмтлээр салгагдаж засварлагдахгүйгээр бэлтгэгдсэний баталгаа болно.

2.3.7.11. Техникийн болон ачаа тээврийн үзлэгээр ачилтанд тэнцэхгүй вагоны гэмтлийг ТҮГ-ын ахлах үзэгч магадлан, уг вагоныг хаана засварлах талаар шийдвэр гаргаж, цахим /цаасан/ ВУ-23, цахим /цаасан/ ВУ-26 (ВУ-23Б ВУ-26Б) маягтуудыг үйлдэнэ.

Техникийн ачилтын хоёрлосон үзлэг

2.3.7.12. Өртөө болон үйлчлүүлэгч байгууллагын ачилтын захиалгаар ачаатай вагоныг буулгалтын дараа вагонд шууд ачилт хийлгэх шаардлагатай бол уг вагоныг ачаатай байдалд нь ачилтад бэлтгэж хоёрлосон үзлэг хийнэ. Хоёрлосон үзлэгээр вагон нь ачилтад тэнцсэн тохиолдолд цахим /цаасан/ ГУ-98А дэвтэрт “АЖ тэнцэнэ” гэж тэмдэглэнэ.

2.3.7.13. Вагонд хоёрлосон үзлэг хийх заавар нь хоосон вагоныг ачилтад бэлтгэх заавартай адил болно.

2.3.7.14. Тэсэрч дэлбэрэх, хялбар шатах, аюултай болон хүнсний бараа ачих вагон, нурмаг ачааг задгайгаар ачих хагас вагонд заавал хоосон байдалд ачилтад бэлтгэх үзлэг, үйлчилгээ хийнэ.

2.3.7.15. Хагас вагоноос нурмаг ачааг хөмрөгч болон бусад машин механизм ашиглан буулгасан бол уг вагоныг дараагийн ачилтанд зөвхөн хоосон байдалд нь үзлэг хийж бэлтгэнэ.

2.3.7.16. Хоёрлосон үзлэгийн явцад дараагийн ачилтад тэнцэхгүй вагон илэрвэл энэ вагоны үзэгчийн самбар дээр “Тэнцэхгүй” гэсэн бичиглэлийг шохойгоор хийх бөгөөд цахим /цаасан/ ГУ-98А дэвтэрт тэмдэглэл хийж, гарын үсэг /цахим, тоон/ зурж баталгаажуулна.

2.3.7.17. Техникийн ачилтын хоёрлосон үзлэгийн хугацаа нь хоосон вагоны ТАҮ-ийн хугацаатай нэгэн адил байна.

Вагон үзэгчгүй өртөөнд ачилтад вагон бэлтгэх

2.3.7.18. Вагон үзэгчгүй өртөөнд захиалгын дагуу ачилтад өгөх вагоныг ойролцоох ТҮГ-тай өртөөнд /Замын даргын тогтоосон тушаалын дагуу хуваарьтай өртөөнд/ техникийн үзлэгт оруулж бэлтгэнэ.

2.3.7.19. Ачилтад бэлтгэсэн вагонуудыг ачилт хийх өртөө рүү явах үед ахлах үзэгч /вагон үзэгч/ уг галт тэрэгний биечилсэн хуудсан дээр гарын үсэг зурна.

Энэ нь тухайн вагон техникийн үзлэгт орж тэнцэж, ГУ-98А цахим дэвтэрт бичлэг хийгдсэн тухай баталгаа болох бөгөөд захиалагч өртөө энэ вагонд ачаа ачуулж болох зөвшөөрөл болно. Ачилтад бэлтгэсэн вагоны мэдээлэл ачилт хийх өртөөнд АТМС-Натурка цахим программд харагдаж байгаа бол дахин цахим /цаасан/ ГУ-98А дэвтэр үзлэгт өгөхгүй.

2.3.8. Завсрын өртөөнд дуудлагаар ажиллах

2.3.8.1. Завсрын өртөөнд дуудлагаар вагон үзэгч ажиллуулах нь Замын даргын тогтоосон тушаал, шийдвэрээр зохицуулагдана.

2.3.8.2. Завсрын өртөөнд дуудлагаар ажиллах вагон үзэгчийн технологийн горим нь энэхүү технолгийн загварт нийцүүлэн боловсруулагдсан байна.

2.3.8.3. Завсрын өртөөнд дуудлагаар ажиллах вагон үзэгчид өртөөний жижүүр нь /ДСП/ өртөөний техник захирамжийн акт, замын байдал, цаг агаарын байдал, техникийн үзлэг үйлчилгээ хийх үед тухайн зам парк дээрх сэлгээний болон галт тэрэгний хөдөлгөөний талаар заавал танилцуулж гарын үсгээр баталгаажуулна.

2.3.9. Хилийн төмөр замууд дээрх галт тэрэг солилцооны технологи

2.3.9.1. Хилээр хүлээн авах галт тэргэнд хилийн төмөр замын комиссын зөвлөгөөний протокол, төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологи горимд заасан технологит хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ. АВЭД болон тушаалд заагдсан хэмжээнд авах ба 1 удаа хүлээн авсан вагон нь буцааж хүлээлгэн өгөх хүртэл засвар үйлчилгээнд хамрагдахгүй байх ёстой.

2.3.10. Радио галт тэрэг

2.3.10.1. Радио галт тэргэнд энэхүү технологийн загварын 1,2-1,6-д заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

2.3.10.2. СХИБ-ын хадгалалт, цэнэглэлт, СХИБ-ыг сүүлийн вагонд тавих, сүүлийн вагоноос авах, дахин ажиллагаатай галт тэргэнд СХИБ-ыг шилжүүлэн тавих, хоорондын замд хяналт тавих, бүртгэлийг радио галт тэргэнд ажиллах технологи горимын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.3.11. Чингэлэгийн галт тэрэг

2.3.11.1. Чингэлэгийн галт тэргэнд энэхүү технологийн загварын 1,2-1,6-д заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

2.3.11.2. Сүхбаатар-Наушки өртөөдөд хүлээн авч буй чингэлгийн тавцант вагонуудад техникийн үзлэг үйлчилгээ хийж гүйцэтгэх технологийн горимыг мөрдлөг болгон ажиллана.

2.3.12. Замын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын аж ахуйн галт тэргэнд ажиллах

2.3.12.1. Аж ахуйн галт тэрэгнүүдийг Замын даргын тогтоосон тушаал, шийдвэрээр батлагдсан схем, төлөвлөгөөний дагуу үндсэн өртөөнөөс энэхүү технологийн загварын 1.2-1.5-д заагдсан техникийн үзлэг үйлчилгээ, тоормосын туршилт гүйцэтгэн явуулна.

2.3.12.2. Цонхны ажилд дуудагдан ажиллаж буй вагон үзэгч нь өртөөний хязгаарт ажил үүрэг гүйцэтгэнэ.

2.3.12.3. Цонхтой хэсэглэлийг хязгаарлагч өртөөнд дахин техникийн үзлэг үйлчилгээ тоормос турших ажилбар гүйцэтгэх шаардлагагүй.

2.3.12.4. Цонхны ажил дууссаны дараа хязгаарлагч өртөө нь ТҮГ /ТҮХ/-тэй бол найруулагдан бэлэн болсон аж ахуйн галт тэргэнд энэхүү технологийн загварын 2.3.4-р заалтын дагуу, дуудлагаар вагон үзэгч очиж ажилласан бол 2.3.5-р заалтын дагуу техникийн үзлэг үйлчилгээ, тоормосын туршилтыг хийж гүйцэтгэнэ.

2.3.12.5. Цонхны ажил гүйцэтгэж байх үед аж ахуйн галт тэрэгний техникийн үзлэг үйлчилгээ, тоормос турших ажлыг аж ахуйн галт тэрэгний механик, зүтгүүрийн бригад хариуцна.

2.3.13. Техникийн үзлэг хийснээс хойш хүлээгдэж байгаа галт тэрэг

2.3.13.1. Өртөөнөөс явах галт тэрэг захиран хуваарилах хэлтсийн хөдөлгөөн зохицуулагч /ДНЦ/ өртөөний жижүүр /ДСП/ нарын зохицуулалтаар яваагүй тохиолдолд тухайн өртөөний жижүүр /ДСП/-нь тухайн галт тэргийг ВОХР-ын /паркын харуул/ хамгаалалтад өгч ТҮГ /ТҮХ/-ийн ажилтнуудыг дараагийн галт тэргэнд шилжин ажиллах ажлыг зохион байгуулна. Үүнд:

2.3.13.1.1. Техникийн үзлэг үйлчилгээнд орсон өртөөнөөс явах галт тэрэг удаан хугацаагаар зогсох тохиолдолд.

2.3.13.1.2. Техникийн үзлэг үйлчилгээнд орсон галт тэрэг зүтгүүр хүлээн удаан хугацаагаар зогсох тохиолдолд.

2.3.14. Өндөр, нам тавцантай замд техникийн үзлэг хийгдэх галт тэрэг

2.3.14.1. Өртөөний өндөр тавцантай зам дээр ачааны галт тэрэгний вагонд техникийн үлэг засвар хийхийг хориглоно.

2.3.14.2. Өндөр тавцантай замаар зорчигчийн галт тэрэг ирсэн тохиолдолд өндөр тавцангийн эсрэг талаар зорчигчийн галт тэрэгний вагонд техникийн үзлэг заварыг хийж гүйцэтгэнэ.

2.3.14.3. Тухайн өртөөний өөр замууд дээр ТБҮ засвар хийж гүйцэтгэсэн бүрэлдэхүүнийг өртөөний замын байдлаас шалтгаалан ДСП, ахлах үзэгч нар зөвшилцсөний үндсэн дээр өндөр тавцантай замаар татан байрлуулж болох ба тоормосын бүрэн туршилтыг вагон үзэгч нар тавцангийн эсрэг талаар хийж гүйцэтгэж явуулж болно.

2.3.14.4. Өртөөний замын байдлаас шалтгаалан ачааны галт тэрэгний вагоныг зорчигчийн нам тавцантай зам дээр вагон үзэгч нар техникийн үзлэг гүйцэтгэх тохиолдолд галт тэрэгний техникийн үзлэгийн хугацааг 20 минутаар нэмэгдүүлнэ.

2.3.14.5. Өртөөний хүлээн авах, явуулах замууд чөлөөтэй үед ачааны галт тэргийг зорчигчийн нам тавцантай замд үзэгт оруулахыг хориглоно.

2.3.15. Ачааны галт тэргэнд үзлэг хийх үед хийгдэх засварын ажлын технологийн хугацаа

2.3.15.1. Засварын технологийн хугацааг доорхи хүснэгтээр тогтоов.

№	Хийгдэх ажил	Хугацаа (хүн/мин)
1	Тоормосын шахавч солих	5
2	Авто угсраа солих	20
3	Тэргэнцрийн пүрш солих	15
4	Авто угсрааны шаантаг солих	15
5	Төгсгөлийн кран солих	10
6	Таслах кран солих	20
7	Зөөлөн хоолой солих	5
8	Агаар хуваарилагчийн гол хоолойн хэсэг солих	9
9	Агаар хуваарилагчийн ерөнхий хэсэг солих	16
10	1-р зэргийн тохируулга хийх	5
11	2-р зэргийн тохируулга хийх	7
12	3-р зэргийн тохируулга хийх	12
13	Авто дэглэм солих	9
14	Авто тохируулагч солих	15
15	Тэргэнцрийн гулсуурийн зай тохируулах	7
16	Тэргэнцрийн гулсуурийн таг солих	7
17	Магадлах шалгалт хийх	60

2.3.15.2. УЗ-ын үед эд анги солиход нөөц сэлбэг, багаж тоног төхөөрөмжийг бэлдэх бэлтгэл ажлын хугацаа нь 15 хүртэл минут байна.

2.3.15.3. Явах галт тэрэгний бүрэлдэхүүнд агаар хуваарилагч, авто дэглэм, төгсгөлийн кран, таслах кран, зөөлөн хоолой сольсоны дараа тоормосын товчилсон туршилт хийнэ.

2.3.16. Галт тэрэгний сүүлийн вагоны дохио, бэхэлгээг авах, тавих, хяналт тавих ажиллагаа

2.3.16.1. Шууд өнгөрч байгаа галт тэргэнд ХДҮ-ийг хийх үед галт тэрэгний сүүлийн дохио хэвийн байгаа эсэхэд хяналт тавьж технологийн холбоогоор албан ярилцлага хийх ба үл тохирол илэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авна.

2.3.16.2. Өртөөнд ирсэн галт тэргэнд ХДҮ-ийг хийж угтан авч зогссоны дараа галт тэрэгний сүүлийн дохио, бэхэлгээг авна.

2.3.16.3. Галт тэрэгний техникийн үзлэг үйлчилгээ дууссаны дараа ТҮГ /ТҮХ/-ийн ажлын байранд авчирч зориулалтын тавиурт байрлуулна.

2.3.16.4. Өртөөнөөс явах галт тэргэнд тоормосын туршилт хийх үед галт тэрэгний сүүлийн дохио, бэхэлгээг зориулалтын дагуу байрлуулна.

2.3.17. Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн болон товчилсон туршилтын технологи горим

2.3.17.1. Явах ачааны галт тэрэгний вагонуудын автомат тоормосын хэвийн ажиллагааг шалгахын тулд тоормосын бүрэн болон товчилсон туршилтыг гүйцэтгэнэ.

2.3.17.2. Галт тэрэгний бүрэлдэхүүнд зүтгүүр холбогдон зөөлөн хоолой залгаж, төгсгөлийн краныг нээсэн цаг нь бүрэлдэхүүнд зүтгүүр орсон цаг болох бөгөөд энэ мөчөөс тоормосын бүрэн болон товчилсон туршилт эхэлнэ.


2.3.17.3. Бүрэлдэхүүнд зүтгүүр орсон цагийг зөөлөн хоолой холбож, төгсгөлийн кран нээсэн цагаар, тоормос шалгаж эхэлсэн цагийг сэрээлт өгсөн цагаар тооцно. / Вагон үзэгч тухайн галт тэргэнд шууд тоормос шалгах боломжгүй тохиолдолд энэхүү заалтыг мөрдөж ажиллана/

2.3.17.4. Галт тэргэнд тоормосын бүрэн туршилтыг сэлгээний зүтгүүр, хосын хоёр дахь зүтгүүрээр хийсэн тохиолдолд суурийн хийн төхөөрөмжөөр ТБТ хийсэнтэй нэгэн адилаар тооцно.

2.3.17.5. Тоормосын бүрэн туршилт

2.3.17.5.1. Өртөөнөөс явах галт тэрэгний тоормосын ажиллагааг шалгах тоормосын бүрэн туршилтыг АТАЗ-ын 4.2-д заагдсан тохиолдлуудад дараах технологийн дагуу гүйцэтгэнэ.

Зураг 5. Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг хийх замнал



Хүснэгт 6. Тоормосын бүрэн туршилтыг гүйцэтгэх ажиллагааны дэс дараалал

Ажилбар дараалал	Үйлдэл	Гүйцэтгэх ажилтан	Мэргэж /зэрэг/	Багаж хэрэгсэл	ХАБЭА
№1	Бүрэлдэхүүнд зүтгүүрийг холбоно.	ДСП, ТЧМ, 1-р үзэгч	-	-	
№2	Бүрэлдэхүүн дэх вагоны тоормосын хийн сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	
№3	Хурд хэмжигчийн туузыг татаж, гол хоолойн сэрээлтийг бичихэд бэлтгэнэ.	ТЧМ	-	-	
	Сүүлийн вагоны төгсгөлийн краныг нээж, гол хоолойн агаарын даралтыг 0 болгоно.	2-р үзэгч	IV, V	Гараар	
	Машинч краныг 3-р байдалд тавина.	ТЧМ	-	-	
	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж сойж байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	
№4	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	
№5	Сүүлийн вагонд ирж байгаа агаарын даралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	манометр	
№6	Галт тэрэгний вагоны сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ, 1-р үзэгч	IV, V	-	
№7	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	
	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	
	Галт тэрэгний вагоны тоормосын ажиллагааг шалгана.	1, 2-р үзэгч	IV, V	-	
	Сүлжээний нягтыг дахин шалгана.	ТЧМ	-	-	
№8	Вагон үзэгч нар мэдээлэл солилцоно.	1, 2-р үзэгч	IV, V	-	
№9	Тоормос суллах дохио өгнө.	1, 2-р үзэгч	IV, V		

	Галт тэрэгний вагоны тоормосыг суллана.	Машинч	-	-	
	Тоормосын суллалтын ажиллагааг шалгана.	1, 2-р үзэгч	IV, V	-	
	Галт тэргийг явуулж болох тухай мэдэгдэнэ.	2-р вагон үзэгч	IV, V	-	
№10	Тоормосын хангамжийн тооцоо хийнэ.	1-р вагон үзэгч	IV, V	Тооны машин	
	ВУ-45 маягтыг бичиж, машинчид гардуулна.	1-р вагон үзэгч	IV, V	-	
	ВУ-45 маягтыг шалгаж, хүлээн авна.	Машинч	-	-	

Тайлбар:

1. Галт тэрэгний вагонд тоормосын бүрэн туршилт гүйцэтгэсний дараа 1-р вагон үзэгч нь ВУ-45 маягтыг журмын дагуу 2-4 хувь үйлдэж, зүтгүүрийн машинчаар шалгуулан гарын үсгээр нь баталгаажуулж, 1-3 хувийг машинчид өгнө.
2. Галт тэрэгний вагон тооноос хамаарч галт тэрэгний тоормосын бүрэн туршилт хийх хугацааг доорх хүснэгтэнд зааснаар тогтооно.
3. Замын даргын 2022 оны 04 сарын 28-ний өдөр баталсан А/357 тоот тушаалын 4.26-р заалтад заагдсаны дагуу галт тэрэгний бүрэлдэхүүн 200-250 голтой бол толгойн хэсгийн вагонуудын 15 хувь, 251-ээс дээш голтой бол 25 хувийг агаар хуваарилагчийн аясын дэглэмийг “Уулын” байдалд тавина. 200 ба түүнээс дээш голтой галт тэрэгний тоормосын туршилт гүйцэтгэхийн өмнө эхний вагоны агаар хуваарилагчийн аясын дэглэмийг уул “Г” шилжүүлж тавих хугацааг 3 хүртэл минутаар тоормосын бүрэн туршилт хийх технологит хугацаан дээр нэмж тооцно.
4. Тоормосын бүрэн туршилтын үед тоормосын төхөөрөмжийн гэмтэлтэй вагонд засвар үйлчилгээ гүйцэтгэхийг хориглоно.
5. Тоормос туршсаны дараа болон техникийн үзлэгийн үед засварлана.
6. 5Тоормосын төхөөрөмжинд засвар үйлчилгээ гүйцэтгэсний дараа АТАЗ-ын 4.3-ыг мөрдлөг болгож тоормосын товчилсон туршилт гүйцэтгэнэ.
7. Өртөөнөөс явах ачаа-зорчигчийн галт тэрэгний тоормосын хангамж тооцох ВУ-45 маягтыг тооцоолох үед галт тэрэгний жингийн 100 тонн тутамд тоормосын шаардагдах шахалтыг 33-28-ын хооронд байгаа тохиолдолд зорчигчийн вагоны голыг хааж явуулна.

Хүснэгт 7. Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг вагон тоо, аялах замын сунгуу уруудуураас хамааруулан гүйцэтгэх технологит хугацаа

Аялах замын уруудуур	Вагон үзэгчийн тоо	Вагоны тоо /хүртэл/								
		5	10	20	30	40-60	70	80	81-100	-
		Томъёолсон урт /хүртэл/								
		5	10	20	30	40-60	70	80	81-100	100-120
		Тоормосын бүрэн туршилт хийх хугацаа /хүртэл/ (мин)								
18%-аас их	1	36	41	48	54	70	78	86	-	-
	2	35	37	39	41	43	-	-	-	-
18% хүртэл	1	28	33	40	46	62	70	78	-	-
	2	27	29	31	35	40	40	45	60	80
-	4	-	-	-	-	-	-	-	35	45


Хүснэгт 8. Ачааны галт тэргэнд тоормосын бүрэн туршилт хийх технологийн горим /1-80 вагонтой/

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлээр	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							10	20	30	40	50
1	Бүрэлдэхүүнд зүтгүүр холбоно.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Бүрэлдэхүүний тоормосын сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	8 7					
3	Төгсгөлийн кран нээж тоормосын гол хоолойн даралтыг 0 болгоно.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нээх ба мулгарч, харвах, цохигдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэргэжилнэ.	2					
4	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	6 5					
5	Сүүлийн вагонд манометр тавьж гол хоолойн даралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	Мано метр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нээж байрлуулсны дараа хрвыг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мулгарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад бэлэн ажиллана.	1					
6	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эртэнээ црхихоос болгоомжилно.	-					
7	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ, 1-р үзэгч	IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	4 3					
8	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгсээр өгнө. Энэ үед халтыг ирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	-					
9	Бүрэлдэхүүний тоормосыг бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
10	Зааврын дагуу хүлээнэ.	-	-	-	-	2					
11	Бүрэлдэхүүний тоормосын барилтыг шалгана.	1, 2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	2 - 10					
12	Бүрэлдэхүүний сүлжээний нягт шалгана.	ТЧМ	-	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
13	Бүрэлдэхүүний дунд уулзаж мэдээлэл солилцох, тоормос суллах дохио өгнө.	1, 2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	1					
14	Бүрэлдэхүүний тоормосын суллалтыг шалгана.	1, 2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	1 - 8					
15	ВУ-45 маягтыг олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	Радио станц	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
16	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	1-р үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3					
НИЙТ ХУГАЦАА						27 - 45					

Тайлбар: — 1-60 түүнээс дээш вагонтой
— 61-80 хүртэл вагонтой

2.3.11.3.3. Томъёолсон уртаар 81-ээс дээш вагонтой ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг 2 вагон үзэгч доорх тохиолдолд Зураг №7 заагдсан технологийн дагуу гүйцэтгэж болно.

Зураг №7. Галт тэрэгний давхцалын улмаас 81-ээс дээш томъёолсон вагон урттай ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилт хийх замнал.



Галт тэрэгний урт 81-100 томъёолсон вагон байгаа тохиолдолд тоормосын бүрэн туршилтыг 2 вагон үзэгч 60 минутад багтаан гүйцэтгэх ба галт тэрэгний томъёолсон урт 100 вагоноос илүү гарсан вагон бүрд 1 минут нэмэгдүүлэн тооцно.

Тайлбар:

1. Галт тэрэгний толгойн хэсэгт байрлаж байгаа вагонд /бүрэлдэхүүний 25%-тай тэнцэх/ агаар хуваарилагчийн аясын дэглэмийг “Уулын” дэглэмд тавина.
 2. Галт тэрэгний автомат тоормосыг арчлахдаа бүрэлдэхүүний 4 вагон тутамд 1 вагоны авто тоормосыг салгаж “ТЗ-ын хөдлөх бүрэлдэхүүний автомат тоормосыг ашиглах заавар”-ын 4, 5, 10-р бүлгийг мөрдөж ажиллана. Вагоны авто тоормосыг салгахдаа “Уулын” дэглэмд тавигдсан вагоноос хойшхи вагонд салгана.
 3. Галт тэрэгний сүүлийн 2 вагоны авто тоормос ажиллагаатай байна.
 4. ТАЖ-ийн 14.5.4 заалтад заасны дагуу вагоны авто тоормосыг салгасан тохиолдолд ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж, авто тоормосыг салгаж явуулах вагоны тоонд оруулан тооцно.
 5. Завсрын өртөөнд галт тэргэнд дахин ажиллагаа хийгдэж вагон салгасан тохиолдолд тоормосын товчилсон туршилтыг сүүлийн 2 вагоны тоормосын ажиллагаагаар, вагон нэмсэн тохиолдолд ирсэн бүрэлдэхүүний сүүлийн 2 вагон болон сүүл хэсэгт нэмж залгасан вагоныг оролцуулан гүйцэтгэнэ.
- Жич: Өртөөнд 60 вагонтай ирсэн галт тэрэгний бүрэлдэхүүнд 30 вагон нэмж 90 вагонтай болсон тохиолдолд тоормосын бүрэн туршилт хийж эхний вагоны Уулын дэглэмийг нэмж тавьж, 4 вагон тутмын 1 вагоны авто тоормосыг салгана.

Галт тэрэгний урт 81-100 томъёолсон вагон байгаа тохиолдолд тоормосын бүрэн туршилтыг 2 вагон үзэгч 60 минутад багтаан гүйцэтгэх технологи горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан		Хугацаа (мин)	Хугацаа (мин)											
					5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
1	Вагонуудын тоормосыг урьдчилан бэлтгэх	1, 2-р үзэгч	Вагон үзэгч нар галт тэрэгний толгойн хэсгийн вагонуудын агаар хуваарилагчийг “Г” дэглэмд тавих, бүрэлдэхүүний ¼-ийн тоормосыг салгах;	Урьдчилан бэлтгэнэ.												
2	Бүрэлдэхүүнд зүтгүүр холбох;	ДСП ТЧМ	АТАЗ	-												
3	Бүрэлдэхүүний тоормосын сүлжээг цэнэглэх;	ТЧМ	АТАЗ	8												
4	Тоормосын гол хоолойг үлээлгэх;	ТЧМ 2-р үзэгч	Машинч краны бариулыг 3-р байдалд тавина. Галт тэрэгний хамгийн сүүлийн төгсгөлийн краныг нээж тоормосын гол хоолойн даралтыг 0 болгоно.	2												
5	Тоормосын сүлжээг дахин цэнэглэх;	ТЧМ		6												
6	Тоормосын гол хоолойн даралтыг шалгах;	2-р үзэгч	Сүүлийн вагоны зөөлөн хоолой дээр манометр тавьж, төгсгөлийн краныг нээж гол хоолойн даралтыг шалгана.	-												


			суллалт, шахавч хос дугуйнаас хөндийрсөн эсэхийг шалгана																
15	Галт тэрэгний тоормосыг дахин бариулах;	1, 2-р үзэгч	Вагон үзэгч нар тоормос бариулах дохио өгнө. Машинч АТАЗ-ын дагуу тоормосыг бариулна.	-															
16	Технологийн дагуу хүлээх;	Үзэгч нар	Тоормос бариулсны дараа 2 минут хүлээж, машинчид тоормос суллах дохио өгнө.	2															
17	Галт тэрэгний тоормосыг суллах;	ТЧМ	АТАЗ	1															
18	Бүрэлдэхүүний тоормосын суллалтыг шалгах;	1, 2-р үзэгч	Галт тэрэгний үлдсэн хэсгийн вагоны тоормосын суллалт, шахавч хос дугуйнаас хөндийрсөн эсэхийг шалгана.	7															
19	Галт тэргийг явуулах дохио өгөх;	2-р үзэгч	Сүүлийн хэсгийн вагон үзэгч вагонуудын тоормос хэвийн суларсан бол 1-р вагон үзэгчид мэдэгдэл өгнө.	-															
20	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	1-р үзэгч ТЧМ	Вагон үзэгч тоормосын хангамжийн тооцоо хийж ВУ-45 маягт үйлдэж машинчид гардуулна. Машинч ВУ-45 маягтыг зөв эсэхийг шалгаад галт тэрэгний тоормос бариатай байх үед тоормосын сүлжээний нягтыг шалгасан үр дүнг тэмдэглэн, гарын үсэг зурж, маягтын 2-3 хувийг авна. Үлдсэн хувиудыг вагон үзэгчид өгнө.	3															
Нийт хугацаа				60															

2.3.11.4. Тоормосын товчилсон туршилт

2.3.11.4.1. Өртөөнд галт тэрэгний автомат тоормосыг бүрэн туршснаас хойш 30 минутаас дээш хугацаа өнгөрсөн, өртөөнд ирснээс хойш 30 минутаас дээш хугацаа өнгөрсөн галт тэргийг явахын өмнө товчилсон туршилтыг АТАЗ-ын 4.3.1-ийн “Д” заалтаар хийнэ. Уг галт тэрэг 2 цаг хүртэл хугацаагаар зогсвол зааврын дагуу 4 удаа хийх шаардлага гардаг тул дээрх үйлдлийг хялбарчлах үүднээс галт тэргийг явахын өмнө тоормосын сүлжээний нягтыг ТЧМ, вагон үзэгч нар хамтран шалгаж сүүлийн 2 вагоноор товчилсон туршилтыг гүйцэтгэж болно. Энэ үед тоормосын товчилсон туршилт хийх захирамжийг өртөөний жижүүр /ДСП/ өгнө.

2.3.11.4.2. Галт тэрэгний вагоны тоормосын ажиллагааг шалгах тоормосын товчилсон туршилтыг АТАЗ-ын 4.3-д заагдсан тохиолдлуудад дараах технологийн дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

Зураг 8. Ачааны галт тэрэгний тоормосын товчилсон туршилтыг хийх замнал



Хүснэгт 9. Тоормосын товчилсон туршилтыг гүйцэтгэх ажиллагааны дэс дараалал

Ажилбар дугаар	Үйлдэл	Гүйцэтгэх ажилтан	Мэргэж/зэрэг	Багаж хэрэгсэл
№1	Галт тэрэгний тоормосын сүлжээний нягтыг шалгана.	Машинч 1-р үзэгч	-	-
№2	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-
	Тоормос бариулна.	Машинч	-	-
	Сүүлийн 2 вагоны тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-
№3	Тоормос суллах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-
	Тоормос суллана.	Машинч	-	-
	Сүүлийн 2 вагоны тоормосын суллалтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-
	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар
	Галт тэрэг явуулж болох тухай мэдэгдэл өгнө.	2-р үзэгч	IV, V	-
№4	ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж, машинчид гардуулна.	1-р үзэгч Машинч	IV, V	-

Хүснэгт 10. Галт тэрэгний бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй үед хийх тоормосын товчилсон туршилтын технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)			
							5	10	15	20
1	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгслээр өгнө. Энэ үед хальтирч унах, бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	-				
2	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харъяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-				
3	Зааврын дагуу хүлээх, төгсгөлийн краны бэхэлгээ шалгана.	2-р үзэгч	IV, V	-	-	2				
4	Сүүлийн 2 вагоны тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	2				
5	Тоормос суллах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	1				
6	Тоормос суллана.	ТЧМ	-	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	2				
7	Сүүлийн 2 вагоны тоормосын суллалтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	2				
8	ВУ-45 маягтыг олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	Радио станц	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1				
9	ВУ-45 маягтанд тэмдэглэл хийнэ.	1-р үзэгч	IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2				
	НИЙТ ХУГАЦАА					10				

Тайлбар:

1. Галт тэрэгэнд тоормосын бүрэн туршилт хийснээс хойш бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй тохиолдолд мөрдөнө.
2. Вагон үзэгч нар тоормосын товчилсон туршилт гүйцэтгэж, галт тэрэг өртөөнөөс явах үед явуут дунд хяналт тавина, хэрхэн өнгөрсөн талаар /НТГ-ын Хавсралт №1 1.2-р заалт/ заагдсаны дагуу ДСП-д мэдэгдэнэ.

Хүснэгт 11. Галт тэрэгнээс вагон салгасан үед тоормосын товчилсон туршилт хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							5	10	15	20	25
1	Бүрэлдэхүүнийг хамгаалалтанд авна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Сүүлийн вагоны дохио, төгсгөлийн краны бэхлэгээг шилжүүлнэ.	2-р үзэгч	IV, V	-	Төгсгөлийн краны бэхлэгээ, сүүлийн дохиог авах болон байрлуулахдаа бударч тээглэх аюулаас сэргэмжилнэ.	3					
3	Сүүлийн вагоны төгсгөлийн краныг нээж сэрээлт өгнө. (10 секунд)	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нэх ба мулгарч, харвах, цохихдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэргэмжилнэ.	2					
4	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эртхэнээ цохихоос болгоомжилно.						
5	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтирч унах, бударч тээглэх аюулаас сэргэмжилнэ.	1					
6	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.						
7	Зааврын дагуу 2 минут хүлээж, сүүлийн хоёр вагоны тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбегийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэмжилнэ.	3					
8	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ	-	-	-	-					
9	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбегийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэмжилнэ.	1					
10	Бүрэлдэхүүний тоормосыг суллана.	ТЧМ	-	-							
11	Бүрэлдэхүүний сүүлийн 2 вагоны тоормосын суллалтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбегийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэмжилнэ.	2					
12	ВУ-45 маягтыг олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	Радио станц	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1					
13	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	1-р үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2					
	НИЙТ ХУГАЦАА					15					

Тайлбар:

1. Галт тэргэнд тоормосын бүрэн туршилт хийгдсэнээс хойш ямар нэгэн шалтгаанаар бүрэлдэхүүний сүүлээс вагон салгасан тохиолдолд мөрдөнө.
2. Галт тэрэгний бүрэлдэхүүнээс вагоныг өртөөний ажилтан салгаж, 10 метрээс багагүй зайд бэхэлсний дараагаар вагон үзэгч явах галт тэрэгний сүүлийн 2 вагоны тоормосын ажиллагаагаар тоормосын товчилсон туршилт хийнэ.

Хүснэгт 12. Галт тэрэгний бүрэлдэхүүнд вагон нэмж залгасан үед тоормосын товчилсон туршилт хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							5	10	15	20	25
1	Бүрэлдэхүүнийг хамгаалалтанд авна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Вагон залгасан хэсгийн автомат угсрааны холболтыг шалгана.	А.үзэгч	V, VI	Шурганы лоом	Хамгаалалтанд бүрэн авсны дараа авто угсрааны холболтыг шалгана. Зам төмөр дээр бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	2					
3	Сүүлийн вагоны дохио, төгсгөлийн краны бэхэлгээг шилжүүлнэ.	2-р үзэгч	IV, V	-	Төгсгөлийн краны бэхлэгээ, сүүлийн дохиог авах болон байрлуулахдаа бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	3					
4	Сүүлийн вагоны төгсгөлийн краныг нээж сэрээлт өгнө. (10 секунд)	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нээх ба мултарч, харвах, цоогдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэргэжилнэ.	1					
5	Сүүлийн вагонд манометр тавьж г/хоолойн даралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой болон манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад болон ажиллана.	2					
6	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохихоос болгоожилно.						
7	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	Зөөлөн хоолой болон манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад болон ажиллана.	1					
8	Тоормос бариулна.	ТЧМ	-	-							
9	Зааврын дагуу 2 минут хүлээж, нэмж залгасан вагоны өмнөх 2 вагоныг оролцуулан тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-		4					
10	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ, 1-р үзэгч	IV, V	-							
11	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	Тоормос суллах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	1					
12	Бүрэлдэхүүний тоормосыг суллана.	ТЧМ	-	-							
13	Бүрэлдэхүүний тоормосын сулралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийж ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	3					
14	ВУ-45 маягтыг олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	Радио станц	Галт тэрэгний зүтүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө	1					
15	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	1-р үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө	2					
	НИЙТ ХУГАЦАА					20					


Тайлбар:

1. Галт тэрэгэнд тоормосын бүрэн туршилт хийснээс хойш бүрэлдэхүүний сүүлд вагон нэмсэн тохиолдолд мөрдөнө.
2. Дөрөв дэх үйлдэл болох сэрээлтийг 10 секундын турш төгсгөлийн краныг нээж өгнө.
3. Галт тэрэгний бүрэлдэхүүнд вагоныг холбож сэлгээний ажил дууссаны дараагаар залгасан бүлэг вагон болон ирсэн бүрэлдэхүүний сүүлийн хоёр вагоныг оролцуулсан тоормосын товчилсон туршилт хийнэ.

2.3.11.5. Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг нэг вагон үзэгч гүйцэтгэх

2.3.11.5.1. Өртөөнөөс явах галт тэрэгний тоормосын ажиллагааг шалгах тоормосын бүрэн туршилтыг нэг вагон үзэгч дараах технологийн дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

Зураг 9. Ачааны галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг нэг вагон үзэгч гүйцэтгэх замнал



Хүснэгт 13. Тоормосын бүрэн туршилтыг нэг вагон үзэгч гүйцэтгэх ажиллагааны дэс дараалал

Ажилбар дэс дараа	Үйлдэл	Гүйцэтгэх ажилтан	Мэргэж зэрэг	Багаж хэрэгсэл	ХАБЭА
№1	Бүрэлдэхүүнд зүтгүүрийг холбоно.	ДСП, ТЧМ	-	-	
№2	Бүрэлдэхүүн дэх вагоны тоормосын хийн сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	
№3	Хурд хэмжигчийн туузыг татаж, гол хоолойн сэрээлтийг бичихэд бэлтгэнэ.	ТЧМ	-	-	
	Сүүлийн вагоны төгсгөлийн краныг нээж, гол хоолойн агаарын даралтыг 0 болгоно.	В.үзэгч	IV, V	Гараар	
	Машинч краныг 3-р байдалд тавина.	ТЧМ	-	-	
	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	В.үзэгч	IV, V	Гараар	
№4	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	
№5	Сүүлийн вагонд ирж байгаа агаарын даралтыг шалгана.	В.үзэгч	IV, V	Манометр	
№6	Галт тэрэгний вагоны сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ, В.үзэгч	IV, V	-	
№7	Тоормос бариулах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	
	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	
	Галт тэрэгний вагоны тоормосын ажиллагааг шалгана.	В.үзэгч	IV, V	-	
	Сүлжээний нягтыг дахин шалгана.	ТЧМ	-	-	
№8	Тоормос суллах дохио өгнө.	В.үзэгч			
	Галт тэрэгний вагоны тоормосыг суллана.	ТЧМ			

	Тоормосын суллалтын ажиллагааг шалгана.	В.үзэгч			
№9	Тоормосын хангамжийн тооцоо хийнэ.	В.үзэгч			
	ВУ-45 маягтыг бичиж, машинчид гардуулна.	В.үзэгч			
	ВУ-45 маягтыг шалгаж, хүлээн авна.	ТЧМ			

Хүснэгт 14. Тоормосын бүрэн туршилтыг нэг вагон үзэгч гүйцэтгэх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэж/зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							10	20	30	40	50
1	Бүрэлдэхүүнд зүтгүүр холбоно.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Бүрэлдэхүүний тоормосын сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	8					
3	Төгсгөлийн кран нээж тоормосын гол хоолойн даралтыг 0 болгож хаана.	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нээх ба мулгарч, харах, цохихдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэрэмжилнэ.	2					
4	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	6					
5	Сүүлийн вагонд манометр тавьж гол хоолойн даралтыг шалгана.	В.үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нээж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мулгарч, харах аюулаас сэрэмжилнэ. Болгоолгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад болон ажиллана.	1					
6	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохихоос болгоомжилно.	-					
7	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ, В.үзэгч	IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	4					
8	Тоормос бариулах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтирч унах, бүүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	-					
9	Бүрэлдэхүүний тоормосыг бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
10	Зааврын дагуу хүлээнэ.	-	-	-	-	2					
11	Бүрэлдэхүүний тоормосын барилтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбегийн хайрцаг, докиолол холбооны хэрэгсэлд бүүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	10					
12	Бүрэлдэхүүний сүлжээний нягт шалгана.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
13	Бүрэлдэхүүний тоормос суллах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	Тоормос суллах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтирч унах, бүүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	1					
14	Бүрэлдэхүүний тоормосын суллалтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбегийн хайрцаг, докиолол холбооны хэрэгсэлүүдэд зэрэгт бүүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	9					
15	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	В.үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3					
	НИЙТ ХУГАЦАА					45					

Тайлбар:

- 200-аас дээш голтой галт тэргэнд тоормосын бүрэн туршилт хийх хугацаа 10 хүртэл минутаар нэмэгдэнэ.

Хүснэгт 15. Галт тэрэгний бүрэлдэхүүнд вагон нэмж залгасан үед тоормосын товчилсон туршилт хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)					
							5	10	15	20	25	30
1	Бүрэлдэхүүнийг хамгаалалтанд авна.	ДСП, В.үзэгч	V, VI	Пульт	Харъяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-						
2	Вагон залгасан хэсгийн автомат угсрааны холболтыг шалгана.	В.үзэгч	V, VI	Шурганы лоом	Хамгаалалтанд бүрэн авсны дараа авто угсрааны холболтыг шалгана. Зам төмөр дээр бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	2						
3	Сүүлийн вагоны дохио, төгсгөлийн краны бэхэлгээг шилжүүлнэ.	В.үзэгч	IV, V	-	Төгсгөлийн краны бэхлэгээ, сүүлийн дохиог авах болон байрлуулахдаа бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	3						
4	Сүүлийн вагоны төгсгөлийн краныг нээж сэрээлт өгнө. (10 секунд)	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нээх ба мултарч, харвах, цогихдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэргэжилнэ.	1						
5	Сүүлийн вагонд манометр тавьж гол хоолойн даралтыг шалгана.	В.үзэгч	IV, V	Мано метр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад бэлэн ажиллана.	1						
6	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	В.үзэгч	IV, V	Гараар								
7	Тоормос бариулах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	Зөөлөн хоолой болон манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад бэлэн ажиллана.	1						
8	Тоормос бариулна.	ТЧМ	-	-								
9	Зааврын дагуу 2 минут хүлээж, нэмж залгасан вагоны өмнөх 2 вагоныг оролцуулан тоормосын барилтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-		4-8						
10	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ	-	-								
11	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	Тоормос суллах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	1						
12	Бүрэлдэхүүний тоормосыг суллана.	ТЧМ	-	-								
13	Бүрэлдэхүүний тоормосын суллалтыг шалгаж зүтгүүрт ирнэ.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг заавар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбигийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	9						
14	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	В.үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2						
НИЙТ ХУГАЦАА						24-28						

8-р үйлдэл нь → 10 хүртэл вагон нэмсэн – 4 минут
11-20 хүртэл вагон нэмсэн – 6 минут
21-30 хүртэл вагон нэмсэн – 8 минут

Тайлбар:

1. Ес дахь үйлдэл болох тоормосын барилтыг нэмсэн вагон тооноос хамаарч хугацаа 4-8 минут байна.
2. Нэмж байгаа вагонуудыг урьдчилан техникийн үзлэгт оруулсан байх ёстой.

Хүснэгт 16. Галт тэрэгний бүрэлдэхүүнээс вагон салгасан үед тоормосын товчилсон туршилт хийх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							5	10	15	20	25
1	Бүрэлдэхүүнийг хамгаалалтанд авна.	ДСП, В.үзэгч	V, VI	Пульт	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Сүүлийн вагоны дохио, төгсгөлийн краны бэхлэгээг шилжүүлнэ.	В.үзэгч	IV, V	-	Төгсгөлийн краны бэхлэгээ, сүүлийн дохиог авах болон байрлуулахдаа бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	3					
3	Сүүлийн вагоны төгсгөлийн краныг нээж сэрээлт өгнө. (10 секунд)	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийгнэх ба мулгарч, харваа, цохихдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэрэмжилнэ.	1					
4	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохихоос болгоомжилно.	-					
5	Тоормос бариулах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгслээр өгнө. Энэ үед хальтирч унах, бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	1					
6	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.						
7	Зааврын дагуу 2 минут хүлээж, сүүлийн хоёр вагоны тоормосын барилтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Эртөнций замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	4					
8	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ	-	-	-	-					
9	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Эртөнций замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	1					
10	Бүрэлдэхүүний тоормосыг суллана.	ТЧМ	-	-							
11	Бүрэлдэхүүний тоормосын суллалтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	1					
12	Зүтгүүрт ирж тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	В.үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	9					
НИЙТ ХУГАЦАА						20					

Тайлбар:

- 200-аас дээш голтой галт тэргэнд тоормосын туршилт хийх хугацаа 5 хүртэл минутаар нэмэгдэнэ.

2.3.11.6. Хийн суурин төхөөрөмжөөр бүрэлдэхүүнд тоормосын туршилт хийх

2.3.11.6.1. Суурин хийн төхөөрөмжөөр галт тэрэгний вагоны автомат тоормосын бүрэн туршилтыг урьдчилан энэхүү технологийн хүснэгт 0-д заагдсаны дагуу гүйцэтгэх ба бүрэлдэхүүнд зүтгүүр холбосны дараа тоормосын товчилсон туршилтыг хүснэгт 0-д заагдсаны дагуу гүйцэтгэнэ.

2.3.11.6.2. Хэрэв суурин хийн төхөөрөмжөөр тоормосын бүрэн туршилт хийснээс хойш 2 цагаас дээш хугацаа өнгөрсний дараа уг бүрэлдэхүүнд зүтгүүр орсон бол тоормосын бүрэн туршилт дахин хийнэ.

2.3.11.6.3. Суурин хийн төхөөрөмжийг ТҮГ-ын тусгай эрх бүхий үнэмлэхтэй ахлах үзэгч/вагон үзэгч/ ажиллуулна.

**Бүрэлдэхүүнд тоормосын туршилт хийх
(машинчийн кранаар удирдах)**

Тоормосын туршилт

2.3.11.6.4. Тоормосын туршилт хийх үед тэжээлийн нөөц савны даралт 7,0 кгс/см-аас багагүй байх ёстой. Тоормосын гол хоолойн даралтыг 5,0-5,5 кгс/см²-р тохируулна.

Тоормосын гол хоолойг үлээлгэх

2.3.11.6.5. Суурин хийн төхөөрөмжийг бүрэлдэхүүний төгсгөлд холбосон тохиолдолд сэрээлтийг бүрэлдэхүүний нөгөө төгсгөлд өгнө.

2.3.11.6.6. Хэрэв бүрэлдэхүүний дунд холбосон бол сүүл, толгойн вагоны төгсгөлийн краныг нээж, гол хоолойн агаарын даралтыг 0 болгоно.

Тоормос бариулах үед

2.3.11.6.7. Бүрэлдэхүүний тоормосын гол хоолойг суурин хийн шугамын гол хоолойд залгаж, бүрэн цэнэглэсний дараа /7-оос доошгүй минут болоод/ тоормос шалгах вагон үзэгчийн шаардлагаар ахлах үзэгч нь (оператор) машинчийн краныг 5-р байдалд тавьж тэнцүүлэх савны даралтыг 0,5-0,6 кгс/см²-р бууруулаад краны бариулыг 4-р байдалд шилжүүлэн тоормосыг бариулна. Үүний зэрэгцээ гол хоолойн даралт тэнцүүлэх савны даралттай ижил хэмжээгээр унаж байгааг хянана.

Тоормос суллах үед

2.3.11.6.8. Ахлах үзэгч нь (оператор) вагон үзэгчийн мэдэгдсэний дагуу тоормосыг суллахдаа машинчийн краны бариулыг 2-р байдалд тавьж суллана.

Хүснэгт 17. Суурин хийн төхөөрөмжөөр урьдчилан тоормосын бүрэн туршилт хийсэн бүрэлдэхүүнд зүтгүүр орсны дараа тоормосын тоормосын товчилсон туршилт хийх технологийн горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэж/зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							5	10	15	20	25
1	Бүрэлдэхүүнд зүтгүүр холбоно.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Бүрэлдэхүүний тоормосын сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	7					
3	Төгсгөлийн кран нээж тоормосын гол хоолойн даралтыг 0 болгоно.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нэхх ба мултарч, харвах, цоогдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэргэжилнэ.	2					
4	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	5					
5	Сүүлийн вагонд манометр тавьж гол хоолойн даралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нэхх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад бэлэн ажиллана.	1					
6	Сүүлийн вагоны зөөлөн хоолойг авто угсрааны салгах хөшүүргийн гинжинд өлгөж байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохихоос болгоомжилно.	-					
7	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ, 1-р үзэгч	IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3					
8	Тоормос бариулах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	-	-					
9	Бүрэлдэхүүний тоормосыг бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
10	Бүрэлдэхүүний сүүлийн 2 вагоны тоормосын барилтыг шалгана.	-	-	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбагийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.	2					
11	Бүрэлдэхүүний сүлжээний нягт шалгана.	ТЧМ	-	-	-	-					
12	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбагийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.	2					
13	Бүрэлдэхүүний тоормосын сулралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-							
14	ВУ-45 маягыг олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	Радио холбоо	-	-					
15	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	1-р үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3					
	НИЙТ ХУГАЦАА					25					

Тайлбар:

1. Урьдчилан сэлгээний зүтгүүрээр тоормосын бүрэн туршилт гүйцэтгэсэн бүрэлдэхүүнд зүтгүүр орсны дараа дээрх технологийн горимыг мөрдлөг болгоно.

ГУРАВ: ЗОРЧИГЧИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

- 3.1. Зорчигчийн галт тэргэнд техникийн үзлэг хийхдээ ачааны галт тэрэгний нэгэн адил хамгаалалтад авч 1 болон 2 группийн аргаар үзлэг засварын ажлыг гүйцэтгэнэ.
- 3.2. Галт тэрэгний техникийн үзлэг, тоормосын туршилтын үед ахлах вагон үзэгч галт тэрэгний дарга, мастер нартай журмын дагуу мэдээлэл солилцоно.
- 3.3. Орон нутгийн онцлог болон тухайн өртөөнд ажиллах зорчигчийн галт тэрэгний ажиллагаанаас шалтгаалан ямар төрлийн үзлэг үйлчилгээ хийхийг тухайн ТҮГ /ТҮХ/-ийнн технологи горимоор зохицуулсан байна.

3.4. Зорчигчийн галт тэргэнд ХДҮ хийх

3.4.1. Галт тэргийг хүлээн авах, үдэн гаргах, шууд өнгөрөх үе явуут дунд нь вагоны техникийн байдалд хяналт тавих үзлэгийн үед дараах үл тохирлууд байгаа эсэхэд хяналт тавина. Үүнд:

- а. Хос дугуй чирэгдэж яваа эсэх
- б. Аялалын үед хос дугуй эргэж байсан ч тоормосын шахавч хос дугуйн хооронд их хэмжээний оч гарч чийхарч дуугаран тоормос бариатай тоормосын цилиндрийн шилбэ дутуу суусан явж байгаа эсэх.
- в. Хос дугуй зам төмөрт хүчтэй цохиж яваа эсэх.
- г. Тэргэнцэр хүчтэй донсолсон, хос дугуй жигд эргэж чадахгүй байх, гүүшинд чийхарсан дуу гарч байгаа эсэх.
- д. Гүүшингийн үзлэгийн таг байхгүй, вагоны хаалга онгорхой вагон бүрэлдэхүүнд байгаа эсэх.
- е. Тоормосын хөшүүрэг, татуурга унаж чирэгдсэн эсэх.
- ё. Зөөлөн хоолой вагонуудын хооронд унжсан эсэх.
- ж. Бүрэлдэхүүний дундуур төгсгөлийн кран хаалттай яваа эсэх.
- з. Вагоны кузовын хазайлт хэмжээнээс хэтэрсэн эсэх.
- и. Авто угсрааны салгах хөшүүрэг байрнаасаа хөдөлсөн, өргөгчийн гол унжсан эсэх.
- й. Вагонд ямар нэг зүйл чирэгдэж яваа эсэх.


3.4.2. Үдэн гаргах, шууд болон дамжин өнгөрөх галт тэргэнд ХДҮ-ийг хийх үед вагонд үл тохирол илэрсэн тохиолдолд вагон үзэгч нь технологийн холбоогоор /радио станц/ ДСП-д мэдэгдэж галт тэргийг зогсоох арга хэмжээг авна. Галт тэрэг зогссоны дараа вагон үзэгч нар үл тохирол бүхий вагонд үзлэг хийж шаардлагатай шуурхай арга хэмжээг авч ажиллана.Өртөөнд ирсэн галт тэргэнд угтан авах үеийн ХДҮ-ээр илэрсэн үл тохирол бүхий вагоныг 1.2-1.6-р заалтад заагдсан техникийн үзлэг, үйлчилгээгээр нарийвчилсан үзлэг хийж шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

3.4.3. ХДҮ-ээр илрэх боломжгүй үл тохирлийг техникийн үзлэг, үйлчилгээ хийж явуулсан ТҮГ /ТҮХ/ хариуцна.

3.5. Зорчигчийн галт тэргэнд техникийн үзлэг хийх замнал.

3.5.1. Зорчигчийн галт тэрэгний вагондуудад нэг группийн зохион байгуулалтаар техникийн үзлэгийг дараах байдлаар гүйцэтгэнэ.

Зураг 10. Галт тэрэгний вагонд нэг группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх замнал




3.5.1.1. Галт тэрэгний вагонуудад хоёр группийн зохион байгуулалтаар техникийн үзлэгийг дараах байдлаар гүйцэтгэнэ.

3.5.1.2. Галт тэрэгний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар техникийн үзлэг үйлчилгээ хийх замнал нь ТҮГ /ТҮХ/-ийн ажлын байрны байршил, орон нутгийн онцлогоос шалтгаалж бүрэлдэхүүний толгой болон сүүлээс нэгэн зэрэг үзлэгийг эхлүүлж дундаа уулзах /зураг А/, бүрэлдэхүүний дундаас хоёр тийш нэгэн зэрэг үзлэгийг эхлүүлэх /зураг Б/, аль нэг групп нь толгой эсхүл сүүл хэсгээс нөгөө групп нь бүрэлдэхүүний дундаас /мөрдөх зарчимаар/ нэгэн зэрэг үзлэгийг эхлүүлэх /зураг В/ аргачлалтай байна.

3.5.1.3. Дунд уулзсан авто угсрааны найдвартай холболтыг 1-р групп хариуцна.


Зураг 11. Галт тэрэгний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх замнал



Зорчигчийн вагонд техникийн үзлэг хийх байрлал

3.5.1.4. Зорчигчийн вагоны зангилаа, эд анги хэсгүүдийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагаанд энэ технологийн загварын 1.2, 1.3-р заалтад заасан техникийн үзлэгийг дараах байрлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

Зураг 12. Зорчигчийн вагонд техникийн бүрэн үзлэг хийх байрлал.



Б талын вагон үзэгч засварчин

3.5.2. Техникийн бүрэн үзлэг /цаашид “ТБҮ” гэх/ хийх технологийн горим

3.5.2.1. Зорчигчийн галт тэргэнд ТБҮ-ийг хийж гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 3.6-р заалтад заасаны дагуу вагоны зангилаа, эд анги хэсгүүдэд нүдэнд харагдах болон өвдөглөж суусан байдлаас хийж гүйцэтгэнэ.

3.5.2.2. ТБҮ-ийг 1 группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх технологийн горим.

Хүснэгт 18. Зорчигчийн галт тэрэгний вагонд нэг группийн зохион байгуулалтаар ТБҮ хийх технологи горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)					
							10	20	30	40	50	60
1	Галт тэрэг орж ирэх тухай мэдээллэнэ.	ДСП	-	Радио станц	-							
2	Галт тэргийг утган авахад бэлтгэж, явуул дунд утган авах ажлыг гүйцэтгэнэ.	В.үзэгч нар	IV, V, VI	Гар чийдэн /шөнө/	Өртөөний зам паркар зорчихдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэмжлж, ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө.							
3	Зүтгүүр гарсны дараа бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтанд авах, цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэмжлэх, шатны баруулаас барьж явна.							
4	Вагонд ТБҮ хийнэ. Ахлах үзэгч галт тэрэгний даргатай уулзаж аялалын талаар мэдээлэл солилцоно.	В.үзэгч нар	IV, V, VI	В.ү-ийн алх, шурганы лоом	ТЗ-ын зурвас газар зорчих, г.т, вагонд үзлэг засвар хийх үеийн ААЗ-ыг мөрдөнө. Замыг хамгаалалтанд бүрэн авна. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэмжилнэ	25 35 45						
5	Техникийн үзлэгийн үед илэрсэн гэмтлийг засварлана.	В.үзэгч нар	IV, V, VI	Алх, га зов, бордок, домкрат, хасуур, бахь, түлхүүр /төр бүр/	Г.т, вагонд үзлэг, засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Тех.горимд заасны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Гараа хавчих, толгойг цохих, хөл гар дээрээ эд анги унагах, сэлбэг материал авахаар явах үед бүдэрч унах, г.т, сэлгээний хөдөлгөөний үйлчлэлд өртөхөөс сэргэмжилнэ. Алх, бордок, түлхүүр багаж нь АА-ны шаардлага хангасан байна.	10 15 20						
6	Замын хамгаалалтыг буулгаж цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих ААЗыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэмжлэх ба шатны баруулаас барьж явна.	5						
НИЙТ ХУГАЦАА						30 40 50						

Тайлбар: — 1-10 вагонтой

— 11-20 хүртэл вагонтой

— 21-27 хүртэл вагонтой

3.5.2.3. ТБҮ-ийг 2 группын зохион байгуулалтаар гүйцэтгэх технологийн горим.

Хүснэгт 19. Зорчигчийн галт тэрэгний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар ТБҮ хийх технологи горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)					
							5	10	15	20	25	30
1	Галт тэрэг орж ирэх тухай мэдээллэнэ.	ДСП	-	Радио станц	-							
2	Галт тэргийг утан авахад бэлтгэж, явуул дунд хяналт тавина.	В.үзэгч нар	IV, V, VI	Гар чийдэн /шөнө/	Өртөөний зам паркар зорчихдоо хальтйрч унах, бударч тээглэх аюулаас сэргийлж, ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө.							
3	Зүтгүүр гарсны дараа бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтанд авах, цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтйрч унах, бударч тээглэх аюулаас сэргийлж, шатны барулаас барьж явна.							
4	Вагонд ТБҮ хийнэ. Ахлах үзэгч галт тэрэгний даргатай уулзаж аялалын талаар мэдээлэл солилцоно.	В.үзэгч нар	IV, V, VI	В.үчийн алх, шурганы лоом	ТЗ-ын зурвас газар зорчих, г.т, вагонд үзлэг засвар хийх үеийн ААЗ-ыг мөрдөнө. Замыг хамгаалалтанд бүрэн авна. Өртөөний замын голд байрлах нүүр, салбэлийн хайрцаг, докилоп холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргийлнэ	15 20 25						
5	Техникийн үзлэгийн үед илэрсэн гэмтлийг засварлана.	В.үзэгч нар	IV, V, VI	Алх, газар, бордож, домкрат, хасуур, бахь, түлхүүр /төр. бүр/	Г.т, вагонд үзлэг, засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Тех. горимд заасны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Гараа хавчих, толгойг цохих, хөл гар дээрээ эд анги унагах, салбэг материал авахад явах үед бударч унах, г.т, салтзэний хөдөлгөөний үйлчлэлд өртөхөөс сэргийлнэ. Алх, бордож, түлхүүр багаж нь АА-ны шаардлага хангасан байна.	5 8 10						
6	Замын хамгаалалтыг буулгаж цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих ААЗыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтйрч унах, бударч тээглэх аюулаас сэргийлж ба шатны барулаас барьж явна.	5						
НИЙТ ХУГАЦАА							20 25 30					

Тайлбар: — 1-10 вагонтой
— 11-20 хүртэл вагонтой
— 21-27 хүртэл вагонтой

3.5.3. Техникийн хяналтын үзлэг /Цаашид “ТХҮ” гэх/ хийх технологийн горим

3.5.3.1. Зорчигчийн галт тэргэнд ТХҮ-ийг хийж гүйцэтгэхдээ энэхүү технологийн загварын 3.6-р заалтад заасны дагуу вагоны зангилаа, эд анги хэсгүүдэд нүдэнд харагдах байдлаас хийж гүйцэтгэнэ.

3.5.3.2.Эргэлтийн өртөөнд очиж ТБҮ хийгдсэн орон нутгийн зорчигчийн галт тэргэнд өртөөнөөс явахын өмнө ТХҮ-ийг хийж гүйцэтгэнэ. Энэ үед бүрэлдэхүүнд бүлэг вагон нэмэх болон салгасан тохиолдолд нэмэх болон салж үлдсэн вагонуудыг урьдчилан ТБҮ-т оруулсан байна. ТХҮ-ийн үед бүх вагоны авто угсрааны найдвартай холболтыг шурганы лоомоор шалгана.

3.5.4. Эргэлтийн өртөөнд ТБҮ хийгдэн зүтгүүр эргэж шууд явах орон нутгийн зорчигчийн галт тэргэнд явахын өмнө ТХҮ-ийг хийж гүйцэтгэхгүй.

3.5.5. Дамжин өнгөрөх өртөөнд зүтгүүр эргэж шууд явах зорчигчийн галт тэргэнд ТХҮ-ийг хийж гүйцэтгэнэ. Энэ үед бүрэлдэхүүнээс бүлэг вагон нэмэх болон салгасан байж болох нэмэх вагонуудыг урьдчилан ТБҮ-т оруулсан байна. Холбогдсон хэсгийн вагонуудын авто угсрааны найдвартай холболтыг шурганы лоомоор шалгана. Салж үлдсэн вагонуудад ТБҮ-г хийж гүйцэтгэнэ.

3.5.5.1. ТХҮ-ийг 1 группын зохион байгуулалтаар гүйцэтгэх технологийн горим.

Хүснэгт 20. Зорчигчийн галт тэрэгний вагонд нэг группийн зохион байгуулалтаар ТХҮ хийх технологи горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)					
							5	10	15	20	25	30
1	Галт тэрэг орж ирэх тухай мэдээллэнэ.	ДСП	-	Радио станц	-							
2	Галт тэргийг утган авахад бэлтгэж, явуут дунд хяналт тавина.	В.үзэгч нар	IV, V,	Гар чийдэн /шөнө/	Өртөөний зам паркаар зорчихдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлж, ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө.							
3	Зүтгүүр гарсны дараа бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтанд авах, цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркаар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлэх, шатны барулаас барьж явна.							
4	Вагонд ТХҮ хийнэ. Ахлах үзэгч галт тэрэгний даргатай уулзаж аялалын талаар мэдээлэл солилцоно.	В.үзэгч нар	IV, V,	В.ү-ийн алх, шурганы лоом	ТЗ-ын зурвас газар зорчих, г.т, вагонд үзлэг засвар хийх үеийн ААЗ-ыг мөрдөнө. Замыг хамгаалалтанд бүрэн авна. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	10 15 20						
5	Техникийн үзлэгийн үед илэрсэн гэмтлийг засварлана.	В.үзэгч нар	IV, V,	Алх, газар, бордок, домкрат, хасуур, бахь, түлхүүр /төр.бүр/	Г.т, вагонд үзлэг, засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Тех.горимд заасны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Гараа хавчих, толгойгоо цохиж, хөл гар дээрээ эд анги унагах, салбэг материал авахаар явах үед бүдэрч унах, г.т, салбэгийн хөдөлгөөний үйлчлэлд өртөхөөс сэрэмжилнэ. Алх, бордок, түлхүүр багаж нь АА-ны шаардлага хангасан байна.							
6	Замын хамгаалалтыг буулгаж цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркаар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлэх ба шатны барулаас барьж явна.	5						
НИЙТ ХУГАЦАА						15 20 25						

Тайлбар: — 1-10 вагонтай
— 11-20 хүртэл вагонтай
— 21-27 хүртэл вагонтай

Тайлбар:

1. Бүрэлдэхүүнд ТХҮ хийх хугацаанд салгалтгүй урсгал засвар хийх технологит хугацааг тооцоогүй ба салгалтгүй урсгал засвар хийсэн тохиолдолд засвар үйлчилгээ хийсэн хугацааг техникийн үзлэгийн хугацаан дээр нэмж тооцно.
2. Эргэлтийн өртөөнөөс явах галт тэрэгний технологит хугацаа нь ТХҮ болон ТБТ хийсэн нийлбэр хугацаа байна.

3.5.5.2. ТХҮ-ийг 2 группийн зохион байгуулалтаар гүйцэтгэх технологийн горим.

Хүснэгт 21. Зорчигчийн галт тэрэгний вагонд хоёр группийн зохион байгуулалтаар ТХҮ хийх технологи горим.

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлийн зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)					
							5	10	15	20	25	30
1	Галт тэрэг орж ирэх тухай мэдээллэнэ.	ДСП	-	Радио станц	-							
2	Галт тэргийг утган авахад бэлтгэж, явуул дунд хяналт тавина.	В.үзэгч нар	IV, V,	Гар чийдэн /шөнө/	Өртөөний зам паркар зорчихдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэмжилж, ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө.							
3	Зүтгүүр гарсны дараа бүрэлдэхүүн байрлах замыг хамгаалалтанд авах, цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП, А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих үеийн ААЗ-ыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэмжлэх, шатны баруулаас барьж явна.							
4	Вагонд ТХҮ хийнэ. Ахлах үзэгч галт тэрэгний даргатай уулзаж аялалын талаар мэдээлэл солилцоно.	В.үзэгч нар	IV, V,	В.ү-ийн алх, шурганы лоом	ТЗ-ын зурвас газар зорчих, г.т, вагонд үзлэг засвар хийх үеийн ААЗ-ыг мөрдөнө. Замыг хамгаалалтанд бүрэн авна. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэмжилнэ	6 8 10						
5	Техникийн үзлэгийн үед илэрсэн гэмтлийг засварлана.	В.үзэгч нар	IV, V,	Алх, газар, бордок, домкрат, хасуур, бахь, түлхүүр /тер.бур/	Г.т, вагонд үзлэг, засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Тех.горимд заасны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Гараа хавчих, толгой цохих, хөл гар дээрээ эд анги унагах, салбэг материал авахаар явах үед бүдэрч унах, г.т, салбэгийн хөдөлгөөний үйлчлэлд өртөөсөө сэргэмжилнэ. Алх, бордок, түлхүүр багаж нь АА-ны шаардлага хангасан байна.							
6	Замын хамгаалалтыг буулгаж цахим ВУ-14 дэвтэрт тоон гарын үсэг зурна.	ДСП А.үзэгч	V, VI	Пульт	Зам паркар зорчихдоо ТЗ-ын зурвас газар зорчих ААЗыг мөрдөнө. ДСП-ын өрөөнд орохдоо хальтирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэмжлэх ба шатны баруулаас барьж явна.	5						
НИЙТ ХУГАЦАА						11 13 15						

Тайлбар: 1-10 вагонтой
 11-20 хүртэл вагонтой
 21-27 хүртэл вагонтой

3.6. Зорчигчийн галт тэргэний вагонд тавигдах техникийн нэмэлт шаардлага

3.6.1. Хэлбэлзэл шингээгчийн дэгээ 2 мм-ээс дээш гүн холгогдсон, 5 мм-ээс дээш хазгай суурилагдсан, дээд доод толгойнуудын зөөлөвч резин язарсан, их хэмжээний тос гоожсон, байцаалтын хугацаа дууссан бол зорчигчийн вагоныг явуулахыг хориглоно.

3.6.2. 1970 оноос өмнө үйлдвэрлэгдсэн тээшний вагоноос бусад зорчигчийн вагон гар тоормос ажилтай байх бөгөөд гар тоормосыг бариулсны дараа шурагт голын шургийн үлдэж байгаа хэсэг нь 75 мм-ээс багагүй байна.

3.6.3. Зорчигчийн вагоны тоормосын суллах жолоо зөв тохируулагдсан бөгөөд вагоны дотор талаас чөлөөтэй татагдаж байх ёстой. Зогсоох цорго хэвийн ажилтай, ломботой байх ёстой.

3.6.4. Зорчигчийн галт тэрэг 120 км/цаг хүртэл хурдтай явдаг хуванцар шахавчаар тоноглогдсон вагоны редуктортой хос дугуйд ширмэн шахавч сольж тавихыг зөвшөөрнө.

3.6.5. Зорчигчийн галт тэргийг эргэлтийн болон найруулсан өртөөнд байх үед технологийн горимд заасны дагуу татагдсан вагоны авто угсрааны элэгдлийг тусгай царилаар шалгана. Царилын тоонолж хэлбэрийн хэсгээр залгагдсан авто угсрааны дагуу болон хөндлөн зайг хэмжнэ.

3.7. Зорчигчийн галт тэрэгний тоормосын бүрэн болон товчилсон туршилтын технологи горим

3.7.1. Явах зорчигчийн галт тэрэгний вагонуудын автомат тоормосын хэвийн ажиллагааг шалгахын тулд тоормосын бүрэн болон товчилсон туршилтыг гүйцэтгэнэ.

3.7.2. Галт тэрэгний бүрэлдэхүүнд зүтгүүр холбогдон зөөлөн хоолой залгаж, төгсгөлийн краныг нээсэн цаг нь бүрэлдэхүүнд зүтгүүр орсон цаг болох бөгөөд энэ мөчөөс тоормосын бүрэн болон товчилсон туршилт эхлэнэ.

3.7.3. Бүрэлдэхүүнд тэрэг орсон цагийг зөөлөн хоолой холбож төгсгөлийн кран нээсэн цагаар, тоормос шалгаж эхэлсэн цагийг сэрээлт өгсөн цагаар тооцно.

3.7.4. Тоормосын бүрэн туршилт

3.7.4.1. Зорчигчийн галт тэрэгний вагоны тоормосын бүрэн туршилтыг АТАЗ-ын 4.2-д заагдсан тохиолдлуудад шалгана.

Хүснэгт 22. Зорчигчийн галт тэрэгний тоормосын бүрэн турших гүйцэтгэх технологийн горим /Хоёр вагон үзэгч/

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэж/ зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)				
							5	10	15	20	25
1	Бүрэлдэхүүнд зүтгүүр холбоно.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
2	Бүрэлдэхүүний тоормосын сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3					
3	Сүүлийн вагонд манометр тавьж гол хоолойн даралтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад бэлэн ажиллана.	1					
4	Төгсгөлийн кран нээж тоормосын гол хоолойн даралтыг 0 болгоно.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нээх ба мултарч, харвах, цоигдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэргэжилнэ.	1					
5	Сүүлийн вагоны зөөлөн хоолойн толгойг тусгай сэртэнд байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохихоос болгоомжилно.	-					
6	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2					
7	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	1-р үзэгч	IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3					
8	Тоормос бариулахыг мэдэгдэнэ.	1-р үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дэхиог гар дохионы хэрэгслээр өгнө. Энэ үед хальгирч унах, бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.						
9	Бүрэлдэхүүний тоормосыг бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
10	Зааврын дагуу хүлээнэ.	1, 2-р үзэгч	IV, V	-	-	2					
11	Бүрэлдэхүүний тоормосын барилт шалгана.	1, 2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	3-8					
12	Дунд уулзаж мэдээлэл солилцоно.	1, 2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	-					
13	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	1-р үзэгч	IV, V	-	-	-					
14	Бүрэлдэхүүний тоормосын сулралтыг шалгана.	1, 2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэргэжилнэ.	3					
15	ВУ-45 маягыг олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	Радио станц	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-					
16	Тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	1-р үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2					
НИЙТ ХУГАЦАА						20					
						25					

— Сунгуу уруудмын өмнөх өртөөнд

Тайлбар: 25-аас дээш вагонтой үед тоормос турших хугацаа нэмсэн вагон бүрд 1,5 хүн/минут дээрх хугацаан дээр нэмэгдэж тооцогдоно.

Хүснэгт 23. Зорчигчийн галт тэрэгний тоормосын бүрэн туршилтыг гүйцэтгэх технологийн горим /Нэг вагон үзэгч/

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлээр	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)					
							5	10	15	20	25	30
1	Бүрэлдэхүүнд зүтгүүр холбоно.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-						
2	Бүрэлдэхүүний тоормосын сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3						
3	Сүүлийн вагонд манометр тавьж гол хоолойн даралтыг шалгана.	В.үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээж ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харах аюулвас сэрэмжилнэ. Богтошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад болон ажиллана.	1						
4	Төгсгөлийн кран нээж тоормосын гол хоолойн даралтыг 0 болгоно.	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолой биедээ наасны дараа хийх нээх ба мултарч, харах, цогихдох нүд нүүр рүү шороо тоос орохоос сэрэмжилнэ.	1						
5	Сүүлийн вагоны зөөлөн хоолойн толгойг тусгай сэртэнд байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохихоос болгоомжилно.							
6	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2						
7	Бүрэлдэхүүний сүлжээний нягтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	4						
8	Тоормос бариулах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгслээр өгнө. Энэ үед хальтйрч унах, бүдэрч тээглэх аюулвас сэрэмжилнэ.	-						
9	Бүрэлдэхүүний тоормосыг бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	-						
10	Зааврын дагуу хүлээнэ.	В.үзэгч	IV, V	-	-	2						
11	Бүрэлдэхүүний тоормосын барилт шалгана.	В.үзэгч	IV, V	-	Т3-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийж ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолон холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулвас сэрэмжилнэ.	2-5						
12	10 минутын барилттай тоормосын барилтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	Т3-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийж ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолон холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулвас сэрэмжилнэ.	10						
13	Бүрэлдэхүүний тоормосыг суллах дохио өгнө.	В.үзэгч	IV, V	-	-	-						
14	Бүрэлдэхүүний тоормосыг суллана.	ТЧМ	IV, V	-	-	-						
15	Бүрэлдэхүүний тоормосын суллалтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	Т3-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийж ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбэгийн хайрцаг, дохиолон холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулвас сэрэмжилнэ.	2-5						
16	Зүтгүүрт ирж тоормосын хангамжийг тооцон ТЧМ-д ВУ-45 маягт гардуулна.	В.үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3						
НИЙТ ХУГАЦАА							20-26					
							23-29					

10 ба 14 дэх үйлдлүүд нь

— Сунгуу уруудмын өмнөх өртөөнд
 ➔ 3 хүртэл вагонтой – 2 минут
 3-6 хүртэл вагонтой – 3 минут
 6-10 хүртэл вагонтой – 5 минут

3.7.5. Тоормосын товчилсон туршилт

3.7.5.1. Өртөөнд галт тэрэгний автомат тоормосыг бүрэн туршснаас хойш 20 минутаас дээш хугацаа өнгөрсөн, өртөөнд ирснээс хойш 20 минутаас дээш хугацаа өнгөрсөн галт тэргийг явахын өмнө товчилсон туршилтыг АТАЗ-ын 4.3.1-ийн “Г” заалтаар хийнэ. Уг галт тэрэг 2 цаг хүртэл хугацаагаар зогсвол зааврын дагуу 4 удаа хийх шаардлага гардаг тул дээрх үйлдлийг хялбарчлах үүднээс галт тэргийг явахын өмнө тоормосын сүлжээний нягтыг ТЧМ, вагон үзэгч нар хамтран шалгаж сүүлийн 2 вагоноор товчилсон туршилтыг гүйцэтгэж болно. Энэ үед тоормосын товчилсон туршилт хийх захирамжийг өртөөний жижүүр /ДСП/ өгнө.

3.7.5.2. Зорчигчийн галт тэрэгний вагоны тоормосын товчилсон туршилтыг АТАЗ-ын 4.3-д заагдсан тохиолдлуудад шалгана

Хүснэгт 24. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй үед тоормосын товчилсон туршилт гүйцэтгэх технологийн горим /Хоёр вагон үзэгч/

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэж/ зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)		
							5	10	15
1	Хийн сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	-				
2	Тоормосын сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ 1-р үзэгч	III, IV, V	-	-				
3	Тоормос бариулахыг мэдэгдэнэ.	1-р үзэгч	III, IV, V	-	-				
4	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харъяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3			
5	Тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	III, IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.				
6	Тоормос суллах дохио өгнө.	2-р үзэгч	III, IV, V	Гараар	-				
7	Тоормос суллана.	ТЧМ	-	-	-				
8	Тоормосын суллалтыг шалгаж ВУ-45 өгөх зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	III, IV, V	Радио станц	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, сэлбэгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжилнэ.	4			
9	ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж ТЧМ-д өгнө.	1-р үзэгч	III, IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1			
	НИЙТ ХУГАЦАА					8			

Хүснэгт 25. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнээс вагон салгасан үед тоормосын товчилсон туршилтыг гүйцэтгэх технологийн горим

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэж/ зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)		
							5	10	15
1	Галт тэрэгний тоормосын сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ	-	-	Галт тэрэгний зүтүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3			
2	Сүүлийн вагонд манометр тавьж шалган сэрээлт өгнө.	2-р үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэрэмжлнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад болон ажиллана.	1			
3	Сүүлийн вагоны зөөлөн хоолойн толгойг тусгай сэртэнд байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохиоос болгоомжилно.				
4	Галт тэрэгний тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1			
5	Тоормос бариулахыг ТЧМ-д мэдэгдэнэ.	1-р үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтйрч унах, бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлнэ.				
6	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.				
7	Зааврын дагуу хүлээнэ.	2-р үзэгч	IV, V	-	-	2			
8	Сүүлийн 2 вагоны тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлнэ.	1			
9	Тоормос суллах дохиог өгнө.	2-р үзэгч	IV, V	Гараар	-				
10	Тоормосыг суллана.	ТЧМ	-	-	-				
11	Тоормосын суллалтыг шалгаж ВУ-45 маягт олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлнэ.	1			
12	ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж ТЧМ-д өгнө.	1-р үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2			
	НИЙТ ХУГАЦАА					11			

Хүснэгт 26. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд вагон нэмсэн үед тоормосын товчилсон туршилт гүйцэтгэх технологийн горим /Хоёр вагон үзэгч/

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэж/ зэрэг	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)		
							5	10	15
1	Тоормосын сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ	-	-	Галт тэрэгний зүтүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3			
2	Галт тэрэгний сүүлд манометр тавьж шалгаад сэрээлт өгнө.	2-р үзэгч	III, IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харвах аюулаас сэрэмжлнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хаахад болон ажиллана.	1			
3	Сүүлийн вагоны зөөлөн хоолойн толгойг тусгай сэртэнд байрлуулна.	2-р үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эрхтэнээ цохиоос болгоомжилно.				
4	Тоормосын сүлжээг дахин цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1			
5	Тоормос бариулахыг мэдэгдэнэ.	1-р үзэгч	III, IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед хальтйрч унах, бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлнэ.				
6	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.				
7	Зааврын дагуу хүлээнэ.	-	-	-	-	2			
8	Нэмсэн вагоны тоормосын барилтыг шалгана.	2-р үзэгч	III, IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлнэ.	3			
9	Тоормос суллах дохио өгнө.	2-р үзэгч	III, IV, V	Гараар	-				
10	Тоормос суллана.	ТЧМ	-	-	-				
11	Тоормосын суллалтыг шалгаж ВУ-45 олгох зөвшөөрөл өгнө.	2-р үзэгч	III, IV, V	Радио станц	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бүдэрч тээглэх аюулаас сэрэмжлнэ.	3			
12	ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж ТЧМ-д өгнө.	1-р үзэгч	III, IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	2			
	НИЙТ ХУГАЦАА					15			

Хүснэгт 27. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй үед тоормосын товчилсон туршилт гүйцэтгэх технологийн горим /Нэг вагон үзэгч/

№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлээр	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)		
							5	10	15
1	Хийн сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	-				
2	Тоормосын сүлжээний нягтыг шалгана.	ТЧМ	-	-	-				
3	Тоормос бариулахыг мэдэгдэнэ.	В.үзэгч	III, IV, V	-	-				
4	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3			
5	Тоормосын барилтыг шалгана.	В.үзэгч	III, IV, V		ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.				
6	Тоормос суллах дохио өгнө.	В.үзэгч	III, IV, V	Гараар	-				
7	Тоормос суллана.	ТЧМ	-	-	-				
8	Тоормосын суллалтыг шалгана.	В.үзэгч	III, IV, V	Радио станц	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.	6			
9	Зүтгүүрт ирж ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж ТЧМ-д өгнө.	В.үзэгч	III, IV, V	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1			
	НИЙТ ХУГАЦАА					10			

Хүснэгт 28. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд вагон нэмсэн үед тоормосын товчилсон туршилт гүйцэтгэх технологийн горим /Нэг вагон үзэгч/


№	Хийгдэх ажилбар	Гүйцэтгэх ажилтан	Гүйцэтгэх ажилтны мэргэжлээр	Багаж хэрэгсэл	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Хугацаа (мин)	Хугацаа (мин)		
							5	10	15
1	Галт тэрэгний тоормосын хийн сүлжээг цэнэглэнэ.	ТЧМ	-	-	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3			
2	Сүүлийн вагонд манометр тавьж шалган сэрээлт өгнө.	В.үзэгч	IV, V	Манометр	Зөөлөн хоолой, манометрыг биедээ нааж байрлуулсны дараа краныг нээх ба даралтыг шалгах үед зөөлөн хоолой мултарч харах аюулаас сэргэжилнэ. Болгошгүй аюулын үед төгсгөлийн краныг хавхад багн ажиллана.	1			
3	Сүүлийн вагоны зөөлөн хоолойн толгойг тусгай сэрээнд байрлуулна.	В.үзэгч	IV, V	Гараар	Зөөлөн хоолойд эд эртнээс цохилоос болгоомжилно.				
4	Галт тэрэгний тоормосын сүлжээг дахин цэнэглэж, нягтыг шалгана.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	3			
5	Тоормос бариулах дохиог ТЧМ-д өгнө.	В.үзэгч	IV, V	-	Тоормос бариулах дохиог гар дохионы хэрэгсэлээр өгнө. Энэ үед халтйрч унах, бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.				
6	Тоормос бариулна.	ТЧМ	-	-	Харьяа байгууллагын аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.				
7	Зааврын дагуу хүлээнэ.	В.үзэгч	IV, V	-	-	2			
8	Сүүлийн 2 вагоны тоормосын барилтыг шалгана.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Өртөөний замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.	1			
9	Тоормос суллах дохиог өгнө.	В.үзэгч	IV, V	Гараар	-				
10	Тоормосыг суллана.	ТЧМ	-	-	-				
11	Тоормосын суллалтыг шалгаж зүтгүүрт ирнэ.	В.үзэгч	IV, V	-	ТЗ-ын зурвас газар зорчих, галт тэрэг, вагонд үзлэг засвар хийх ААЗ-ыг мөрдөнө. Замын голд байрлах ивүүр, салбгийн хайрцаг, дохиолол холбооны хэрэгсэлд бударч тээглэх аюулаас сэргэжилнэ.	4			
12	ВУ-45 маягтанд тэмдэглэл хийж ТЧМ-д өгнө.	В.үзэгч	IV, V	Тооны машин	Галт тэрэгний зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.	1			
	НИЙТ ХУГАЦАА					15			

ДӨРӨВ. САЛГАЛТТАЙ УРСГАЛ ЗАСВАР

- 4.1. Вагоны гэмтэл нь салгалтгүй урсгал засвар “УЗ”-аар засварлах боломжгүй нь “ТҮ” үзлэгээр тогтоогдсон, засварын ажлыг тусгай тоногдсон зам дээр шаардлагатай салгалттай урсгал засварыг хийж гүйцэтгэнэ.
- 4.2. Салгалттай урсгал засвараар вагон засварлагдах үед Замын даргын болон Вагон ашиглалтын депогийн даргын тогтоосон тушаал, журам, Замын ерөнхий инженер, Вагон ашиглалтын депогийн даргын баталсан технологи, технологи картуудыг мөрдөж ажиллана.
- 4.3. Салгалттай урсгал засварын газрууд нь батлагдсан орон нутгийн технологийн горимтой байна.
- 4.4. Вагон засварын ажлын технологийн горимын мөрдөлтөнд ТҮГ-ын дарга, мастер нар биечлэн хяналт тавих ба ажлын чанар, хэмжээг биечлэн шалгаж хүлээн авна.
- 4.5. Салгалттай урсгал засварын үеийн вагонуудын техникийн гэмтлийн бүртгэлийг хөтлөнө.

ТАВ. ГТХАБ-ТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

- 5.1. ГТХАБ-тай холбоотой асуудал үүссэн тохиолдолд доорх схемийн дагуу мэдээлэлийг хурдан шуурхай үнэн зөв дамжуулж ажиллана.



ЗУРГАА. АЧААНЫ ВАГОН ПАРКИЙГ ӨВӨЛ, ЗУНЫ ТЭЭВЭРТ БЭЛТГЭХ ҮЗЛЭГ ЗАСВАР

- 6.1. Жил бүр ачааны вагоныг зуны тээвэрлэлтэнд бэлтгэх эрүүлжүүлэх засварыг 4-р сард, өвлийн тээвэрлэлтэнд бэлтгэх засварыг 9-р сард тусгай хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ.

6.2. Замын даргын тогтоосон тушаал шийдвэрт тусгагдсан ачааны вагон паркийн бүх вагонуудад өвөл зуны тээвэрт бэлтгэх үзлэг, үйлчилгээ, засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

6.3. Тү-2 үзлэг засварын үед дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

6.3.1. Вагоны арал, тэвшинд хийх үзлэг, засварын ажлыг хийнэ.

6.3.1.1. Бүх төрлийн вагоны хаалга нээлхий, нугас, түгжээ, хамгаалах түгжээ, зэргийг засварлаж хаалга нээлхийг хэвийн болгоно. Шаардлагатай бол салгалттай урсгал засвараар засварлана.

6.3.1.2. Ноён нуруу, нугас төмрийн дамнуур, зангилаа хэсэг болон , тэдгээрийн хөндлөн, дагуу дамнуруу тоормосын эд анги байрлуулдаг суурь, тулгууруудад үзлэг хийж гэмтэлтэй бол салгалттай урсгал засвараар засварлана.

6.3.1.3. Тэвшний босоо шон, булангын шон, хөндлөн холбоос, эмжээрүүдэд үзлэг хийж гэмтэлтэй бол салгалттай урсгал засвараар засварлана.

6.3.1.4. Бүх төрлийн вагоны холбогчийн болон пүүлэгчийн шат бариулуудад үзлэг хийж дутууг нөхөж тавина, хугарсан тахийсан тохиолдолд тэгшилж засварлана.

6.3.2. Явах ангид хийх үзлэг, засварын ажлыг хийнэ.

6.3.2.1. Тэргэнцрийн нумын дээд дамнуур, хажуу арал, хос дугуйн хэсгүүд ашиглалтын үеийн шаардлага хангаж байгаа эсэх, ан цав, хэв гажилт, гулзайлт байгаа эсэхэд бага оврын гэрэлтүүлгээр нарийвчлан үзлэг хийнэ.

6.3.2.2. Хос дугуй бүрийн дэл болон мөөрийн зузааныг хэмжиж, техникийн зөрчилтэй хос дугуйг солих, дэлний зузааны зөрүүтэй хос дугуйг эргүүлэх ажлыг салгалттай урсгал засвараар гүйцэтгэнэ.

6.3.2.3. Өнхрөх холхивчтой гүүшинд үзлэг хийхдээ их биеийн арын хэсгийн тосыг хусаж цэвэрлэн АҮВТҮҮХЗ-н 3.3.3д заасны дагуу үзлэг хийнэ. Үзлэгээр гүүшингийн нягтруулах цагираг цухуйлттай, нягтруулах цагираг их биетэй жигд бус харьцаатай бол хос дугуйн гүүшингийн үзлэгийн тагыг эрх бүхий ажилтан авч үзлэг хийнэ.

6.3.2.4. Хажуугын гулсуурын зайг хэмжиж АҮВТҮҮХЗ-н 3.4.1д заасан зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй тохиолдолд ачаатай үед салгалттай урсгал засвараар тохируулна. Хоосон вагоны гулсуурын зай тохируулах ажлыг салгалтгүй урсгал засвараар гүйцэтгэж болно.

6.3.2.5. Нумын бүрдэл, үрэлтийн шаантагт үзлэг хийж гэмтэлтэй элэгдэлтэй эд ангиудыг солино.

6.3.3. Ачааны вагоны тоормосын төхөөрөмжинд дараах үзлэг засварын ажлыг хийнэ.

6.3.3.1. Бүх вагоны ажлаагүй тоормосыг сэргээж хэвийн болгоно.

6.3.3.2. Тоормосын хөшүүргэн дамжуулгад тохируулга хийхдээ “Ачааны вагоныг өвөл, өвлийн тээвэрлэлтэнд бэлтгэх үзлэг, засварын журам”-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

6.3.3.3. Тоормосын цилиндрийн шилбэний гаралтыг ширмэн шахавчаар тоноглогдсон бол 125мм-р хуванцар шахавчаар тоноглогдсон бол 50-80мм-р тохируулах ба авто тохируулагчгүй бол тоормосын цилиндрийн шилбэний гаралтын дээд хэмжээг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 20мм-р

багаар буюу 50-60мм-р тохируулна. Хоёр тоормосын цилиндрээр тохируулагдсан вагонуудын тоормосын цилиндрийн шилбэний гаралтыг кузов дээрх тэмдэглэлийн дагуу тохируулна.

6.3.3.4.Вагоны тоормосын агаар дамжуулах хоолойнууд болон бүх эд ангиудын бэхэлгээ нь зөв, бүрэн, чанга эсэх.

6.3.3.5.Бүх төрлийн даравч, дөр, түгжих эрэг зөв байрлуулсан эсэх.

6.3.3.6.Хөшүүргэн дамжуулгын босоо хөшүүргийн голонцор унахаас урьдчилан сэргийлж гагнаж байрлуулсан хоёр чих болон триангелын дүүжлүүрийн голонцор унахаас хамгаалагч хэрэгсэл бүрэн байгаа эсэх.

6.3.3.7.Тоормосын хийн сүлжээ сийгэлтгүй, нягт байгаа эсэхийг сонсголоор болон үзлэгийн явцад тодорхойлно. Эрээсгүй холболттой тоормосын эд ангийн холболтын хэсгээр сийгэлт гарсан тохиолдолд тоормосын гол хоолойноос салгахгүйгээр АҮВТҮҮХЗ-н 3.6.7д заасан хүчээр чангална.

6.3.4. Ниших татах байгууламжинд хийх үзлэг, үйлчилгээний ажил гүйцэтгнэ

6.3.4.1.Авто угсрааны их бие гадна талд үзлэг хийж, ан цавтай бол солино.

6.3.4.2.Авто угсраа найдвартай залгагддаг эсэхийг шалгаж, шардлагатай бол №873 загвараар шалгана.

6.3.4.3.Шингээх аппаратын их бие, татах хом, тулгуур булан, тулах хавтан, авто угсрааны шаантаг, тогтоох хавтан зэрэгт нарийвчлан үзлэг хийж тогтоох хавтангийн боолтуудыг чангалж дөрүүдийг гүйцээнэ.

6.3.4.4.Салгах хөшүүрэг, түүний тулгууруудын хэвийн ажиллагааг шалгаж, гинжний уртыг тохируулна.

6.3.4.5.Төвлөрүүлэгч, розетза, дүүжин боолтны элэгдэл, ан цавыг шалгаж, гэмтэлтэйг солино.

6.4. Тү-2 үзлэг засварын ажилд хяналт тавих, вагон хүлээн авах

6.4.1. ТҮГ-ын дарга нь нийт ТҮ-2 үзлэг засварт орсон нийт вагонуудын 50%-г заавал биечлэн хүлээж авна. Вагон хүлээн авах үед доголдол илэрсэн тохиодолд газар дээр нь арилгуулан дахин гаргахгүй байх арга хэмжээг авна. */Дагнасан хэрэглээний салбар замд, хоорондын замд ТҮ-2-ын ажлыг гүйцэтгэсэн үед үзлэг засварын ажлын чанарыг ахлаж буй ажилтан шалгаж хүлээн авна/*

6.4.2. Ачааны вагоны өвлийн тээвэрт бэлтгэх үзлэг засварын ажлын хугацаанд Вагон ашиглалтын депогийн дарга, ерөнхий инженер, хэсэглэл хариуцсан орлогч дарга, инженерүүд нь 80-аас доошгүй вагоны ТҮ-2 үзлэг засварын ажлын чанарыг шалгана.

6.4.3. Үзлэг, үйлчилгээ, засварын чанарыг шалгасан вагоны тэвшний зөвхөн А талын вагон үзэгчийн самбар дээр талууд нь 20 см урттай, гурвалжин дотор ТҮГ-ын дарга нар өөрийн ТҮГ-ын кодыг, ИТА, удирдах ажилтнууд гурвалжин дотор “З” үсгэн тэмдэглэгээг шохойгоор тавина.

ДОЛОО. СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН БУУРШГҮЙ НӨӨЦИЙГ ТОГТООХ, СЭЛБЭГИЙН ХАЙРЦАГ БАЙРЛУУЛАХ

7.1. Вагон ашиглалтын депогоос тогтоосон нормын дагуу ТҮГ, ТҮХ-ийн Вагон ашиглалтын депо түүний харъяа ТҮГ, ТҮХ-үүдийн хэмжээд байршуулах шаардлагатай сэлбэг материалын нөөцийг бүрдүүлсэн байна.

7.2. Сэлбэг багажийн хайрцгийг тухайн өртөөтэй зөвшилцсөний үндсэн дээр техник захирамжийн актад тусгасан зайд байрлуулна.

НАЙМ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ

8.1. ВАГОН АШИГЛАЛТЫН ДЕПОГИЙН НИЙТ АЖИЛТНУУДЫН ДАГАЖ МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Вагон ашиглалтын депогийн нийт ажилтан болон ажил олгогч нь МУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3-р бүлгийн 18-р зүйл “Ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон эрх, үүрэг”-ийг мөрдлөг болгон ажиллана.

1. Ажилтнууд нь ажилд ирэх буцахдаа хувийн аюулгүй байдлыг хангаж зорчиж аюулгүйн гарц, зам талбайг сонгон албан замналыг зурж, ТҮГ-ын даргаар хянуулан, депогийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженерт өгнө.
2. Албан замнал өөрчлөгдсөн тохиолдолд замналыг дахин зурж баталгаажуулна.
3. Ажил эхлэхийн өмнө уг ажлыг аюулгүй гүйцэтгэх арга ажиллагааны сургалт болох өдөр тутмын зааварчилгааг авч бүрэн ойлгосон гэдгээ өөрийн баталгаат гарын үсгээр баталгаажуулна.
4. Ажил олгогчоос олгосон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн, зөв хэрэглэж үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэл болон бусад бохирдлоос өөрийгөө хамгаална.
5. ТҮГ-ын орчинд зорчихдоо аюулгүй зам талбайг сонгож, үйлдвэрлэлийн ямар нэгэн хүчин зүйлийн үйлчлэлд өртөхөөс болгоомжилж, анхаарлаа бүрэн төвлөрүүлж явна.
6. Өөрийн ажлын байрны тодорхойлолтод зааснаас бусад төрлийн ажил үүргийг биелүүлэхдээ тухайн ажлыг хэрхэн аюулгүй гүйцэтгэх арга ажиллагааны ээлжит бус зааварчилгааг авч ажиллана.
7. Ажил амралтын дэглэм баримталж, хөдөлмөрийн чадвар бүрэн нөхөн сэргээгдсэн үед ажилд гарна.
8. Ажлын байрыг байнгын эмх цэгцтэй, цэвэр байлгаж, хөдөлмөрийн багаж хэрэгсэлтэй зөв харьцаж, гэмтэлгүй багаж хэрэгслээр ажил үүрэг гүйцэтгэнэ.
9. Ажлын байр түүний орчинд галын аюулгүй байдлыг хангах ба гал түймэр гарсан тохиолдолд нэн даруй унтраах арга барил, ур чадвар эзэмшинэ.
10. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан ажлын байранд ажиллах, уг шаардлагууд зөрчигдсөн тохиолдолд засаж арилгахыг ажил олгогчоос шаардаж зөрчлийг арилгасны дараа ажиллана.

Хориглох заалтууд:

1. Тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэх талаар сургалт зааварчилгаа аваагүй, ажлын байранд илэрсэн аюултай, хортой нөхцөл байдлыг арилгаагүй ажил гүйцэтгэхийг хориглоно.
2. Унтаж амраагүй /6-8 цаг/, архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн тохиолдолд ажлын байранд байх ба ажиллахыг хатуу хориглоно.
3. Удирдах албан тушаалтны зөвшөөрөл шийдвэргүй тоног төхөөрөмж дур мэдэн ажиллуулах болон цахилгаан цит, удирдлагын товчлуур (кноп) дарахыг хориглоно.
4. Тоног төхөөрөмжид тавьсан хаалт, хамгаалах, хориглох, анхааруулах плакат самбарыг ажил удирдагчийн шийдвэргүйгээр авахыг хориглоно.
5. Ажлын байруудаар сэлгүүцэх, анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байгаа ажилтны анхаарлыг өөр зүйлд хандуулахыг хориглоно.
6. Шалбарч гэмтсэн хүчдэлтэй утас (кабель) дээр гишгэх, хамгаалалтгүйгээр барих хүрэхийг хориглоно.
7. Тэсэрч дэлбэрэх, өөрөө гал авалцах бодис материалын ойролцоо (10 м-ээс дотогш) ил гал гаргахыг хориглоно.
8. Галт тэрэг, сэлгээний хөдлөх бүрэлдэхүүн, бусад хөдөлгөөнт машин механизмын хөдлөх чиглэлийн замд орж хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.
9. Зам төмөр дээр гишгэх, хөдөлж байгаа хөдлөх бүрэлдэхүүний өмнүүр өрсөж гарахыг оролдох, зүүгдэж явах, зогсоогүй байхад үсэрч буух зэрэг ямар нэг аюултай үйлдэл хийх, арга ажиллагааг хялбарчлах, технологи зөрчихийг хориглоно.
10. Цасан болон шороон шуургатай, манан будантай, шөнийн харанхуй зэрэг үзэгдэлт муутай орчинд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй буюу аюултай ажлын байранд чихээ тагласан, нүүр, нүдээ битүүмжилсэн, анхаарлаа өөр зүйлд хандуулсан байдлаар зорчихыг хориглоно.
11. Өндөрт ажил үүрэг гүйцэтгэхдээ зориулалтын бус шат тавцан ашиглах, гартаа ямар нэгэн зүйл барьж явах, өндөрт ажиллаж байгаа хүнд багаж хэрэгслийг шидэж өгөхийг хориглоно.
12. Ажлын байрнаас бусад газар ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
13. Ажлын байранд ноцолдох, чихэвчний хөгжим хэрэглэх, аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг санаатай буюу санамсаргүйгээр зөрчихийг хатуу хориглоно.

8.2. ӨРТӨӨНИЙ ЗАМ ПАРКАД АЖИЛЛАХ БА ЗОРЧИХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Төмөр замын аюултай бүсэд ажиллахдаа “Төмөр замын тээврийн тухай хууль”, “Төмөр замын техник ашиглалтын журам”, “Төмөр замын дохиоллын журам”, “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”, Замын даргын 2021 оны А-156 тоот тушаал “Зам дээр хүн” тушаалыг мөрдлөг болгон ажиллана.

1. Өртөөний зам паркаар зорчихдоо батлагдсан аюулгүйн замнал, тухайн өртөөний техник захирамжийн актыг баримтлан зорчино.
2. Замуудын дагуу зорчихдоо зэргэлдээ замуудын дунд, захын зам төмрөөс 2 м ба түүнээс багагүй зайд талбай чөлөөтэй эсэхийг магадлан зорчино.
3. Зэрэгцээ замуудаар галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн зэрэг явагдах үед тэдгээрийн хооронд байж таарвал хөдөлгөөн зогстол аль нэг талруу харан сууж хувийн аюулгүй байдлаа хангана.
4. Зам хөндлөн гарахдаа 90 градусаар эгц хөндлөн явж гарах ба зам төмөр дээр гишгэх, суухыг хатуу хориглоно. Замын голоор дэр модон дээгүүр гишгэж явахыг хориглоно.
5. Өртөөний зам дээр зогсож байгаа хөдлөх бүрэлдэхүүний аль нэг талаар тойрч гарахдаа авто угсрааны төгсгөлөөс 5 м ба түүнээс багагүй зайд тойрч гарна.
6. Нэг зам дээр салгаж тавьсан хөдлөх бүрэлдэхүүнүүдийн хооронд 10 м ба түүнээс багагүй зайтай үед дундуур нь эгц хөндлөн явж гарна.
7. Ойртон ирж байгаа хөдлөх бүрэлдэхүүний өмнүүр өрсөж гүйж гарахыг хориглох ба 800-1000 м-с илүү ойртсон үед явж өнгөртөл нь зогсож хүлээнэ.
8. Нэг зам дээр зогсож байгаа хөдлөх бүрэлдэхүүний төгсгөлөөр тойрч гарахдаа дараагийн буюу зэргэлдээ замаар хөдлөх бүрэлдэхүүн ирж байгаа эсэхийг заавал магадлан сонор сэрэмжтэй гарна.
9. Өртөөний зам парк буюу төмөр замын аюултай бүсэд ажил үүрэг гүйцэтгэж байхдаа сонор сэрэмжгүй байх, анхаарал сарниулсан байдалтай зорчих, өөр зүйлд анхаарлаа хандуулах, тонгойж явах зэргийг хориглоно.
10. Галт тэргэнд үзлэг засвар хийх үед заавал хаалт хамгаалалтанд авсан байх ба хамгаалалтанд аваагүй хөдлөх бүрэлдэхүүний доогуур шургахыг хориглоно.
11. Хамгаалалтанд аваагүй хөдлөх бүрэлдэхүүн доогуур шургахгүйн тулд зэргэлдээ замууд дээр дамжих тавцан бүхий вагон байвал түүнийг ашиглан дараагийн замруу гарч болно.
12. Дамжих тавцангаар гарахдаа шат, бариулын бүрэн бүтэн эсэхийг урьдчилан магадлан шалгах ба гартаа юм барьсан байж болохгүй. Гарахдаа вагонруугаа харж гарах ба буухдаа ухарч бууна.
13. Өртөөний зам паркийн 2 талын төгсгөлөөр явахдаа суман шилжүүлгийн хөдөлгөөнтэй хэсгээс аль болох холуур тойрч, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнөөс болгоомжлон явна.
14. Өртөөний зам паркад зорчих, ажил үүрэг гүйцэтгэж байхдаа гар утсаар ярих, чихэвч хэрэглэхийг хатуу хориглох ба үзэгдэлт бууруулсан нүдний шил зүүх, сонсгол бууруулж чихээ дарсан малгай ороолт зүүх зэргийг хориглоно.
15. Өртөөний зам паркын оворгүй хэсгээр явахдаа хувийн аюулгүй байдлаа хангаж сонор сэрэмжтэй явахаас гадна өртөөний жижүүрийн чанга яригчаар хэлж ярьж байгаа зүйлийг сайтар сонсож, шаардлагатай бол нэн дариу хариу өгч ажиллана.
16. Хүчтэй салхи шуургатай, цасан болон шороон шуургатай, аянга цахилгаантай ширүүн бороотой үед вагоны дээвэр дээр гарч үзлэг хийхийг хориглоно.
17. Зам төмөр, модон болон бетонон дэр нь аль ч улиралд тогтмол халтиргаатай байдаг тул түүн дээгүүр гишгэж явахыг хориглоно.

18. Өртөөний зам паркийн захаар ухсан нүх, овоолсон шороо, их хэмжээний зэрлэг ургамал ургасан байдаг тул сонор сэрэмжтэй яв.

8.3. ГАЛТ ТЭРЭГНИЙ ЗҮТГҮҮРТ СУУХ, ЗҮТГҮҮРЭЭС БУУХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Галт тэрэгний автомат тоормосыг турших үед зүтгүүрт орох, зүтгүүрээс буухдаа дараах аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллана. Үүнд :

1. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн, зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.
2. Галт тэрэгний зүтгүүрлүү авирч гарахдаа гартаа алх, гэрэлтүүлгийн хэрэгсэл, радио станц зэрэг ямар нэгэн эд зүйлс барьсан байхыг хориглоно.
3. Зүтгүүрлүү авирах үедээ багаж хэрэгслээ зэргэлдээ замын бүрэлдэхүүн, зүтгүүрийн шат, хамагч, зүтгүүрийн тэргэнцэр зэрэг дээр тавихыг хориглоно.
4. Зүтгүүрийн шатаар авирахын өмнө шатны бариулаас сайтар нягт атган барьсны дараа эхний гишгүүр дээр хөлөө тавьж халтирхааргүй гишгэж дээш авирах үйлдлийг хийнэ.
5. Зүтгүүрийн хаалга хаалттай байвал нэг гараараа шатны бариулаас сайтар нягт барьж, нөгөө гараараа хаалганы бариулыг доош дарж хаалгыг түлхэж нээнэ. Хаалгыг гүйцэд нээсний дараа 2 гараараа шатны бариулаас барьж зүтгүүрлүү орно.
6. Зүтгүүрт орохдоо шалан дээр асгарсан ус, тос зэрэг дээр гишгэж халтирч унахаас болгоомжилно.
7. Зүтгүүрээс буухдаа биеэрээ зүтгүүрлүү харж шатны хоёр талын бариулаас хоёр гараараа нягт барин ухарч бууна.
8. Зүтгүүрийн шатны эхний гишгүүр дээр лав гишгэсний дараа доош аажмаар буухдаа дараагийн шатны гишгүүрүүд дээр баттай гишгэн яаралгүй тайван доош бууна.
9. Зүтгүүрийн хамгийн доод шатан дээр очсоны дараа буух орчноо сайтар магадлан харж, чөлөөтэй аюулгүй газарт үсрэхгүйгээр зөөлөн бууна.

8.4. ГАЛТ ТЭРЭГ БОЛОН ВАГОНД ҮЗЛЭГ ЗАСВАР ХИЙХ ҮЕИЙН АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

1. Галт тэргэнд техникийн үйлчилгээ хийх, гэмтэлтэй вагоныг бүрэлдэхүүнээс салгахгүйгээр засварлахад өртөөний жижүүрийн зүгээс тухайн замаас хөдлөх бүрэлдэхүүн гарах, уг замруу оруулах замналын дохионуудыг нээх боломжгүй болгон хязгаарладаг дохиолол төвлөрүүлэлт холбооны байгууламжийг вагон үзэгч засварчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор өртөөдөд ашиглана.
2. Өртөөний замд техникийн үзлэг, үйлчилгээ хийгдэх, галт тэрэгний бүрэлдэхүүн найруулагдаж бэлэн болсны дараа /Сэлгээний ажил бүрэн дууссаны дараа/ өртөөний ДСП галт тэрэг зогсож байгаа замын сумыг уг замд өөр хөдлөх бүрэлдэхүүн орох боломжгүй байдалд тавьж тухайн замын товрууг улаан тагаар хамгаална.

3. Шөнийн ээлжинд ажиллах ажилтнууд гэрэлтэй газраас харанхуй орчинд шилжих үедээ нүд дасгах дасгал хийнэ.
4. Галт тэрэгний бүрэлдэхүүнд байгаа вагонуудын тоормосын тоноглолыг засварлахын өмнө таслах краныг хааж, ажлын болон нөөц савны хийг бүрэн суллана.
5. Галт тэргэнд хийх үзлэг засварыг технологийн дагуу шаардлагатай багаж, хэрэгсэл ашиглан биедээ ямар нэгэн гэмтэл авахаас болгоомжилж, болгоомжтой гүйцэтгэнэ.
6. Хөшүүргэн дамжуулганд тохируулга хийхдээ татуургын толгойн болон хөшүүргүүдийн нүхнүүдийн давхцалыг бордокны тусламжтайгаар хийнэ.
7. Вагон доогуур орж тоормосын тоноглолд засвар хийхдээ тоормосын цилиндрийн шилбэний толгойн харалдаа ойр байрлахыг хориглоно.
8. Бүрэлдэхүүний тоормосын гол хоолойг үлээлгэхдээ зөөлөн хоолойны толгойг биедээ шахаж найдвартай барина.
9. Зөөлөн хоолойг салгахдаа 2 вагоны төгсгөлийн краныг, тоормосын шахавч солихдоо таслах краныг тус тус хааж, засварын явцад гэнэт хий ирж, механизм ажиллагаанд орохоос хамгаална.
10. Авто угсраа, ниших татах төхөөрөмжинд засвар хийхдээ бүрэлдэхүүнийг 10 м-с багагүй зайд салгаж ивүүрээр бэхэлнэ.
11. Авто угсраа нь хүнд жинтэй, барьц муутай эд тул гараар өргөж зөөвөрлөх үед 4-с доошгүй хүн оролцоно.
12. Суурин хийн шугам ашиглан тоормос шалгахдаа зөөлөн хоолой мултарч, түүний толгойд цохигдохоос болгоомжлон бүрэн залга.
13. Хийн машин ажиллаж, хий гаргаж байгаа техник үйлчилгээний газруудад «даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм»-ийн хангаж ажиллана.
14. Урт эд ангиудыг зам паркаар гараар зөөвөрлөхдөө замуудын тэнхлэгийн дагуу шилжүүлнэ.
15. Галт тэрэгний техникийн үзлэг үйлчилгээ, тоормос турших ажиллагаа дууссаны дараа тухайн галт тэрэг бэлэн болсон мэдэгдлийг ДСП-д вагон үзэгч радио холбоогоор мэдэгдэж замын товруун дээрх улаан тагийг авхуулна.
16. Аюултай ачаа ачих зориулалт бүхий вагонд үзлэг засвар хийх үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдлөг болгон ажиллана.

8.5. ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

1. Тоормосын тохируулга хийх үеийн аюулгүй ажиллагаа

Тохируулга хийхийн өмнө таслах краныг хааж суллах хавхлагийг татажхийг бүрэн гаргана. Тохируулгыг нарийн үзүүртэй бордок, засварын алхыг ашиглан хийнэ. Бордокны нарийн үзүүрийг авах гэж байгаа голонцорын дөрний гогцоо-руу хийсний дараа бордок-руугаа алхаар зөөлөн тоншиж дөрийг сугалан авна. Ингэхдээ алхыг өөрийнхөө эсрэг чигтэй цохино. Дөрийг сугалан авсны дараа голонцорыг доороос нь алхаар цохиж сугалан авна. Хөшүүргийг зохих хэмжээгээр шилжүүлсний дараа хөшүүргүүдийн нүхний давхцалыг бордок

шургуулан тохируулсны дараа голонцорыг дээрээс нь хийж оруулна. Шайб тавьж, дөрийг голонцорын нүх рүү хийсний дараа алх бордокны тусламжтайгаар дөрийг тэнийлгэнэ. Вагон доор байж тохируулга хийх үедээ тоормосын цилиндрийн шилбэ талд байж болохгүй.

2. Шахавч солих үеийн аюулгүй ажиллагаа

Шахавчийг солихын өмнө таслах краныг хааж суллах хавхлагийг татаж хийг бүрэн гаргасан байна.тэргэнцрийн гадна байж шахавчийг солих бөгөөд зам төмөр дээр хөлөө тавих, гишгэж зогсохыг хориглоно. Тэргэнцрийн гадна талаас бордок эсвэл лоомыг оруулан шахавчийн шаантгийн толгойд тулган барьсны дараа лоом руугаа алхаар цохиж шаантгийг сугалан авна. Дараа нь лоомоо шахавч, шахавч баригч 2-ын завсраар оруулан хөшиж, шахавчийг шахавч баригчаас хөндийрүүлээд дээд талаас нь гараар татаж авах, эсвэл доош унагаана. Унагаах үедээ доор нь гараа тосох, доороос нь гараа оруулж барихыг хориглоно. Хуучин шахавчийг авсны дараа шинэ шахавчийг хийхдээ лоомоор шахавч баригчийг хос дугуйнаас хөндийрүүлж байгаад хос дугуйн дээд талаас шинэ шахавчийг аажим гулгуулан доошлуулж шахавч баригчид байрлуулсны дараа шаантгийг дээд талаас нь шахавч баригч, шахавчийн нүхнүүдийг давхцуулан хийнэ. Энэ ажиллагааны үед вагоны доорх эд ангиудад толгойгоо цохихоос болгоомжилно. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

3. Зөөлөн хоолой солих үеийн аюулгүй ажиллагаа

Зөөлөн хоолойг солихын өмнө тухайн вагоны болон зэргэлдээ вагоны таслах краныг хааж, 2 вагоны зөөлөн хоолойг хоорондуур нь салгасан байна. түлхүүр, газов ашиглан хуучин зөөлөн хоолойг тайлж авах ба шинээр тавих зөөлөн хоолойг вагонд угсарч, өнцгийг зөв тааруулан чангална. Сольж дууссаны дараа зөөлөн хоолойнуудыг холбож, төгсгөлийг крануудыг нээнэ. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

4. Агаар хуваарилагч солих үеийн аюулгүй ажиллагаа

Агаар хуваарилагчийг солихын өмнө таслах краныг хааж суллах хавхлагийг татаж хийг бүрэн гаргасан байна. Солих гэж байгаа агаар хуваарилагчийн боолтуудыг сөөлжүүлэн тайлж сулруулсны дараа агаар хуваарилагчийг ажлын камераас хөндийрүүлэн хөдөлгөж үлдэгдэл хийг гаргана. Дараа нь боолтуудыг гүйцэд тайлж агаар хуваарилагчийг салгаж авна. Ажлын камерын хөндий дэх тоос шороог арилгахын тулд таслах краныг багаар аажим нээж үлээлгэнэ. Ингэхдээ нүүрээ ажлын камерын нүхнээс хол байлгана. Үлээлгэж дууссаны дараа таслах кранаа буцаан хааж шинэ агаар хуваарилагчийг угсран, боолтуудыг чангална. Тэгээд таслах краныг нээнэ. Энэ ажилбарыг хийх үедээ тоормосын цилиндрийн шилбэ талд байж болохгүй. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

5. Авто дэглэм солих үеийн аюулгүй ажиллагаа

Таслах краныг хааж суллах хавхлагийг татан хийг бүрэн сулласны дараа ажлаа эхэлнэ. Авто дэглэмийн боолтуудыг суллан тайлсны дараа бэхлэх

хавтангаас авто дэглэмийг салгаж авна. Тэгээд шинэ авто дэглэмийг байрлуулна. Энэ үед авто дэглэмийг хөл дээрээ унагаахаас болгоомжилж сайн барьж байгаад боолтуудаар нь бэхэлнэ. Вагон доор байхдаа вагоны доорх эд ангиудад толгойгоо цохихоос болгоожилно. Сольж дууссаны дараа таслах краныг нээнэ. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

6. Авто тохируулагч солих үеийн аюулгүй ажиллагаа

Авто тохируулагч солих вагоны тоормосын таслах краныг хааж, суллах хавхлагийг татаж бүх нөөц хийг гаргана. Авто тохируулагчийн богино татуурга болон хэвтээ хөшүүрэгтэй холбогдсон голонцоруудын дөрийг авч голонцорыг дараалан сугалан авто тохируулагчийг салгаж авна. Салгаж авах үедээ өөр дээрээ унагаахаас болгоомжлон 2 гараар сайтар барьж авах ба вагоны хажууд гаргаж тавина. Шинээр тавих гэж байгаа авто тохируулагчийн ажиллагааг шалган үзэхдээ босоо байдалд дээд үзүүрээс нь сайтар барьсны дараа шалгана. Энэ үед эргэлдэж байгаа хэсэгт гар хуруугаа хүргэж болохгүй. Шинэ авто тохируулагчийг байрлуулахдаа эхлээд тохируулах шилбэний хэсгийг богино татуургатай холбож голонцорыг шургуулах бөгөөд энэ үед нөгөө үзүүрийг нь 2 дахь вагон үзэгч барьж байна. Үүний дараа нөгөө тал буюу их биеийн хэсгийг хэвтээ хөшүүрэгтэй холбож голонцорыг шургуулна. Дөр, шайбуудыг тавьсны дараа тохируулагчийг эргүүлэн тохируулна. Сольж дууссаны дараа таслах краныг нээнэ. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

7. Таслах кран солих үеийн аюулгүй ажиллагаа

Төгсгөлийн краныг хааж суллах хавхлагийг татан хийг бүрэн сулласны дараа ажлаа эхэлнэ. Вагон доор орж таслах краныг тайлахдаа байрлалаа зөв эзлэн суух ба вагоны доор байх эд ангиудад нүүр нүдээ цохихоос болгоомжилно. Таслах краныг тайлахдаа зориулалтын Түлхүүр, газовыг хэрэглэх ба хэт том түлхүүр ашиглан тайлах гэж оролдохыг хориглоно. Тайлж авсны дараа шинээр тавих краныг угсарна. Краныг хэт чангалж, эсвэл хэт сул эргэдэлгүй тохируулан чангална. Дараа нь төгсгөлийн краныг нээж, сийгэлт байгаа эсэхийг магадлан шалгана. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

8. Төгсгөлийн кран солих үеийн аюулгүй ажиллагаа

Төгсгөлийн кран солих вагоны кран солихгүй талын төгсгөлийн краныг хаана. Кран солих талын зэргэлдээ вагоны төгсгөлийн краныг мөн хааж хий ирэхээс таслана. Хэрвээ бүрэлдэхүүн зүтгүүртэй байгаа бол зүтгүүртэй тал буюу хий ирэх талын краныг эхэлж хаасны дараа нөгөө краныг хаана. Вагоны бүх хийг гаргасны дараа төгсгөлийн краныг тайлж эхэлнэ. Ингэхдээ тохирох дугаарын газов Түлхүүр ашиглаж тайлна. Хуучин төгсгөлийн краныг тайлж авсны дараа шинэ краныг угсарна. Ингэхдээ краны өнцгийг зөв тохируулан чангална. Энэ ажилбарыг хийхдээ зам төмөр дээр гишгэхийг хориглоно. Шинэ краныг угсарч дууссаны дараа эхлээд кран сольсон вагоныхоо хаалттай краныг нээнэ. Дараа нь кран сольсон талын зэргэлдээ вагоны төгсгөлийн краныг нээнэ. Хэрвээ бүрэлдэхүүн зүтгүүртэй бол зүтгүүргүй талын төгсгөлийн краныг эхэлж нээгээд

дараа нь хий ирэх талын краныг нээнэ. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

9. Авто угсрааны салгах хөшүүрэг солих үеийн аюулгүй ажиллагаа

Үзлэг засвар хийх гэж байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг хамгаалалтанд авна. Салгах хөшүүргийг авто угсрааны цоож өргөгчийн голонцортой холбосон боолтыг, мөн салгах хөшүүргийн бэхлэх тулгууруудыг вагоноос салган авна. Энэ үед зориулалтын түлхүүрийг ашиглах ба түлхүүр нь элэгдэл гэмтэлгүй, амны суналтгүй байна. Бэхлэх тулгуураас хөшүүргийг салгаж аваад шинэ салгах хөшүүргийг хийж вагонд хадах буюу боолтоор боох ажиллагааг хийнэ. Дээрх ажилбарыг хийхдээ зам төмөр дээр гишгэхийг хориглоно.

10. Дүүжин боолт солих үеийн аюулгүй ажиллагаа

Засварын ажлыг эхлэхийн өмнө тухайн бүрэлдэхүүнийг хамгаалалтанд заавал авна. Дүүжин боолтыг солихын өмнө тухайн вагоны хоорондуур 10м-с багагүй зайд салгасан байх салгасан хэсгүүд тус бүрийн хос дугуйн доор модон ивүүр тавьж бэхэлсэн байна. Дүүжин боолт солих авто угсрааг 2 хүн өргөх ба ганцаараа өргөхийг хориглоно. Зам төмөр дээр гишгэх, хөлөө тавихыг хориглоно. Авто угсрааг 2 талд нь зогсож байгаад нэгэн зэрэг өргөх ба энэ үед 3 дахь вагон үзэгч дүүжин боолтыг салган авч шинэ дүүжин боолтыг байрлуулна. Үүний дараа 2 үзэгч авто угсрааг зэрэг аажим буулгана. Засварын ажлаа дууссаны дараа модон ивүүрүүдийг авч хөдлөх бүрэлдэхүүнийг холбоно.

11. Авто угсрааны шаантаг солих үеийн аюулгүй ажиллагаа

Авто угсрааны шаантгийг солихын өмнө тухайн бүрэлдэхүүнийг хаалт хамгаалалтанд авна. Вагон доогуур орж ажиллахдаа вагоны доор байх эд анги, бэхэлгээнүүдэд толгойгоо цохихоос болгоомжлон ажиллана. Авто угсрааны шаантгийн бэхэлгээний 2 боолтыг 22-ын Түлхүүрээр тайлж авна. Хэмжээ таарахгүй түлхүүрээр ажиллахыг хориглоно. Шаантгийг авсны дараа шинэ шаантгийг авто угсрааны нүхрүү хийнэ. Дараа нь шаантгийн бэхэлгээг хийж 2 боолтыг бооно. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

12. Авто угсрааны механизмуудыг солих үеийн аюулгүй ажиллагаа

Авто угсрааны механизмуудыг солихын өмнө тухайн бүрэлдэхүүнийг хаалт хамгаалалтанд авах бөгөөд авто угсрааны механизмуудыг солих вагоны хоорондуур 10м-с ойргүй зайд салгаж салгасан хэсэг тус бүрд нь модон ивүүрээр ивж хөдөлгөөнгүй болгоно. Авто угсрааны механизмуудыг авахын өмнө авто угсрааны голонцорын чихнээс салгах хөшүүргийн гинжийг салгаж, дараа нь голонцорыг сугалж авна. Хэмжээ таарахгүй түлхүүрээр ажиллахыг хориглоно. Голонцорыг авсны дараа солих механизмаа гаргаж авах ба оронд нь шинэ механизмыг хийнэ. Авсан эд ангиа зориулалтын зөөврийн тэргэнцэр дээр, эсвэл газарт болгоомжтой буулгаж тавих ба хөл гар дээрээ алдахаас болгоомжилно. Шинээр сольж хийж байгаа механизмыг вагонд байрлуулахдаа гар хуруугаа хавчуулахаас болгоомжлон хийнэ. Механизмыг байрлуулсны дараа голонцорыг шургуулан, боолтуудыг хийж чангална. Мөн салгах хөшүүргийн гинжийг авто угсрааны голонцорын чихтэй холбоно. Ажлаа дууссаны дараа вагоны хос дугуй

доор тавьсан модон ивүүрүүдийг авч хөдлөх бүрэлдэхүүнийг холбоно. Вагоноос тайлж авсан эд ангийг парк дээрээс зөөж хураана.

13. Гулсавчийн зай тохируулах үеийн аюулгүй ажиллагаа

Засварын ажлыг эхлэхийн өмнө тухайн бүрэлдэхүүнийг хамгаалалтанд заавал авна. Гулсавчийн зай тохируулах гэж байгаа вагоны хос дугуйн доор 2 талд нь модон ивүүр тавьж хөдөлгөөнгүй болгоно. Зөөврийн домкратыг тохируулга хийх гэж байгаа тэргэнцэрийн дам нурууны дээр, вагоны кузовын тулгуурын доор 2 талд нь байрлуулна. Байрлуулахдаа ирмэгдүүлж тавихгүй бөгөөд өргөх үед домкрат мултрах, харвах зэргээс сэргийлэн найдвартай байрлуулна. Домкратын баталгаат хугацаа дуусаагүй, өргөх шингэн нь гоожиж асгараагүй хэвийн ажиллагаатай байх ёстой. Домкратны дээр 2-5см-н зузаантай модон жийргэвчийг тавина. Домкратуудыг нэгэн зэрэг ажиллуулан өргөж эхлэх ба хэрэгтэй өндөрт өргөсний дараа өргөлтөө зогсооно. Гулсавчийн хайрцгийн боолтыг тайлж авсны дараа тагийг авч хуудсуудыг хасах буюу нэмж тавина. Дараа нь тагийг тавьж боолтоор нь боосны дараа 2 талын домкратуудыг аажим буулгаж эхэлнэ. Гэнэт огцом буулгахыг хориглоно. Буулгаж дууссаны дараа домкратуудаа авч, хос дугуйн доор тавьсан модон ивүүрүүдийг авна.

14. Гүүшингийн үзлэгийн ба бэхлэх тагийг солих үеийн аюулгүй ажиллагаа

Засварын ажлыг эхлэхийн өмнө тухайн бүрэлдэхүүнийг хамгаалалтанд заавал авна. Хэрвээ тухайн бүрэлдэхүүн зүтгүүртэй бол зүтгүүрийн машинчид засвар хийх гэж байгааг радио холбоогоор болон биечлэн мэдэгдэж хөдлөхгүй байх талаар анхааруулна. Ажил эхлэхийн өмнө түлхүүр багажуудын бүрэн бүтэн эсэхийг шалгаж үзсэн байх ёстой.

8.6. ХИЙН СУУРИН ТӨХӨӨРӨМЖӨӨР БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТООРМОС ШАЛГАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Найруулагдан бэлэн болсон галт тэрэг болон бусад бүрэлдэхүүнд суурин хийн төхөөрөмжийг холбож тоормосын үзлэг засварыг зүтгүүр орохоос өмнө урьдчилан гүйцэтгэж бэлтгэнэ. Энэ үед тухайн бүрэлдэхүүнийг хаалт хамгаалалтад авсан байна. Бүрэлдэхүүний хийн сүлжээг холбох мэдэгдлийг ээлжийн ахлах үзэгч өгсний дараа хоёр талын авто үзэгч хамтран ажлыг эхэлнэ. Бүрэлдэхүүний дунд хэсгээр хийн суурин төхөөрөмжтэй холбох тул бүрэлдэхүүний хоёр талын вагоны зөөлөн хоолойг гурвалсан холбоосонд эхэлж холбосны дараа компрессорын хийн хоолойтой холбоно. Холболтын найдвартай эсэхийг заавал шалгаж үзсэний дараа краныг нээж бүрэлдэхүүний хийн сүлжээг цэнэглэнэ.

Вагоны төгсгөлд манометр байрлуулахдаа манометрийг вагоны зөөлөн хоолойд бүрэн зөв бэхэлсэн эсэхийг заавал шалгаж үзнэ. Тоормос турших ажиллагааг дууссаны дараа бүрэлдэхүүнийг хийн суурин төхөөрөмжөөс салгана. Энэ үед:

1. Хийн төхөөрөмжийн краныг эхэлж хаана.
2. Вагонуудын төгсгөлийн краныг хаана.

3. Хийн төхөөрөмжийн хоолойг гурвалсан холбоосноос салгана.
4. Гурвалсан холбоосыг вагонуудын зөөлөн холбоосноос салгана.
5. Вагонуудын зөөлөн холбооснуудыг хооронд нь холбож, төгсгөлийн крануудыг нээнэ.

Тоормос туших ажилбаруудыг хийж гүйцэтгэсний дараа хийн төхөөрөмжийн зөөлөн хоолой хурааж зориулалтын хайрцагт хийж, хайрцгийг түгжинэ. Суурин хийн төхөөрөмжөөр ажил гүйцэтгэхэд дараах зүйлүүдийг анхаар. Үүнд:

1. Хийн крантууд чөлөөтэй хаагдаж, нээгдэж байх ба зөөврийн байдлаар ашигладаг хий шугамуудын хаалт, хавхлаг нь шугамын төгсгөл дээр буюу хаах нээхэд гарт ойр байхаар тоноглогдсон байвал зохино.
2. Хий дамжуулах шугамууд тасрах, задрах, холболтууд мултрах зэрэг гэмтлээс шалтгаалан даралтат хийн хүчний нөлөөлөлд хүн өртөхөөс болгоомжилж, ашиглалтын үед үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээг хийх зэрэг арга хэмжээг урьдчилан авч байна.
3. Хийг өгөхийн өмнө эд анги бүрэн бэхлэгдсэн эсэхийг сайтар магадлах ба хийг чөлөөлөх үед эд анги мултарч үсрэхээс хамгаалах, үсэрч болзошгүй чиглэлд хүн байхыг хориглоно.
4. Ажил эхлэхийн өмнө хийн шугам холболтуудын бүрэн бүтэн байдал, даралтын хэмжээ урьдчилан шалгаж, гэмтлийг арилгасны дараа ажлыг гүйцэтгэнэ.
5. Даралттай хийгээр өмссөн хувцасаа цэвэрлэх, хүний бие рүү үлээлгэ хийх зэрэг технологийн бус үйлдэл хийхийг хатуу хориглоно.
6. Хий ашиглаагүй үед зөөврийн хийн шугамын төгсгөл хэсгийн хаалтыг найдвартай хааж түгжинэ.

8.7. ЦИСТЕРН ВАГОНД ҮЗЛЭГ ХИЙХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Газ болон нефтийн бүтээгдэхүүн зөөвөрлөх зориулалт бүхий цистерн вагонуудын тогоонд үзлэг хийх үед дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:

1. Үзлэг хийх бүрэлдэхүүн байрлах замыг хаалт хамгаалалтанд авсан байна.
2. Цисверн вагоны дээш шатаар авирч гарахын өмнө шатны бариул, гишгүүр бүрэн эсэхийг сайтар шалгаж магадлана.
3. Цистерн вагон дээр гарах, вагоноос буух үеийн аюулгүй ажиллагаа нь зүтгүүрт бууж, суух үеийн аюулгүй ажиллагааны зааврын нэгэн адил дагаж мөрдөнө.
4. Шатаар авирахдаа 2 гараараа барих ба гартаа ямар нэг зүйл барьсан байхыг хориглоно.
5. Цистерн вагон дээр гарсны дараа тавцан, түүний хашлага, бариулын бүрэн бүтэн байдлыг шалгаж, онцгой сонор сэрэмжтэй ажиллана.
6. Шатны гишгүүр мөс, ус тостой байвал гишгэхийн өмнө цэвэрлэн, халтирхаас болгоомжилно.

7. Вагон дээр гарч тогооны нээлхийг онгойлгохдоо бариулыг арчиж цэвэрлэн, барьц алдаж хүчний инерцээр савж унахаас болгоомжилж, бусад хөдөлгөөнгүй хэсгээс барина.
8. Тогооны нээлхийн хэсэг болон бусад газар тогтсон бодис материалын үлдэгдлийг үнэрлэх, биедээ хүргэхийг хориглоно.
9. Цистерны тогоон дотор орж ажиллахыг хориглоно.
10. Суллах хэрэгслийн клапанг хаахдаа гар хуруугаа хавчуулахаас болгоомжилно.
11. Ямар ч тохиолдолд ачааны үлдэгдэл нь галын аюултай учраас цистерн вагоны ойролцоо гагнуур хийх, тамхи татах, хос дугуйг точилдох зэргээр оч үсэргэх, ил гал гаргахыг хатуу хориглоно.
12. Угаалга, уталтанд ороогүй хийн тэсрэх аюултай цистерний тогоон дотор гэрэл гаргах зориулалтаар ил гал гаргах, 12 вольтоос их хүчдэлтэй зөөврийн гэрэл оруулахыг хориглоно.
13. Үзлэг дууссаны дараа шатны бариулаас барьж болгоомжтой буух ба үсэрч буухыг хориглоно.

8.8. АЧААНЫ ВАГОНЫГ ӨВӨЛ ЗУНЫ ТЭЭВЭРТ БЭЛТГЭХ ҮЗЛЭГ ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Ачааны вагоныг өвөл зуны тээвэрт бэлтгэх үзлэг засварын ажлын үед ээлжийн ахлах үзэгч болон засварын бригад бүрэлдэхүүнийг хамгаалалтад авах үед дараах зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:

1. Ажилд гарахын өмнө хариуцсан ТҮГ-ын дарга түүний эзгүйд албан ёсоор орлон ажиллаж байгаа ажил удирдагчдаас өдөр тутмын зааварчилгаа авч ажилд гарна.
2. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн зөв өмсөж хэрэглэнэ.
3. Засварын бригад ажиллах бүрэлдэхүүний замыг төвлөрсөн пульттэй тохиолдолд пультээр, пультгүй тохиолдолд зөөврийн улаан дохиогоор хаалт хамгаалалтанд авч ажиллана.
4. Засварын ажил гүйцэтгэх үедээ зэргэлдээ замын галт тэрэгний болон сэлгээний бүрэлдэхүүний хөдөлгөөнөөс болгоомжилж ажиллана.
5. Засварын ажил гүйцэтгэж байгаа ажилтны анхаарлыг сарниулж өөр зүйлд татах, өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд учруулахыг хориглоно.
6. Төвлөрсөн хамгаалалтаар тоноглогдсон зам дээр засварын ажил үүрэг гүйцэтгэх үед бригад ахлан ажиллаж буй вагон үзэгч үндсэн ээлжийн ахлах үзэгчид радио станцаар мэдэгдэж хамгаалалтанд бүрэн авсаны дараа засварын ажлыг эхлүүлнэ.
7. Төвлөрсөн хамгаалалтгүй зам дээр засварын ажил гүйцэтгэх тохиолдолд бригад ахлан ажиллаж буй вагон үзэгч үндсэн ээлжийн ахлах үзэгчээр дамжуулан өртөөний жижүүрээр улаан хуруувчаар хамгаалуулах бөгөөд нөгөө талаас зөөврийн улаан дохиог байрлуулж бүрэн хамгаалалтанд авсаны дараа засварын ажлыг эхлүүлнэ.

8. Зөөврийн улаан дохиог бүрэлдэхүүн байрлуулсан зам дээр тавих болон засварын ажил дууссаны дараа авах ажлыг засварын бригад ахлан ажиллаж байгаа ажилтан томилно.
9. Засварын бригад нь засварын ажил дууссан тохиолдолд замыг чөлөөлж хамгаалалт буулгах талаар ээлжийн ахлах үзэгч болон өртөөний жижүүрт мэдэгдэнэ.
10. Засварын ажил гүйцэтгэж эд анги солих үедээ УБТЗ-ын даргын А-24 технологи картыг мөрдлөг болгож ажиллана.
11. Засварын ажлын үед дур мэдэн ажил үүрэг гүйцэтгэх бригадын ахлахын зөвшөөрөлгүй даралтат хийтэй хоолойг салгах, залгах ажлыг хориглоно.
12. Салаа салбар замд очиж засварын ажил гүйцэтгэхдээ хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглох ба энэ талаар ажил удирдагчид мэдэгдэнэ.
13. Өвөл зуны тээвэрт бэлтгэх ажил үүрэг гүйцэтгэсэн ажлын хугацааг ээлжийн ажлын зурмагт ахлах үзэгч тэмдэглэж ажиллана.

8.9. ВАГОН ҮЗЭГЧ ДУУДЛАГААР АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

УБТЗ-ын 2021 оны А-605 тоот тушаал “Завсарын өртөөнд вагон үзэгч дуудлагаар ажиллуулах журам” болон өртөө зөрлөгт дуудлагаар вагон үзэгч ажиллах үед дараах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

1. Дуудлагаар ажиллах вагон үзэгч нь долоо хоногийн ажлын өдрүүдийн ажлын цагаар тухайн ТҮГ-ын дарга түүний эзгүйд албан ёсоор орлон ажиллаж байгаа ажилтнаас бусад тохиолдолд үндсэн ТҮГ-ын ээлжийн ахлах үзэгчээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчилгаа авна.
2. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгаа өгсөн болон авсан аль аль талдаа зааварчилгаа өгсөн цаг минутыг тодорхой тэмдэглэж гарын үсгээр баталгаажуулан бүртгэл хөтөлнө.
3. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн зөв өмсөж хэрэглэнэ.
4. Дуудлагаар вагон үзэгч ажиллуулах тохиолдолд 3-с доошгүй цагийн өмнө ажилтанд мэдэгдэх ба ажилтнуудын ажил амралтын дэглэмийг алдагдуулалгүйгээр зохицуулна.
5. Дуудлагын вагон үзэгчийн гэрэлтүүлэг, багаж хэрэгслийг шалгаж эвдрэл гэмтэлгүй бүрэн багажтай ажил үүрэг гүйцэтгэнэ. Дутуу тохиолдолд энэ тухай ажил удирдагчид мэдэгдэн нөхөн авна.
6. Завсарын өртөөнд дуудлагаар ажилласан вагон үзэгч нь “Хяналтын хуудас” буюу чеклестийг хөтлөж завсарын өртөөнд ажиллах үед хүндрэл гарсан тохиолдолд бичиж тэмдэглэнэ.
7. Дуудлагаар ажиллах үедээ өөрийн ажлын байрны тодорхойлолтонд заагдаагүй ажил үүрэг гүйцэтгэх, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зөрчих, технологи хялбарчлах зэргийг хориглоно.
8. Дуудлагаар хоорондын зам, завсарын өртөөнд ажиллах тохиолдолд хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглоно.

9. Дуудлагаар ажиллаж байгаа вагон үзэгч нь ТҮГ-ын дарга болон ээлжийн ахлах үзэгчтэй байнгын холбоотой ажиллах ба мэдээ илтгэл өгч ажиллана.

8.10. SA37A ЗАГВАРЫН КОМПРЕССОРЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

SA37A загварын компрессор ашиглах тохиолдолд дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:

1. Компрессор ашиглах, ажил үүрэг гүйцэтгэх ажилтан нь тусгай мэргэжлийн сургалтанд хамрагдаж шалгалт өгч тэнцсэн, мэргэжлийн үнэмлэхтэй ажилтныг томилон ажиллуулна.
2. Компрессор ашиглах, ажил үүрэг гүйцэтгэхийн өмнө ажил удирдагчаас зааварчилгаа авч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
3. Компрессор түүний цахилгааны щит нь бүрэн газардуулагдсан байх ёстой бөгөөд газардуулгыг зохих эрх бүхий байгууллагаар 6 сард 1 удаа шалгуулан баталгаажуулна.
4. Компрессорын аюулгүй ажиллагааг хангах зориулалт бүхий аваарын дохиолол болон блоклох төхөөрөмж нь бүрэн ажиллагаатай байх ёстой.
5. Компрессорыг ажиллаж байх үед түүний нээлхийг нээх, засвар үйлчилгээ хийх, нээлттэй үед нь ажиллуулахыг хориглоно.
6. Компрессорыг ажиллаж байх үед эзэнгүй орхихыг хориглоно.
7. Компрессорын аюулгүйн хавхалгыг ломбодсон байх ба тогтоосон хугацаанд шалгаж байвал зохино.
8. Компрессор дээр ажил үүрэг гүйцэтгэх үед гэмтэл илэрсэн тохиолдолд нэн даруй ажлаа зогсоож энэ тухай ажил удирдагчид мэдэгдэж шуурхай арга хэмжээг авна.
9. Компрессор ба түүний цахилгаан тоноглолд үзлэг үйлчилгээ хийх бол анхааруулах самбар, тэмдэг тавьсны дараа үзлэгийг эхэлнэ. Ажлаа дууссаны дараа самбар, тэмдгийг хураан авна.
10. Автомат залгуурын хайрцгийг нээлттэй орхих, түүн дээр багаж түлхүүр тавихыг хориглоно.
11. Компрессорын хяналтын болон бусад манометруудын лац ломбо бүрэн, заалт хэвийн, үечилсэн шалгалт хийгдэж баталгаажигдсан байх ёстой.
12. Компрессорын суурийн бэхэлгээний байдлыг тогтоосон хугацаанд шалгаж, тусгай дэвтэрт тэмдэглэл хийсэн байх шаардлагатай.
13. Компрессор дээр гадны хүн болон ажиллах эрхийн үнэмлэхгүй ажилтны ажиллуулахыг хориглоно.
14. Компрессорын тоос шороог цэвэрлэх, чийгтэй цэвэрлэгээ хийх нь үзлэг үйлчилгээ хийж буй нэг хэлбэр бөгөөд 7 хоногт нэг удаа тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийнэ.
15. Компрессорын дотор талыг цэвэрлэхдээ бензин болон түүнтэй адилтгах шатамхай шингэн хэрэглэхийг хориглоно.
16. Компрессорын засвар тохиргоог хийх үедээ зөвхөн гар удирдлагыг ашиглана.
17. Ажил дууссан тохиолдолд компрессорыг унтрааж, бүрэн бүтэн байдал, тосны түвшин зэргийг шалгаж, дараагийн ашиглалтад бэлтгэж үлдээнэ.

18.Ээлж дамжуулан хүлээлцэхдээ зөвхөн мэргэжлийн үнэмлэхтэй эрх бүхий ажилтнуудаар хүлээлцүүлнэ.

8.11. ДАРАЛТАТ ХИЙТЭЙ ХАРЬЦАЖ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

0.7 Мпа-аас дээш даралттай битүү сав, өндөр даралттай хий, шингэн зөөвөрлөх, хадгалах баллон, цистерн зэрэг даралтат сав төхөөрөмж нь ашиглалтын явцад дэлбэрэх, хүчтэй даралтанд цохигдох аюултай байдаг. Вагон ашиглалтын депогийн технологийн үйл ажиллагаанд 5.0-6.5 кг/см.кв хүртэл даралт бүхий хий ашиглах үед дараах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж хангаж ажиллана. Үүнд:

1. Даралтат хийтэй харьцаж ажил ажилтан нь тусгай мэргэжлийн сургалтанд хамрагдаж шалгалт өгч тэнцсэн, мэргэжлийн үнэмлэхтэй ажилтанг томилон ажиллуулна.
2. Даралтат хийтэй харьцаж ажил үүрэг гүйцэтгэхийн өмнө ажил удирдагчаас зааварчилгаа авч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
3. Хийн крантууд чөлөөтэй хаагдаж, нээгдэж байх ба зөөврийн байдлаар ашигладаг хийн шугамуудын хаалт, хавхлага нь шугамын төгсгөл дээр буюу хаах нээхэд гарт ойр байхаар тоноглогдсон байвал зохино.
4. Даралтат хийгээр үлээлэг, цэвэрлэгээ хийж байгаа үед үлээлт явагдаж байгаа чиглэлд хүн байхыг хориглоно.
5. Хийн дамжуулах шугамууд тасрах, задрах, холболтууд мултрах зэрэг гэмтлээс шалтгаалан даралтат хийн хүчний нөлөөлөлд хүн өртөхөөс болгоомжилж, ашиглалтын үед үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээг урьдчилан тооцож аюулгүй байдлыг хангаж ажиллана.
6. Хүчтэй үлээлтэнд доргио, дуу шуугиан үүсэх тул хамгаалах хэрэгслийг нормын дагуу бүрэн зөв хэрэглэнэ.
7. Үлээлэг хийх үед ус, тоос шороо, хөнгөн чанарын материал үсэрч болзошгүйг анхаарч нүдний шил, шаардлагатай гэж үзвэл нүүрний хаалт зүүнэ.
8. Хийг өгөхийн өмнө эд анги бүрэн бэхлэгдсэн эсэхийг магадлах ба хийг чөлөөлөх үед эд анги мултарч үсрэхээс хамгаалах, үсэрч болзошгүй чиглэлд хүн байлгахыг хориглоно.
9. Хийн крантыг алгуур болгоомжтой нээж хийг өгөх ба хийн шугамнаас барьсан үед гараас мултарч алдагдахааргүй найдвартай барина.
10. Ажил эхлэхийн өмнө хийн шугам холболтуудын бүрэн бүтэн байдал, даралтын хэмжээг урьдчилан шалгаж, гэмтлийг арилгасны дараа ажлыг эхэлнэ.
11. Даралттай хийгээр өмссөн хувцсаа цэвэрлэх, хүний бие рүү үлээлэг хийх зэрэг технологийн бус үйлдэл хийхийг хатуу хориглоно.
12. Даралтат хийтэй баллон савыг дулааны эх үүсвэрийн дэргэд байрлуулах, унаж болзошгүй байрлалаар тавих, таг штуцерийг гал авалцах, оч гаргах материалаар цохиж онгойлгох, таг амсраас нь тостой, гар болон бээлийгээр барихыг хориглоно.

13. Гэнэт хийн даралт үүсч болзошгүй хэсэгт орох, хуруу гараа хийх, ойртож харах зэрэг аюултай үйлдэл хийхийг хориглоно.
14. Хий ашиглаагүй үед зөөврийн шугамын төгсгөл хэсгийн хаалтыг найдвартай хааж, тусгай тавиурт бэхэлнэ.
15. Зөөлөн хоолойг ашиглан хийн шугамыг сунгасан тохиолдолд зөөлөн хоолойн толгойг мултрахаас хамгаална.
16. Хийн өргүүрийн ашиглалтын явцад гэнэт шугамын даралт буурч, өргөгч алдсанаас өргөж байсан зүйлд дарагдах, хавчигдахаас болгоомжил.
17. Хий ирэх шугамын хаалтыг хаалгүйгээр, даралтын манометрийн зүү "0" заасныг **“шугам хийгүй”** гэж үзэх боломжгүй гэдгийг байнга санаж ажиллавал зохино.

8.12. ГАР БАГАЖ АШИГЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Вагон ашиглалтын депогийн хэмжээнд салгалттай болон салгалтгүй урсгал засварын ажил гүйцэтгэх үед гар багаж ашиглахдаа дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

1. Засварын ажилд хэрэглэгдэх алх, бордок, лоом, отвертка, бахь, хуурай, цүүц зэрэг гар багажуудыг үндсэн зориулалтын дагуу ашиглах ба ажил эхлэхийн өмнө түүний бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтэлгүй эсэхийг шалгаж үзнэ.
2. Ажил гүйцэтгэхийн өмнө ажил удирдагчаас аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч ажил үүрэг гүйцэтгэнэ.
3. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн, зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.
4. Ажлын явц дунд гар багаж эвдэрч гэмтсэн эсэхийг сайтар магадалж тогтмол анхаарч ажиллана.
5. Алхны иш болон толгой сууж буй хэсэг нь цууралтгүй, хэв гажилтад ороогүй байх ба ямар нэгэн сул хөдөлгөөнтэй байхыг хориглоно
6. Алхны цохих гадаргуу болон ар тал нь гөлгөр гадаргуутай байх ба ан цав үүсээгүй, эмтрээгүй, шаваасгүй байна.
7. Бордок, цүүц зэрэг цохилтын гар багажнууд нь арын цохих гадаргуу нь товгор гөлгөр, ан цавгүй, эмтрэлт, ховхролтгүй байна.
8. Зубил нь зуйван эсвэл олон талт хэлбэрийн хөндлөн огтлолын хэлбэртэй байх ба сөртөс үүсэж засварчны гар хурууг холгох, зүсхээргүй байна.
9. Хадаас авагч, лоом, бордок зэрэг металл иштэй багажны ишний гадаргуу нь ажилтны гарыг холгохоогүй, сөртөнгүй байна.
10. Ажлын байранд батлагдсан стандартын дагуу гар багаж хэрэглэх, албан ёсны бүртгэлгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй гар хийцийн багаж хэрэгсэл ашиглахыг хориглоно.
11. Тухайн засвар үйлчилгээг гүйцэтгэхэд заагдаагүй, А-24 технологи картанд тусгагдаагүй багаж хэрэгсэл ашиглахыг хориглоно.
12. Тусгай гар багаж ашиглахдаа нэг бүрийн хамгаалах хэрэгслийг өмсөж ашиглана.

13. Ашиглалтын явцад гар багаж гэмтсэн ашиглахгүй боломжгүй болсон тохиолдолд ажил удирдагчид мэдэгдэн акталж, нөхөн авах ажлыг зохион байгуулна.
14. Гэмтэлтэй, стандартын шаардлага хангаагүй, ажлын явцад гүйцэтгэж буй ажилтанд ямар нэгэн эргономикийн хүндрэл учруулах багажаар ажил гүйцэтгэхийг хориглоно.
15. Тухайн ажлын байранд ажил гүйцэтгэхтэй холбоотой гар багаж хэрэгслийг өөрт ойр байлгах ба ажил эхлэхийн өмнө бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.
16. Гар багаж гэмтсэн тохиолдолд өөрөө бие даан засварлах, түр тогтоох арга хэмжээ авах, нуун дарагдуулах зэрэг эрсдэлтэй үйлдэл хийхийг хориглоно.
17. Ажил дууссан тохиолдолд гар багаж хэрэгслийг өөр хүнд дамжуулан ашиглах, хувийн шүүгээндээ хийж хадгалах, өөр ажлын байрлуу зөөхийг хориглоно.
18. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй, машин ажиллуулах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад ороогүй ажилтан машин ажиллуулах зэргийг хатуу хориглоно.
19. Ажил дууссан тохиолдолд гар багаж хэрэгслийг буцаан зориулалтын хайрцаг, сав шүүгээнд хийж байрлуулах ба ажлын байрыг цэгцэлж эмх цэгцийг хангана.

8.13. ШАТ БАРИУЛ ТЭГШЛЭГЧ АШИГЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Ачааны вагоны шат, бариулыг тэгшлэх засвар үйлчилгээ хийх тохиолдолд дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

1. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн, зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.
2. Шат, бариул тэгшлэх хэрэгслийг ашиглахын өмнө вагон үзэгч засварчин нь бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтлийг бүрэн магадалсны дараа ажил гүйцэтгэнэ.
3. Хэрэгслийг сэлбэг материалын шүүгээ эсвэл хананд хөдөлгөөнгүй, унахааргүй байрлуулж хадгална.
4. Хэрэгслийг зөвхөн хамгаалалтанд авсан бүрэлдэхүүнд байгаа вагоны шат бариулыг тэгшлэх эсвэл, салгалттай засварын зам дээр байгаа вагоны шат бариулыг тэгшлэх үед ашиглана.
5. Хэрэгслийг зөөвөрлөх үед босоо эсвэл хөдөлгөөний чиглэлийн дагуу хэвтээ байрлалаар батлагдсан аюулгүй зам талбайг сонгож зорчино.
6. Хэрэгслийг зөөвөрлөхдөө вагон доогуур шургахыг хориглох ба ДТХ-ын байгууламжийн хайрцаг, чулуунд цохигдож гарнаас мултрах, хөл гар дэр унах аюулаас сэрэмжилнэ.
7. Хэрэгслийн толгойн хэсгийн дэгээг вагоны бариулд тохируулан байрлуулж тэгшилнэ. Энэ үед дэгээний хэсэг бүрэн гогцоолдсон байх ба хөдөлгөөнт өнхрүүлэг нь вагоны хажуугийн хананд нягт шахсан байна. Дэгээг бариулд дутуу оруулах, хөдөлгөөнт хэсгийг вагоны тэвшинд хазгай шахаж тэгшлэхийг хориглоно.

8. Хэрэгслийг ашиглах үед гарнаас мултарч дээрээс унах зэргээс сэргийлж аюулгүй байдлаа бүрэн хангаж ажиллана.
9. Дээрээсээ нэг болон хоёр дахь эгнээний шатыг тэгшлэхдээ хэрэгслийн сүүл хэсэгт байрлах бариулыг залгаж уртасгах ба уртасгагч төмрийг бариулд бүрэн гүйцэт суугаагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.
10. Бариулд зориулалтын бус төмөр хийж уртасгахыг хориглоно.
11. Хэрэгслийг шат бариул тэгшлэхээс өр зориулалтаар ашиглахыг хориглоно.

8.14. СҮҮЛИЙН ВАГОНЫ ХАГАС ИЖ БҮРДЛИЙГ /СВХИБ/ ВАГОНД БАЙРЛУУЛАХ, ВАГОНООС АВАХ, ЗӨӨВӨРЛӨХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Сүүлийн вагоны хагас иж бүрдлийг /цаашид СВХИБ/ вагонд байрлуулах, вагоноос авах, өртөөний зам паркаар зөөвөрлөх үед дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:

1. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн, зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.
2. СВХИБ-ийг галт тэрэгний сүүлийн вагонд тавих ба авах технологитой танилцсан байна.
3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан ажилтан СВХИБ-ийг вагонд байрлуулж вагоноос авах, зөөвөрлөх ажлыг гүйцэтгэнэ.
4. СВХИБ-ийг вагоноос авах үедээ төхөөрөмжийн их биеийн бүрэн бүтэн байдал, эвдэрч, гэмтээгүй эсэхийг магадалж шалгаж үзнэ.
5. Хаалт хамгаалалтанд аваагүй галт тэрэгний сүүлийн вагонд төхөөрөмж байрлуулахыг хориглоно.
6. Зөөвөрлөх хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, гэмтэлгүй хэрэгсэл ашиглана.
7. СВХИБ-г вагонд байрлуулахдаа авто угсраан дээр алх, бордок, түлхүү зэрэг эд зүйл тавьж, хавчуулахыг хориглоно.
8. СХИБ-г вагонд байрлуулахдаа авто угсраанд найдвартай бэхлээхгүй үед орхиж явах, харгалзах ажилтангүйгээр холдохыг хориглоно.
9. Өртөөний зам паркаар зөөвөрлөхдөө СВХИБ-г вагон доогуур шургуулж дамжуулах, газар тавих зэргийг хориглоно.
10. Зөөвөрлөх өргөх явцад биеийн цээжний хэсгээс илүү өндөрт гаргаж өргөхийг хориглоно.
11. Шинээр ажилд орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа ажилтан, оюутан зэрэг ажлын туршлагагүй ажилтнаар бие даан СХИБ-г байруулах, зөөвөрлөхийг хориглоно.
12. Тавиур дээрээс СВХИБ-ийг авах болон тавихдаа унагах, гар хуруугаа хавчуулах, цохих зэргээс сээрэмжилж анхаарал болгоомжтой ажиллана.
13. СХИБ-ийг вагонд суурилуулахдаа гар хуруугаа хавчуулахаас болгоомжилж төхөөрөмжийн бариулаас сайтар барьж өргөнө.
14. Төхөөрөмжийг авах үед ямар нэгэн техникийн гэмтэл илэрсэн, их биед өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар ажил удирдагчид мэдэгдэн холбогдох арга хэмжээг авна.

15. Засвар үйлчилгээг дур мэдэн хийхийг хориглох ба ажил удирдагчид мэдэгдэн мэргэжлийн засварчинаар засварлуулна.
16. Албан замналын дагуу өртөөний зам паркад зорчих үеийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдлөг болгон ажиллана.
17. Зөөвөрлөх явцад өртөөний чанга яригчаар мэдээлж буй мэдээллийг сонсож анхаарал болгоомжтой зорчино.

8.15. ТӨМӨР ЗАМЫН АЮУЛТАЙ БҮСИЙН ДЭГЛЭМД АЖИЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Ажилтан нь төмөр замын аюултай бүсийн дэглэмд үүрэг гүйцэтгэх, постонд эргүүлээр ажиллах үедээ дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:

1. Төмөр замын аюултай бүсэд эргүүлээр ажиллахдаа өглөө 08:00-14:00, 14:00-20:00 цаг хүртэл хоёр ажилтан хоёр ээлжээр ажиллана.
2. Эргүүл хийх газар болох тухайн цэгээс хоёр тийш 200 метрийн зайд галт тэрэгний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж хариуцаж ажиллана.
3. Ажилтан нь тухайн постыг өөрийн ажлын байр гэж үзэн дээр заагдсан хугацаанд ГТХАБ-ыг чанд баримтлан ажиллана. Хэрэв хоцорч ирэх постыг орхин явах зэрэг бусад зөрчил гаргасан тохиолдолд ажлын байрны шаардлагатай ижил хэмжээгээр авч хариуцлага тооцно.
4. Постонд ажиллах ажилтан нь ТҮГ-ын байранд ирж ажил удирдагчаас зааварчилгаа авч гарын үсгээр баталгаажуулсан байна.
5. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн зөв, өмсөж ажиллана.
6. Постонд ажиллах ажилтанд зориулалтын дохионы хэрэгсэл /шар хантааз, рапортын дэвтрийг / ээлжийн ахлах үзэгч дээр байрлуулж хүлээлцэнэ.
7. Постонд ажиллах ажилтан нь үүрэг гүйцэтгэсэн талаарх мэдээллийг ВОХР диспетчер: 244080 утсанд тогтмол мэдээлэж ажиллана.
8. Ажилтан нь албан ажлын үнэмлэхээ биедээ авч ажиллана.
9. Постонд ирж буцахдаа батлагдсан аюулгүйн маршрутын дагуу зорчино.
10. Эргүүл хийх хугацаанд хэт халуун болон, усархаг борооноос урьдчилан сэргийлж хувийн бэлтгэлийг ханган эргүүлд гарна.
11. Эргүүл хийж байх хугацаанд галт тэрэгний хөдөлгөөнд саад учруулахгүй байх бүх арга хэмжээг авч шаардлагатай гэвэл холбогдох албан тушаалтанд мэдээлэл өгч ажиллана.

8.16. ЗӨӨВРИЙН ИМПАКТ АШИГЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Зөөврийн импакт ашиглан галт тэргэнд засвар үйлчилгээ хийх үедээ дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

1. Ажил удирдагчийн шийдвэрээр томилогдсон эрх бүхий ажилтнаар цахилгаан өрмөөр ажил гүйцэтгүүлнэ.

2. Ажил гүйцэтгэхийн өмнө ажил удирдагчаас аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч ажил үүрэг гүйцэтгэнэ.
3. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн, зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.
4. Зөөврийн импактыг ажиллуулахын өмнө багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, эвдрэл гэмтэл зэргийг бүрэн магадласны дараа ажлыг эхлүүлнэ.
5. Ажил гүйцэтгэж дууссаны дараа импактыг зориулалтын хайрцаг саванд хийж байрлуулна.
6. Импактыг зөвхөн хамгаалалтанд авсан бүрэлдэхүүнд болон салгалттай засварын зам дээр байгаа вагонд ашиглана.
7. Зөөврийн импактыг ажиллуулахын өмнө түүний хошууны элэгдэл, баттерей бүрэн байдал, ажиллагаа хэвийн эсэхийг нэг бүрчлэн шалгаж, импактыг хоосон ажиллуулж үзнэ.
8. Ажиллагааны явцад бэхэлгээ сулрах, толгой мултрах зэрэг эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд нэн даруй ажлыг зогсоож, гэмтлийг засуулах арга хэмжээ авна.
9. Импактны эргэлтэд ямар нэгэн зүйлийг санамсаргүй шүргүүлэхээс болгоомжилно.
10. Зөөврийн импактыг ашиглахдаа багажийг боолт гайканд нягт шахаж байрлуулах ба алгуур зөөлөн ажлуулна.
11. Ажлын дараа зөөврийн импактыг баттерейг салган, зориулалтын хайрцаг саванд хийж хадгална.

Хориглох нь:

1. Зөөврийн импактны эргэлтийг албадан зогсоох, гараар барихыг хориглоно.
2. Зөөврийн импактыг ямар нэгэн зүйлд цохих зориулалтын бусаар ашиглах зэргийг хориглоно.
3. Ажил удирдагчийн томилж, зөвшөөрөл олгосон ажилтнаас өөр ажилтан зөөврийн импактыг ажиллуулахыг хориглоно.
4. Зөөврийн импактыг ашиглаж байгаа детальд хэтэрхий хүчтэй шахах, эсвэл сул барьж алдах зэрэг хайхрамжгүй аюултай үйлдэл хийж, анхаарал болгоомжгүй ажиллахыг хориглоно.
5. Зөөврийн импактыг асаалттай байдлаар эзэнгүй орхих, хүнд дамжуулах бариулахыг хориглоно.